

НУУЦ

ИЛ БОЛСОН

БАТЛАВ


БАТЛАВ

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ"-ЫН ДАРГА

Р.БАТСҮХ

Д.ЖИГЖИДНЯМАА



ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД БҮТЭЦ, ДОХИОЛОЛ
ТӨВЛӨРҮҮЛЭЛТ ХОРИГЛОЛ БА ХОЛБООНЫ СИСТЕМ, ЭРЧИМ ХҮЧ, ГҮҮРИЙН
БАРИЛГЫН АЖИЛ, ЗУРАГ ТӨСӨЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

ОГ/20/042/ АНТ-20/21-20/06

Энэхүү гэрээг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д заасан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл (цаашид "Төсөл" гэх)-ийн хүрээнд Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох зорилгоор, Монгол Улсын Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газрын 2012 оны 121, 2013 оны 28, 2019 оны 135 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 10 дугаар сарын 10-ны өдрийн 12, 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар худалдааны шийдвэр, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 44, 53 дугаар тушаал, Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаал, 2019 оны 01/6383 дугаартай "Чиглэл өгөх тухай" албан бичиг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсгийн 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 83 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн,

нэг талаас, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол /14230 Нарны зам-62/ Юнион бюлдинг А блок 7 давхарт байрлах, улсын бүртгэлийн 9012001025, регистрийн 5214203 дугаартай "Монголын төмөр зам" ТӨХК (цаашид "Захиалагч" гэнэ);

нөгөө талаас, Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Сөүлийн гудамж-42, өөрийн байранд байрлах Монгол-Оросын Хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам" (цаашид "Гүйцэтгэгч" гэнэ), (Захиалагч болон Гүйцэтгэгчийг дангаар нь "Тал", хамтад нь "Талууд" гэнэ)

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн км дэлгэмэл урттай төмөр замын дээд бүтцийг угсрах, Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны систем, эрчим хүч, гүүрийн барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэхээр дараах нөхцлийг харилцан тохиролцож, 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1.1. "Ажил" гэж Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн км дэлгэмэл урттай төмөр замын дээд бүтэц (гол зам, суман шилжүүлэг, зам төмөр, уулзварын ба завсрын бэхэлгээ, зам төмрийн суурь /дэр, дүнз, гулдангууд/, чигжээсний үе, балласт, хориг хашаа), Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны систем болон эрчим хүч, шилэн кабель, өртөө зөрлөгийн зам, гүүр барьж байгуулах, зураг төсөл боловсруулахыг хэлнэ.

1.2. "Эрх барих байгууллага" гэж Захиалагч буюу "МТЗ" ТӨХК-ийн хувьд "МТЗ" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг, Гүйцэтгэгч буюу "УБТЗ" ХНН-ийн хувьд "УБТЗ" ХНН-ийн Ерөнхий хороог хэлнэ.

ИЛ БОЛСОН

1.3. "Гэрээний үнэ" гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу Гүйцэтгэгчид төлөх төлбөрийг хэлнэ.

1.4. "Гэрээний хугацаа" гэж гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс дуусгавар болох өдрийг хэлнэ.

1.5. "Худалдан авалт" гэж энэхүү гэрээний 1.1-д заасан ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой бараа, ажил, үйлчилгээг Гүйцэтгэгч хариуцан нийлүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ИЖ БҮРДЭЛ

- 2.1. Дараах баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:
 - 2.1.1. Хавсралт -1 (Үндэслэлд дурдсан тогтоол, шийдвэр, албан бичгийн хуулбар);
 - 2.1.2. Хавсралт -2 (Гэрээний ерөнхий нөхцөл);
 - 2.1.3. Хавсралт 3-13 (Гэрээний тусгай нөхцөл)

2.1.3.1. Хавсралт -3 (Багц ажил);

- а. Төмөр замын дээд бүтцийн ажил;
- б. Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны систем, шилэн кабелийн ажил;
- в. Эрчим хүч, өртөө зөрлөгийн гэрэлтүүлгийн ажил;
- г. Гүүрийн барилга угсралтын ажил;
- д. Хориг хашаа;
- е. Зураг төсөл, төсөв боловсруулах ажил;
- ё. Захиргаа, удирдлагын зардал.

/Жич: Ажлын даалгавар, техникийн нөхцөл, техникийн шаардлага, ажлын зураг, төсөвт өртөг, ажлын төлөвлөгөө, ажил гүйцэтгэх аргачлал, магадлалын ерөнхий дүгнэлт зэргийг багтаасан байх/

- 2.1.3.2. Хавсралт- 4 (Багц ажлын нэгдсэн календарчилсан төлөвлөгөө);
- 2.1.3.3. Хавсралт- 5 (Ажил дуусгавар болох үед хийгдэх шалгалт);
- 2.1.3.4. Хавсралт -6 (Төлбөрийн нөхцөл болон төсөвт өртөг);
- 2.1.3.5. Хавсралт -7 (Даатгал);
- 2.1.3.6. Хавсралт -8 (Зөвшөөрлүүд);
- 2.1.3.7. Хавсралт -9 (Төслийн баримт бичгүүд);
- 2.1.3.8. Хавсралт -10 (Талуудын ажилтнуудын нэр, албан тушаалын жагсаалт);
- 2.1.3.9. Хавсралт -11 (Техникийн зөвлөх);
- 2.1.3.10. Хавсралт -12 (Байгаль орчны менежментийн төлөвлөгөө);
- 2.1.3.11. Хавсралт -13 (Төсөл хэрэгжүүлэх талбай).

ГУРАВ. ҮНДСЭН ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн км дэлгэмэл урттай төмөр замын дээд бүтэц (гол зам, суман шилжүүлэг, битүү оглололцол, зам төмөр, уулзварын ба завсрын бэхэлгээ, зам төмрийн суурь /дэр, дүнз, гулдангууд/, чигжээсний үе, балласт, хориг хашаа), Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны систем болон эрчим хүч, шилэн кабель, өртөө зөрлөгийн зам, гүүр барьж байгуулах, зураг төсөл боловсруулах, Захиалагч гэрээгээр тохиролцсон хөлсийг саадгүй төлөх үүргийг тус тус хүлээнэ.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

4.1 Талуудыг төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2 Энэхүү гэрээний 2.1.3-т заасан хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд талууд баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

ХТ

ХТ

ХТ

ИЛ БОЛСОН

4-
НУУЦ

ТАВ. ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХ

5.1. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээ, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана.

ТАЛУУД ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ ҮҮГЭЭР БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА


СУУРЬ БҮТЭЦ ХАРИУЦСАН ЗАМЫН
ОРЛОГЧ ДАРГА


 Д.НЯМЛХАГВА

 БЕЛОШ К.Р

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ЗАМЫН ОРЛОГЧ ДАРГА

 Д.ДАВААДОРЖ

 УСОЛЬЦЕВА С.Я

ТӨСӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

 Б.БАТЦЭНГЭЛ


ЗАМЫН АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА

 Ю.НЯМЖАРГАЛ


ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА

ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ОРЛОГЧ
ДАРГА

 Р.БЯМБАА

 Д.МИНЖМАА
4/04/2020

4/04/2020



ИЛ БОЛСОН

НУУЦ

ХАВСРАЛТ -1
ОГ /20/042

2020-02-15

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ БОЛСОН ТОГТООЛ, ШИЙДВЭР,
АЛБАН БИЧГИЙН ХУУЛБАР

Эгэхүү гэрээ нь төрийн болон албаны нутагд хаммагжих нэг өөр бусад этгээдэд хувилжж тархах, нийтийн зүртээл дагдохыг хориглоно. Үл шаардлагыг биелүүлэхгүй гэнэвэл этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

"МТЗ" ТӨХК

"УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

АГУУЛГА

НУУ

1. НЭР ТОМЬЕОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1. Тодорхойлолт
- 1.2. Албан харилцаа
- 1.3. Хэрэглэх хууль ба хэл
- 1.4. Гэрээний эрх, үүрэг шилжүүлэлт
- 1.5. Баримт бичгийг хадгалах, хамгаалах
- 1.6. Нууцлал
- 1.7. Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч ашиглах
- 1.8. Захиалагчийн баримт бичгийг Гүйцэтгэгч ашиглах
- 1.9. Гэрээг дагаж мөрдөх
- 1.10. Ажилд шаардагдах зөвшөөрөл
- 1.11. Төслийн баримт бичиг
- 1.12. Өмнөх ажил
- 1.13. Нэмэлт, өөрчлөлт
- 1.14. Гэрээний зарим заалт хүчин төгөлдөр бус болох
- 1.15. Гэрээний хувь ба бүрдэл хэсэг

2. ЗАХИАЛАГЧ

- 2.1. Ажлын талбайд нэвтрэх эрх
- 2.2. Захиалагчийн ажилтан
- 2.3. Захиалагчийн санхүүжилт
- 2.4. Захиалагчийн нэхэмжлэл
- 2.5. Барьж байгуулах ажилд үзүүлэх туслалцаа, урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх

3. ЗӨЛӨХ-ХЯНАЛТЫН БАГ



- 3.1. Зөвлөх-хяналтын баг
- 3.2. Шийдвэр

4. ГҮЙЦЭТГЭГЧ

- 4.1. Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг
- 4.2. Гүйцэтгэгчийн баталгаа
- 4.3. Техникийн зөвлөх
- 4.4. Гуравдагч этгээдээр ажил гүйцэтгүүлэх
- 4.5. Хамтын ажиллагаа
- 4.6. Ажлаа тодорхойлох
- 4.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин болон орон нутгийн харилцаа
- 4.8. Чанарын баталгаа
- 4.9. Ажлын талбайтай холбоотой мэдээлэл
- 4.10. Гэрээний үнэ болон ажил дуусгах хугацааны хангалттай байдал
- 4.11. Урьдчилан харах боломжгүй хүндрэл
- 4.12. Бусдын газар, байгууламжид нэвтрэх эрх
- 4.13. Хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх
- 4.14. Технологийн болон түр зам ашиглах
- 4.15. Бараа материалын тээвэрлэлт
- 4.16. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж
- 4.17. Байгаль орчныг хамгаалах
- 4.18. Цахилгаан, ус болон хий
- 4.19. Ажлын явцын тайлан
- 4.20. Ажлын талбайн харуул хамгаалалт

Энэхүү гэрээ нь торчин болон албаны нууцад хамрагдах тул өөр бүхэд этгээдэд хувилж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглана. Энэ шаардлагыг биелүүлэхгүй илгэвэл этгээдэд хуульд заасны дагуу харилцаагаа хүтээгч болно.

"МТЗ" ТӨХК "УБТЗ" ХНН



- 4.21. Ажлын талбай дахь Гүйцэтгэчийн үйл ажиллагаа
- 4.22. Археологийн олдвор
- 4.23. Ажлын талбайн газрын нөхцөл

5. ЗУРАГ ТӨСӨЛ

- 5.1. Ерөнхий зураг төслийн үүрэг
- 5.2. Гүйцэтгэчийн баримт бичиг
- 5.3. Гүйцэтгэчийн амлалт
- 5.4. Техникийн стандарт болон журам
- 5.5. Гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн талаарх баримт бичиг
- 5.6. Ашиглалт үйлчилгээний зааварчиглаа
- 5.7. Зураг төслийн алдаа

6. АЖИЛТАН БА АЖИЛЛАХ ХҮЧ

- 6.1. Ажилтан болон ажиллах хүч элсүүлэх
- 6.2. Захиалагчид ажиллах хүмүүс
- 6.3. Ажилтны ахуй хангамж
- 6.4. Эрүүл мэнд, аюулгүй байдал
- 6.5. Ажилтныг ажиллах нөхцөлөөр хангах
- 6.6. Гүйцэтгэчийн ажилчид
- 6.7. Гүйцэтгэчийн ажилчид болон тоног төхөөрөмжийн бүртгэл
- 6.8. Ёс зүйгүй үйлдэл

7. МАТЕРИАЛ БОЛОН АЖЛЫН УР ЧАДВАР

- 7.1. Гүйцэтгэх байдал
- 7.2. Сорьц болон дээж
- 7.3. Үзлэг шалгалт
- 7.4. Тохируулга, зүгшрүүлэг
- 7.5. Үзлэг, тохируулга, зүгшрүүлгийн үр дүнг хүлээн авахаас татгалзах
- 7.6. Засаж залруулах ажил
- 7.7. Материалын ба эд хөрөнгийн өмчлөл
- 7.8. Орон нутгийн хураамж
- 7.9. Барьцаалах
- 7.10. Гүйцэтгэчийн тоног төхөөрөмж
- 7.11. Аюултай материал

8. АЖИЛ ЭХЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, ХОЙШЛУУЛАХ, ТҮР ЗОГСООХ

- 8.1. Ажил эхлэх
- 8.2. Урьдчилан байдлаар хүлээн авах хугацаа
- 8.3. Төлөвлөлт болон ажлын хуваарь
- 8.4. Хугацаа сунгах
- 8.5. Ажил түр зогсоох
- 8.6. Түр зогсоолтын үр дагавар
- 8.7. Түр зогсоолтын үеийн материалын төлбөр
- 8.8. Түр зогсоолтын хугацааны сунгалт
- 8.9. Ажлаа үргэлжүүлэх

9. АЖИЛ ДУУСАХ ҮЕД ХИЙХ ТОХИРУУЛГА, ЗҮГШРҮҮЛЭЛТ

- 9.1. Ажил дуусах үеийн зүгшрүүлэлт
- 9.2. Захиалагч оролцож чадахгүй байх
- 9.3. Дахин зүгшрүүлэг хийлгэх

10. УРЬДЧИЛСАН БАЙДЛААР ХҮЛЭЭН АВАХ

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарна тул оор бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээгээх болно.
 МТЗ ТӨХК "УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

НУУ

- 10.1. Урьдчилсан байдлаар хүлээн авсан тухай гэрчилгээ
- 10.2. Урьдчилсан байдлаар хүлээн авсны дараа Гүйцэтгэгчийн хандалт

11. ДОГОЛДОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 11.1. Хийж дуусаагүй ажлыг гүйцэтгэх, доголдол, зөрчлийг арилгах
- 11.2. Доголдол, зөрчил арилгах зардал
- 11.3. Доголдол, зөрчлийн талаар мэдэгдэх хугацааг сунгах
- 11.4. Доголдол, зөрчлийг арилгах үйл ажиллагаа амжилтгүй болох
- 11.5. Доголдол, зөрчилтэй ажлыг хасах
- 11.6. Цаашдын гүйцэтгэх туршилт
- 11.7. Гүйцэтгэгч тал үзлэг шинжилгээ хийх
- 11.8. Эцсийн байдлаар хүлээн авсан тухай гэрчилгээ /ажил хүлээлсэн акт/
- 11.9. Гүйцэтгээгүй үүрэг, хариуцлага
- 11.10. Ажлын талбайг цэвэрлэх

12. ДАЛД ДОГОЛДЛУУД

- 12.1. Засаж залруулах ажлын үүрэг

13. ӨӨРЧЛӨЛТ, ТОХИРУУЛГА

- 13.1. Ажилд өөрчлөлт оруулах
- 13.2. Өөрчлөлт хийх журам
- 13.3. Ажил өдөр

14. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ТӨЛБӨР

- 14.1. Гэрээний үнэ
- 14.2. Урьдчилгаа төлбөр
- 14.3. Завсрын төлбөрийн хүсэлт
- 14.4. Завсрын төлбөрүүд
- 14.5. Төлбөр төлөх хугацаа
- 14.6. Төлбөрийн саатал ба баталгаа
- 14.7. Ажил дуусгасан тухай мэдэгдэл
- 14.8. Эцсийн төлбөр авах хүсэлт
- 14.9. Гүйцэтгэл
- 14.10. Эцсийн төлбөр
- 14.11. Төлбөр хийх мөнгөн тэмдэгт
- 14.12. Нэмэлт төлбөрийн нэхэмжлэл

15. ЗАХИАЛАГЧИЙН САНААЧИЛГААР ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 15.1. Зөрчил, доголдлыг засах
- 15.2. Захиалагч гэрээг цуцлах
- 15.3. Гэрээг цуцлах өдөр гаргах үнэлгээ
- 15.4. Гэрээг цуцлалтын дараах төлбөр
- 15.5. Гэрээг цуцлах Захиалагчийн эрх


16. ГҮЙЦЭТГЭГЧ АЖЛЫГ ТҮР ЗОГСООХ БОЛОН ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 16.1. Ажлыг түр зогсоох Гүйцэтгэгчийн эрх
- 16.2. Гүйцэтгэгч Гэрээг дуусгавар болгох
- 16.3. Ажлыг зогсоон Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх
- 16.4. Цуцлах үед төлөх төлбөр
- 16.5. Цуцлах онцгой эрх

17. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

- 17.1. Хохирлыг арилгах баталгаа

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамрагдах тул өөр бусад этгээдэд хувиулж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

МТЗ ТӨХК 

"УБТЗ" ХНН 

ИЛ БОЛСОН

НУУЦ

- 17.2. Гүйцэтгэгч ажилдаа хариуцлагатай хандах
- 17.3. Захиалагчийн эрсдэл
- 17.4. Захиалагчийн эрсдлийн үр дагавар
- 17.5. Оюуны болон үйлдвэрлэлийн өмчийн эрх
- 17.6. Хариуцлагын хязгаарлалт

18. ДААТГАЛ

- 18.1. Захиалагчийн даатгал
- 18.2. Гүйцэтгэгчийн даатгал
- 18.3. Гүйцэтгэгчийн ажиллагсдын даатгал


19. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХУЧИН ЗҮЙЛС

- 19.1. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн тодорхойлолт
- 19.2. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн талаар мэдэгдэл
- 19.3. Саатлыг хамгийн бага болгох үүрэг
- 19.4. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн үр дагавар
- 19.5. Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт

20. НЭХЭМЖЛЭЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 20.1 Маргаан шийдвэрлэх журам

Энэхүү гэрээ нь торийн болон албаны нутагд хамаарих түү өөр бусад этгээдээ хувиар тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй ашигаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцагаа хүлээлгэх болно.

"МТЗ" ТӨХК 

"УБТЗ" ХНН.....



ИЛ БОЛСОН
НЭГ. НЭР ТОМЪЕОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

НУУН

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр, томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.1.1. Гэрээ:

- (a) “Гэрээ” гэж гэрээний 2-т заасан гэрээний иж бүрдлийг;
- (b) “Гэрээний тусгай нөхцөл” гэж Гэрээний Хавсралтуудыг;
- (c) “Зураг төсөл” гэж Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д тодорхойлсноор ойлгох бөгөөд Гэрээний хавсралт 3-т заасан баримт бичгүүдийг;
- (d) “Эрх бүхий байгууллага” гэж Төмөр замын дээд бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, шилэн кабель, гүүрийн барилгын ажлын зураг төсөл магадлах, холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг олгох, хяналт тавих, удирдлагаар хангаж чиглэл өгөх, барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой аливаа асуудлаар шийдвэр гаргах эрх хуулиар олгогдсон төрийн болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээдийг.

1.1.2. Талууд ба хамаарал бүхий Этгээд:

- (a) “Хамааралтай ажлын гүйцэтгэгчид” гэж Захиалагч, эрх бүхий байгууллага эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс Хамааралтай ажлыг гүйцэтгүүлэхээр хөлслөн авсан зөвлөх эсвэл үйлчилгээ үзүүлэгчид, аливаа бусад гүйцэтгэгчдийн хамтаар:
 - (i) Энэхүү гэрээнд Захиалагч гэж нэрлэгдсэн этгээдийг;
 - (ii) Хууль, тогтоомжийн дагуу Захиалагчийн хууль ёсны эрх, үүргийг залгамжлан авч буй этгээдийг;
- (c) “Захиалагчийн ажилтан” гэж Энэхүү гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор Захиалагчтай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан инженер, мэргэжилтэнг хэлнэ. Талуудын ажилтнуудын нэр, албан тушаалын жагсаалтанд орсон байна.
- (d) “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” Гэрээнд Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс ажиллах Гүйцэтгэгчийн төлөөлөгч гэж нэрлэсэн эсхүл бусад байдлаар 4.3 дахь заалт [Гүйцэтгэгчийн төлөөлөгч]-ын дагуу тухайн үед Гүйцэтгэгчийн томилсон, итгэмжлэл бүхий этгээдийг;
- (e) “Зөвлөх-Хяналтын баг” гэж Гүйцэтгэгч энэхүү гэрээнд заасан ажлыг батлагдсан зураг төсөв, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг гэрээний үндсэн дээр Захиалагчийг төлөөлөн хэрэгжүүлэх хуулийн этгээдийг;

1.1.3. Огноо (өдөр), тохируулга, зүгшрүүлэлт, хугацаа болон ажил дуусах:


Энэхүү гэрээ нь түүний болон албаны нууцанд хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хуртээд байрлахыг хориглоно. Энэ гэрээнийг биезүүтгэгч асваг этгээдэд хууль заасны дагуу харуулсаг хууль ёг болно.
“МТЗ” ТӨХК “УБТЗ” ХНН

НУУЦ

ИЛ БОЛСОН

- (a) "Ажил эхлэх өдөр" гэж Гүйцэтгэгч ажил эхлүүлэхийг шаардсан мэдэгдлийг Захиалагчаас бичгээр хүлээн авсан хугацаа болон эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр ажил, эхлүүлэх үргэлжлүүлэх тохиолдолд тухайн байгууллагаас зөвшөөрөл олгогдсон өдрийг;
- (b) "Ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэлт" гэж Хавсралт 5-д заасан тодорхой ажил дуусах үед явуулах туршилтуудыг. Тухайн Хавсралтад заасан журмын дагуу явуулахаас өөрөөр явуулсан ямар ч туршилтыг Ажил дуусах үеийн туршилт гэж тооцохгүй;
- (c) "Урьдчилсан байдлаар хүлээн авах өдөр" гэж ажлыг Техникийн комисс хүлээн авсан өдрийг;
- (d) "Хоног" гэж хуанлийн хоногийг, "жил" гэж гурван зуун жаран таван (365) хоногийг;
- (e) "Чанарын баталгаат хугацаа" гэж ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн Улсын комисс хүлээн авч акт баталгаажсан тухайн өдрөөс хойш гучин зургаан (36) сарын хугацааг;
- (f) "Эцсийн байдлаар хүлээн авсан тухай гэрчилгээ" гэж гэрээний 14.9 дэх заалтын дагуу Захиалагчаас олгох гэрчилгээг /Талуудын гэрээ дүгнэсэн акт/;
- (g) "Төлбөрөөс чөлөөлөх хугацаа" гэж Урьдчилсан байдлаар хүлээн авахад бэлэн болгосон байх ёстой өдрөөс хойш жар (60) хоногийн хугацааг /энэ хугацаанд Гүйцэтгэгч нь Саатлаас үүдсэн хохирол нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөгдөнө/;
- (h) "Төслийн гол үе шатны зааг" гэж Хавсралт 4-д заасан утгыг;
- (i) "Төслийн гол үе шатны заагийн огноо" гэж Хавсралт 4-д заасан утгыг;
- (j) "Доголдол, зөрчил" гэж Гүйцэтгэгч Гэрээнд заасны дагуу ажиллаагүйтэй холбоотой уг Ажилд гарсан доголдол, зөрчлийн талаар мэдэгдэх баталгаат хугацаа дуусахаас өмнө Захиалагчийн явуулсан шалгалтаар илрээгүй аливаа доголдол, зөрчлийг /гэрээнд заагаагүй боловч гэрээг хэрэгжүүлэх явцад Захиалагч талтай харилцан тохиролцон хийсэн ажлуудыг оруулан тооцохгүй/
- (k) "Доголдол, зөрчил илрүүлэх хугацаа" гэж Урьдчилсан байдлаар хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр (12) сарын хугацааг.
- (l) "Урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаа" нь Төлбөрөөс чөлөөлөх хугацаа дууссанаас хойш жар дахь (60) хоногийг /энэ хугацаа болсон бол Захиалагчийн зүгээс Гэрээг цуцлах эрхтэй/
- (m) "Ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авах" гэж уг Ажлын хувьд дараах шаардлагууд биелэгдэн техникийн комисс хүлээн авсан байхыг; Үүнд:
 - (i) Тухайн Ажлыг хүлээн аваад зохих зориулалтаар нь ашиглахад саад болохооргүй үлдсэн бага зэргийн ажил болон засах доголдлоос бусдаар уг Ажлыг Гүйцэтгэгч Гэрээний шаардлагын дагуу хийж гүйцэтгэж дууссан бөгөөд уг Ажил нь зохих хууль тогтоомжид нийцсэн байх;

Энэхүү гэрээ нь тэрийн болон албаны агууламд хамрагдсан тул өөр бусад этгээлдээ хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээлдээ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

МТЗ ТӨХК 

"УБТЗ" ХНН



ИЛ БОЛСОН

ХУУЦ

- (ii) Ажил дуусах үед явуулах тохируулга, зүгшрүүлэлтийг явуулаад тэнцсэн байх;
- (iii) Хавсралт 9-д заасан бичиг баримтууд бүрэн

1.1.4. Мөнгө ба төлбөр:

- (a) "Урьдчилгаа төлбөр" гэж Хавсралт 3-т зааснаар Гүйцэтгэгчид төлөх анхдагч төлбөрийг;
- (b) "Гэрээний үнэ" гэж талуудын энэхүү гэрээний хавсралт 3, 6-д заасан багц ажил бүрийн мөнгөн дүнг;
- (c) "Зардал" гэж байгууллагын нэмэлт зардал болон ашгийн аливаа дүнг оролцуулахгүйгээр Гүйцэтгэгчийн гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой гарсан зардлыг;
- (d) "Хохирол нөхөн төлөх" гэж Төслийн гол үе шатуудын зааг дээр зөрүү үүссэний хохирол болон Саатал гаргаснаас үүдсэн хохирол нөхөн төлөхийг;
- (e) "Эцсийн мэдэгдэл" гэж гэрээний 14.8 дэх заалтад заасан мэдэгдлийг;
- (f) "Үе шатны төлбөрийн гэрчилгээ" гэж Хавсралт 3-т заасан хэлбэрийн гэрчилгээг;
- (g) "Байгууллагын нэмэлт зардал" гэж уг Ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор Гүйцэтгэгчийн ажлын талбайгаас гадна гарсан бусад нэмэлт зардал (захиргааны, удирдлагын зардал)-д дараах зүйлс багтахыг.
 - (i) ажлын талбайгаас гадна түүнтэй холбоотойгоор гарсан Гүйцэтгэгчийн захиргааны, менежментийн үйлчилгээний болон ажлын талбайд дэмжлэг үзүүлэх системүүдийн зардал;
 - (ii) энэхүү Гэрээтэй шууд хамааралтай Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ явуулахтай холбоотой гарч буй зардал: Гүйцэтгэгчийн төслийн нэгжтэй холбоотой зардал, ус, цахилгаан, дулаан мэтийн нийтийн үйлчилгээний зардлууд, ажлын байрны тоног төхөөрөмжүүд, бичгийн хэрэгсэл, зөөврийн сууц, ажлын болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, машин, шатахуун тослох материал, сэлбэг хэрэгсэл, хэрэглээний зүйлс, хоол хүнс, төслийн нэгжийн ажилтнуудын цалин хөлс, илүү цагийн хөлс, тэдний томилолтын зардлууд, ажлын талбайд очиж ажилласан Гүйцэтгэгчийн эрх бүхий албан тушаалтан, инженер техникийн ажилтнуудын зардал г.м оролцуулсан зардал;
 - (iii) маркетинг, зар сурталчилгаа болон бизнес хөгжүүлэх зардал;
 - (iv) Бараа материал, түүхий эд, машин, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн элэгдэл хорогдол;

ИЛ БОЛСОН

НУУ

оролцуулан) авах шаардлагатай болох зөвшөөрөл, тохиролцоо, баталгаа, эрх олголт, хэлцэл, татгалзаагүй гэсэн гэрчилгээ, эрхээсээ татгалзалт, улсын комиссын ашиглалтад хүлээн авсан тухай гэрчилгээ эсвэл тусгай зөвшөөрөл зэргийг хэлэх бөгөөд үүнд бусдын газраар нэвтрэх эрх, газар худалдан авах, түрээслэх эрх олж авах гэрээг, (мөн уг Ажлын хэсгийг явуулахад нь саад тотгор үзүүлж болох (эсвэл гэрээ байгуулаагүйгээс Захиалагч эсвэл Гүйцэтгэгч уг Ажлыг гүйцэтгэсний төлөө хариуцлага хүлээхэд хүргэж болох) этгээдтэй байгуулах асуудал багтана);

- (с) "Гүйцэтгэгчийн баримт бичиг" гэж гэрээний 5.2 дахь заалтад [Гүйцэтгэгчийн баримт бичиг] заасанчлан Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн боловсруулан нийлүүлэх тооцоонууд, компьютерийн программууд, бусад программ хангамж, зураг төсөл, зураг, гарын авлага, гэрэл зураг, загвар (3D загварыг оролцуулан) болон Хавсралт 9-д заасан бусад баримт бичиг, техникийн шинж чанартай өгөгдлүүдийг;
- (d) "Маргаан" гэж Гэрээтэй холбоотойгоор эсвэл түүнээс үүдэн Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үүссэн нэхэмжлэл, маргаан эсвэл зөрчлийг /Гэрээний хүчинтэй байдал, цуцлалт эсвэл уг Ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор уг Ажлын явцад эсвэл дууссаны дараа болон Гэрээг орхиж зөрчих эсвэл Гүйцэтгэгчийн ажлыг цуцлахын өмнө эсвэл хойно үүссэн асуудлууд багтана/;
- (e) "Цуцлалтын эцсийн тооцоо" гэж гэрээний 15.4 дахь заалтанд тодорхойлсныг;
- (f) "Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлс" гэж гэрээний 19 дэх заалтад [Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлс] тодорхойлсныг;
- (g) "Оюуны өмчлөх эрх" гэж дэлхийн хаана ч бүртгэгдсэн, бүртгэгдээгүй, хүсэлт гаргасан боловч эрх нь хүлээгдэж буй патент, зураг төсөл, байгууламжийн загвар, зохиогчийн эрх, өгөгдлийн сангийн эрх, худалдааны тэмдэг, нөү-хаугийн эрх, худалдааны нууц, нууцлал бүхий мэдээлэл болон ижил төстэй бусад аливаа бүх эрхийг багтаасан аливаа оюуны болон үйлдвэрлэлийн өмчийн эрхийг;
- (h) "Хууль тогтоомж" гэж Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, УИХ-ын бусад шийдвэрийг;
- (i) "Төслийн үе шат" гэж Хавсралт 4-т заасан утгыг агуулсныг;
- (j) "Төлөвлөлт болон ажлын хуваарь" гэж гэрээний 8.3 дахь заалтын [Төлөвлөлт ба ажлын хуваарь] дагуу Гүйцэтгэгч тухайн үед боловсруулан шинэчилж байх Ажлын төлөвлөгөөг;
- (k) "Төслийн баримт бичиг" гэж Хавсралт 9-д заасан баримт бичгүүдийг;
- (l) "Хийж дуусгах ажлын жагсаалт" гэж хийгдэж дуусаагүй байгаа боловч уг Ажлыг туршиж үзэн ашиглалтанд оруулахад нөлөө үзүүлээд байхааргүй, Хуулиар болон Зөвшөөрлөөр заавал уг Ажлыг туршиж, ашиглаж эхлэх, ашиглалтанд бүрэн оруулахаас өмнө дуусгахыг шаардаад байдаггүй захиргааны эсвэл чухал бус шинж чанартай гүйцээж хийх шаардлагатай байгаа ажлын хуваарийг;

Энэхүү гэрээ нь тэрийн болон албаны нхүдэд хамаргах тул өөр бусад эт, тээвэр хувилж тараах, нийтийн хүртээл болгох, зардал, зориулалт, зориулалтыг биелүүлээгүй аливаа эт, тээвэр хуульд заасны дагуу хариуцлага хүлээгээд болно.
"МТЗ" ТӨХК "УБТЗ" ХНН

- (m) "Засаж залруулах ажил" гэж ил эсвэл далд доголдол, зөрчлөөс үүдэн Байнгын ажилд учирсан далд доголдол, зөрчил болон/-ын зураг төслийг өөрчлөх, засаж залруулах, дахин барьж байгуулах, солих эсвэл бусад байдлаар засаж залруулахыг (11.1(a)(b) болон 12 дэд заалтуудад заасныг оролцуулан);
- (n) "Ажлын талбай" гэж Хавсралт 13-д заасанчлан Байнгын ажил явагдаж байгаа Материалыг хүлээн авах газар болон Ажлын талбайн нэг хэсэг гэж Гэрээнд заасан бусад газрыг;
- (o) "Урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйл" гэж үндсэн хугацаанд Гүйцэтгэгч, Захиалагчийн боломжит зүйлийг урьдчилан таамаглаж чадаагүйгээс үүссэн нөхцөл байдлыг;
- (p) "Өөрчлөлт" гэж уг Ажилд оруулсан өөрчлөлт, нэмэлт 13 дахь заалтын [Өөрчлөлт тохиргоо] дагуу хийгдэх өөрчлөлт гэж Захиалагч болон Захиалагчийн хяналт хүлээн зөвшөөрч, зааварчилгаа өгсний дагуу Гүйцэтгэгчийн ажлын дараалал, хуваарь болон ажлын аргад Захиалагчийн санаачилгаар оруулсан өөрчлөлтүүдийг;
- (q) "Улсын комисс ашиглалтанд хүлээн авсан тухай дүгнэлт" гэж Монгол улсын хуулийн дагуу төрийн байгууллага эсвэл улсын комиссоос Ажлыг ашиглалтанд хүлээн авахдаа гаргадаг дүгнэлтийг.

1.1.7. Гэрээний зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэхүү гэрээнд заасан дээрх нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль, стандартад заасныг баримтална.

1.1.8. Энэхүү Гэрээнд орсон бусад нэр томъёонууд нь гэрээний тусгай нөхцөл болох Хавсралтад ашиглагдсан утгатай ижил утгатай байна.

1.2. Албан харилцаа

1.2.1. Энэхүү гэрээний дагуу зөвшөөрөл, баталгаа, гэрчилгээ, шийдвэр, мэдэгдэл, хүсэлт өгөх, олгох гэж заасан бол тэдгээр харилцааг дараах байдлаар явуулна. Үүнд:

- (a) Бичгээр үйлдэн биечлэн хүргэж, хүлээлгэн өгсөн баримт авах эсхүл шуудангаар, Захиалагч, Зөвлөх-Хяналтын баг зөвшөөрсөн бол электрон дамжуулах аргаар Хавсралт 10-т заасан хаягаар явуулна.
- (b) Хавсралт 10-т заасанчлан хүлээн авагчийн хаягаар хүргүүлэх, явуулах, дамжуулах боловч:
- (i) хүлээн авагч нь өөр хаяг руу явуулж байх тухай мэдэгдэл өгсөн бол тухайн мэдэгдэл авснаас хойш тэр хаяг руу нь явуулна.
- (ii) хүлээн авагч нь зөвшөөрөл, баталгаа хүсэхдээ өөрөөр заагаагүй бол хариуг тухайн хүсэлт ирүүлсэн хаяг руу нь явуулж болно.

1.2.2. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл, баталгаа, гэрчилгээ, шийдвэрийг зохих шалтгаангүйгээр саатуулах, хариу өгөхөөс цааргалж үл болно.

1.3. Хэрэглэх хууль ба хэл

ИЛ БОЛСОН

НУУН

1.3.1 Энэхүү гэрээ нь Монгол Хэл дээр Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдах бөгөөд гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг ягштал биелүүлж, мөрдөж ажиллана.

1.4. Гэрээний эрх, үүрэг шилжүүлэлт

1.4.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр, энэхүү Гэрээний эрх, үүргийг бүхэлд нь бусад этгээдэд шилжүүлж үл болно.

1.5. Баримт бичгийг хадгалах, хамгаалах

1.5.1. Гэрээний хавсралт 3 ба 4-т заасан баримт бичгийн эх хувийг Талууд (өөрт хамаарах шийдвэр) тус тусдаа, хавсралт 5, 6, 7-д заасан баримт бичгийн эх хувийг Захиалагч хадгалж хамгаалах бөгөөд энэхүү Гэрээнд Талуудын "хуулбар үнэн" дардас бүхий хувийг хавсаргана. Ажлын болон техникийн зураг төсөл, техникийн шаардлагын баримт бичгийн хуулбарыг Гүйцэтгэгчид хувилж өгнө. Үүнтэй холбоотой гарах зардлыг Захиалагч өөрөө хариуцна.

1.5.2. Гүйцэтгэгч өөрийн боловсруулсан баримт бичгийг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хадгалах ба Захиалагчид хүлээлгэн өгөх үед тус бүр гурван хувь (2 эх хувь цаасаар 1 цахим хувь) баримт бичгийг өгнө.

1.5.3. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр үндсэн гэрээ, техникийн шаардлага ажлын зургууд болон өөрчлөлттэй холбоотой баримт бичиг, Гэрээний бусад баримт бичгийг ашиглаж, зохих журмын дагуу хадгалж, хамгаална. Захиалагчийн ажилтан нь шаардлагатай тохиолдолд ажлын талбай дээр эдгээр баримт бичигтэй танилцах, ашиглах эрхтэй.

1.5.4. Хэрэв Гэрээний нэг Тал ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор баримт бичгүүдэд алдаа, зөрчил, доголдол гаргах тохиолдолд даруй нөгөө Талд мэдэгдэж залруулна.


1.5.5. Гүйцэтгэгч нь шилжүүлэн авсан баримт бичгийг оролцуулан Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор олж авсан, өөрөө бий болгосон, эсхүл өөрийн нэрийн өмнөөс хийлгэсэн бичгээр үйлдсэн бүх баримт бичиг, зураг, график, материал, гэрэл зураг болон бусад бүх мэдээлэлд нэвтрэх, ашиглах, өөрийн зардлаар хуулбарлан авах боломжийг Захиалагчид олгоно.

1.6. Нууцлал

1.6.1. Талууд, тэдгээрийн ажилтан гэрээний хэрэгжилттэй холбоотой нууцлалбал зохих баримт бичиг, мэдээллийг харилцан дамжуулах, солилцох, хадгалах, хамгаалахдаа Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, эдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг чанд мөрдөх үүрэгтэй. Гэрээний хэрэгжилттэй холбоотой нууцлалбал зохих асуудлаар Талууд гуравдагч этгээдтэй гэрээ, хэлэлцээр байгуулахдаа тухайн гэрээний оролцогч талуудад энэхүү хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллах үүргийг гэрээний нөхцөл болгон заавал тусгана.

1.6.2. Талууд энэхүү гэрээний нөхцөл, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор нөгөө талын шууд ба шууд бусаар олж авсан /Үүнд: гэрээ байгуулахаас өмнө эсхүл хойно гэрээ цуцалсны дараа/ мэдээллийг нөгөө талын /шаардлагатай тохиолдолд Тэгнүүлын ерөнхий газрын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах туяа өөр бусад этгээдэд хувилаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдтэй хуульд заасны дагуу хариуцаага хүтээлгэх болно.

МТЗ ТӨХК. 

"УБТЗ" ХНН.



ИЛ БОЛСОН

НУУЦ

1.6.3.Төслийн баримт бичиг, материалтай талуудын зөвхөн нууцтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтан танилцана. Талууд нууцтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтны жагсаалтыг харилцан бичгээр мэдэгдэнэ. Уг жагсаалтад өөрчлөлт орсон даруй нөгөө талд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

1.6.4.Гэрээгээр гүйцэтгэх ажилд хамааралтай бусад гүйцэтгэгч нарт тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хүрээ хязгаарын дотор мэдээллийг өгч болно. Мэдээлэл задруулж буй тал нь нууц хадгалах гэрээ эсхүл нууцын баталгааг тухайн этгээдтэй заавал байгуулна Гүйцэтгэгч задруулах гэж буй мэдээллийн тухай мэдэгдлийг нөгөө талд, шаардлагатай бол Тагнуулын ерөнхий газарт урьдчилан хүргүүлж, задруулах мэдээллийн хэмжээг аль болох бага байлгаж, нууцлалыг хамгаалах талаар бүх талын арга хэмжээ авна.

1.6.5.Мэдээлэл задруулах талын хүлээх үүрэгт дараах баримт бичиг хамаарахгүй.Үүнд:

- (a) аль нэг талын буруутай үйлдлээс үл хамааран нийтэд илэрхий болсон мэдээ, мэдээлэл, баримт материал, бичиг баримт;
- (b) гуравдагч этгээд ямар ч нууцлалын үүрэг хүлээлгэлгүйгээр тухайн Талд хууль ёсны дагуу өгсөн мэдээ, мэдээлэл, баримт материал, бичиг баримт;
- (c) Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэгчийн оролцох оролцоо ямар нэг байдлаар цуцлагдах, дуусгавар болсон нь хууль тогтоомжид заасан хугацаагаар мэдээллийг хадгалах үүргээс чөлөөлөгдөхгүй.

1.7. Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч ашиглах

1.7.1.Дараах баримт бичгийг Захиалагч ашиглах эрхтэй.Үүнд:

- (a) Гүйцэтгэгчийн баримт бичгүүд;
- (b) Гүйцэтгэгч өөрөө боловсруулсан эсвэл түүний нэрийн өмнөөс хийлгүүлсэн бусад зураг төсөл, программ хангамж, өгөгдөл болон баримт бичиг.

1.7.2.Гүйцэтгэгч нь Оюуны өмч эзэмшигч эрх бүхий Гүйцэтгэгчийн өмчлөлийн баримт бичгүүдийг хуулбарлах, ашиглах, дамжуулах болон тэдгээрт өөрчлөлт оруулж ашиглах дэлхийн хэмжээний, эргэлт буцалтгүй, шилжих боломжтой, онцгой бус, роялти төлдөггүй, цааш нь дэд лицензээр өгөх бүрэн боломжтой зөвшөөрлийг Захиалагч өөрийн зардлаар хуулбарлаж, ашиглаж, дамжуулан олж авч болно.



1.7.3.Гүйцэтгэгчийн өмчлөлийн баримт бичгүүдийг Захиалагч эсвэл түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй этгээд нь Гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд ашиглуулж, хуулбарлан өгч эсвэл дамжуулж үл болно.

1.7.4.Энэхүү гэрээний 1.8 дахь заалтын дагуу хүлээх өөрийн үүргүүдийг биелүүлэх боломжтой байхын тулд Гүйцэтгэгчид шаардагдаж болох гуравдагч этгээдээс авах шаардлагатай бүхий л холбогдох эрхүүдийг Гүйцэтгэгч өөртөө олж авах бөгөөд Захиалагч өөрөөс хамаарах бүхий л талын тусламж дэмжлэгийг үзүүлнэ.

Энэхүү гэрээ нь тэрийн болон албаны нууцад хамаарах тул тэр бүхэнд этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээлтэй болгохыг хорьсон. Энэ шаардлагыг биелүүгээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харилцан хүтээлэгч болно.

"МТЗ" ТӨХК

"УБТЗ" ХНН



1.8. Захиалагчийн баримт бичгийг Гүйцэтгэгч ашиглах

1.8.1 Дараах баримт бичгийг Гүйцэтгэгч ашиглах эрхтэй:

- (a) Зураг төсөл;
- (b) Захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, техникийн нөхцөл, зураг, төсөв. ТЭЗҮ г.м,
- (c) Захиалагч өөрөө боловсруулсан эсвэл түүний нэрийн өмнөөс хийлгүүлсэн зураг төсөл, өгөгдөл болон бусад баримт бичиг.

1.8.2. Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс Захиалагчийн Оюуны өмчийн баримт бичгийг өөрийн зардлаар хуулбарлаж, ашиглаж, дамжуулан олж авч болно.

1.8.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд тэдгээр баримт бичгийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч хуулбарлаж, ашиглаж эсвэл гуравдагч этгээдэд дамжуулж үл болно.

1.9. Гэрээг дагаж мөрдөх

1.9.1. Захиалагч гэрээг Гүйцэтгэгч нь дагаж мөрдөж байгаа эсэхийг хэдийд ч шалгах эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч холбогдох мэдээллээр түргэн шуурхай хангах үүрэгтэй.

1.9.2. Гэрээний талууд нь аль нэг талдаа хохирол учруулахаас зайлсхийх, аль аль талдаа ашигтай байх зарчмыг баримтлах, нөгөө талын эрх ашгийг зөрчихөөс зайлсхийх үүрэгтэй.

1.10. Ажилд шаардагдах зөвшөөрөл

1.10.1. Талууд ажил гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан тусгай зөвшөөрөлтэй байна.

1.10.2. Гэрээний Хавсралт 8-д Талуудад хамаарах зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг нарийвчлан зохицуулна.

1.10.3. Гүйцэтгэгчид хамаарах зөвшөөрөл авах үүрэг нь Хавсралт 8-д зааснаар хязгаарлагдахгүй.

1.11. Төслийн баримт бичиг

1.11.1. Захиалагч нь Хавсралт 9-д заасан Төслийн баримт бичгийн талаар шаардлагатай мэдээллийг Гүйцэтгэгчид өгнө

1.11.2. Гүйцэтгэгч нь Төслийн баримт бичгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авсан бол тэдгээртэй нарийвчлан танилцана. Гүйцэтгэгч, Захиалагч нь Төслийн баримт бичгийн дагуу хүлээсэн үүргээ зөрчихөд хүргэх, эсхүл зөрчсөнд тооцогдох байдалд оруулахгүй байхаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

Энэхүү гэрээ нь торлоос болон цахиаар үүсчээ. Энэ гэрээг хууль ёсоор бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгож харуулах, эсвэл шаардлагыг биелүүлэхгүй олоход этгээдэд хууль ёсны дагуу хариуцаага хүлээлгэх болно.

"МТЗ" ӨХК

"УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

НУУН

1.11.3. Захиалагчийн зүгээс гаргаж өгсөн баримт материал, бичиг баримт, зураг төсөл, ажлын даалгавар, техникийн нөхцөлийн бүрэн, үнэн зөвийг Захиалагч өөрөө хариуцна. Эдгээр гаргаж өгсөн зүйлүүд нь алдаатай, өөр хоорондоо зөрүүтэй, стандарт шаардлагад нийцэхгүй тохиолдолд түүнийг арилгуулах мэдэгдэл өгөх эсвэл Гүйцэтгэгч өөрийн ажилтнууд болон техникийн зөвлөхүүдийн тусламжтайгаар засаж зөв болгож болох бөгөөд түүнтэй холбоотой гарсан нэмэгдэл төлбөрийг төлөх болон саатсан хугацааг сунгах асуудлыг Захиалагч шийдвэрлэж өгнө.

1.12. Өмнөх ажил

1.12.1. Гэрээ байгуулахаас өмнө энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажилтай холбоотойгоор Захиалагчийн Гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн, гүйцэтгүүлж байгаа ажлыг гэрээний шаардлагад нийцүүлэн гүйцэтгэсэнд тооцох бөгөөд энэхүү гэрээнд заасан баталгаа, амлалт нь тэдгээр ажилд мөн адил хамаарна.

1.12.2. Гэрээний 1.12.1-д заасан ажилд төлсөн төлбөрийг гэрээний үнээс төлсөнд тооцогдох бөгөөд нийт төлсөн дүн нь гэрээний эцсийн төлбөрийн үнийн дүнгээс хасагдаж тооцогдоно.

1.12.3. Гэрээний 1.12.1-д заасан ажлыг энэхүү гэрээнээс тусдаа гэрээ байгуулж төлбөрийг төлсөн тохиолдолд энэхүү гэрээний төлбөрөөс хасагдаж тооцогдохгүй болно.

1.13. Нэмэлт, өөрчлөлт

1.13.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

1.13.2. Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл түүний төслийг тусгана. Саналыг хүлээж авсан тал ажлын 10 хоногийн дотор хариу ирүүлнэ.

1.13.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг байна.

1.13.4. Гэрээт ажлын санхүүжилттэй холбоотойгоор Захиалагч зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Гүйцэтгэгчийн эрх ашгийг ямар нэг байдлаар хохироох, урьд байгуулсан гэрээний нөхцөлийг дордуулахгүй бөгөөд бусад тохиолдолд Гүйцэтгэгч энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаас шалтгаангүйгээр татгалзахгүй.


1.13.5. Гэрээний хавсралт 3, 4, 6-г тусдаа батлах бөгөөд үүнийг гэрээний нэмэлт өөрчлөлт гэж үзэхгүй.

1.14. Гэрээний зарим заалт хүчин төгөлдөр бус болох

1.14.1. Гэрээний зарим заалт хүчин төгөлдөр бусад тооцогдсон нь гэрээг бүхэлд нь хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болохгүй.

1.15. Гэрээний хувь ба бүрдэл хэсэг

Энэхүү гэрээ нь торийн болон албан ёрууцаа замаарх тусгаар бусад этгээд хувиар таргах, нийтийн хуртэл бичлэмж хорьсонго. Энэ ширтлэгийг биед үл хуи аливаа этгээд хууль цааста дагуу хариуцагч хувиар х болно. МТЗ" ТӨХК. "УБТЗ" ХНН.





ИЛ БОЛСОН



1.15.1. Гэрээг Монгол хэл дээр 2 хоёр хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр хуулийн хүчин төгөлдөр байна.

1.15.2. Зураг төсөл, ажлын даалгавар, техникийн нөхцөл бэлэн болсны дараа хийгдэх ажил, төсөвт өртөг, үе шатны ажлын хуваарийг хавсралтаар тухай бүр нь хийж баталгаажуулах бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй бүрдэл хэсэг болно.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

2.1. Ажлын талбайд нэвтрэх эрх

2.1.1. Захиалагч нь Хавсралт 4-д заасан хугацааны туршид Ажлын талбайд нэвтрэх эрхийг Гүйцэтгэгчид олгоно.

2.1.2. Хавсралт 4-д хугацаа заагаагүй бол Захиалагч нь Ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд Ажлын талбайд нэвтрэх эрхийг Гүйцэтгэгчид олгоно.

2.1.3. Захиалагч ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс Гүйцэтгэгчийн ажил саатсан бол Гүйцэтгэгч дараах шаардлага гаргах эрхтэй:

- (a) ажлын гүйцэтгэл саатсан бол гэрээний 8.4-т заасны дагуу хугацааг сунгах;
- (b) Ажлын гүйцэтгэл саатсанаас үүдсэн зардлыг нэхэмжлэх.

2.1.4. Дээрх шаардлагыг хүлээн авсны дараа Захиалагч нь гэрээний 3.2 дахь заалтын [шийдвэрүүд] дагуу тухайн асуудлаар шийдвэр гаргана.

2.1.5. Захиалагч ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүй нь Гүйцэтгэгчээс шалтгаалсан бол Гүйцэтгэгч нь Захиалагчид шаардлага гаргах эрхгүй.

2.2. Захиалагчийн ажилтан

2.2.1. Захиалагчийн ажилтан нь гэрээний 4.8 дахь заалтын [Аюулгүй ажиллагааны журам] (a), (b) ба (c) дэд заалтууд болон гэрээний 4.18 дахь заалтын [байгаль орчныг хамгаалах] дагуу Гүйцэтгэгчийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дагаж мөрдөн ажиллана.

2.2.2. Захиалагч нь энэхүү гэрээний 6.4.1-д заасан зүйлийг өөрийн ажилтнуудын хувьд мөн авч хэрэгжүүлсэн байна.

2.2.3. Захиалагчийн ажилтан нь энэхүү гэрээний 6.4.2-т заасан ажлын талбай дахь Гүйцэтгэгчийн гаргаж мөрдүүлж буй дотоод журмыг мөрдөж ажиллах бөгөөд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журам, зааварчилгааг ягштал баримталж ажиллана. Захиалагч нь өөрийн ажилтныхаа санаатай болон санамсар болгоомжгүйн улмаас Гүйцэтгэгч, түүний ажилтнууд болон бусад 3-дагч этгээдэд учруулсан гэм хорын хохирлыг хариуцна.

2.3. Захиалагчийн санхүүжилт

2.3.1. Захиалагч нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасан эх үүсвэрээс төвлөрүүлсэн хөрөнгөөс ажлын гүйцэтгэлийн төлбөрийг төлнө. Захиалагч нь хөрөнгийн эх үүсвэртэй холбоотой өөрөөс хамаарах бүх талын арга хэмжээг

НУУЦ

ИЛ БОЛСОН

авч ажиллана. Захиалагч нь төмөр замын барилгын ажил эхлэхээс өмнө урьдчилгаа төлбөрийг гэрээний хавсралт 3, 6-д заасны дагуу Гүйцэтгэгчид олгоно. Гэрээний хавсралт 3-д заасан Ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх нөхцөл, санхүүжилтийн хуваарийн дагуу урьдчилгаа төлбөр, үе шатны буюу завсрын төлбөр, эцсийн төлбөрийг санхүүжүүлнэ.

2.3.2. Захиалагч нь Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолын дагуу Төслийн зориулалтаар бэлэн төвлөрсөн хөрөнгийн хэмжээгээр ажлыг гүйцэтгүүлж, дараагийн хөрөнгө дансанд бэлэн орж иртэл ажлыг түр зогсоох арга хэмжээ авч, түр зогсолтын хугацаанд гарах Гүйцэтгэгчийн зайлшгүй гарах зардлын гүйцэтгэлийг төслийн магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлнэ.

2.3.3. Зайлшгүй зардал гэдэгт: Ажилтнуудын сул зогсолтын үеийн цалин хөлс, харуул хамгаалалт, захиалсан бараа материал, тоног төхөөрөмжийн үнэ болон эд хөрөнгийн элэгдэл хорогдол, тээврийн зардал г.м болно.

2.4. Захиалагчийн нэхэмжлэл

2.4.1. Захиалагч нь Гүйцэтгэгчийн доголдол, зөрчлийн талаар мэдэгдэх хугацааг сунгах, гэрээтэй холбоотой эсхүл гэрээний нөхцөлөөр ямар нэгэн төлбөр нэхэмжлэх эрхтэй гэж үзэж байгаа бол Гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Дараах тохиолдолд мэдэгдэл өгөх шаардлагагүй. Үүнд:

- (а) Гэрээ зөрчсөнөөс үүдэн гарах хохирлыг урьдчилан тооцсон нөхөн төлбөртэй холбоотой эсхүл гэрээний 15.4 дахь заалтын [цуцлалтын дараа төлөх төлбөр] дагуу төлөх төлбөрүүд;

2.4.2. Нэхэмжлэл гаргах болсон нөхцөл байдал эсхүл тохиолдлын талаар Гүйцэтгэгчид ердийн боломжит хугацаанд мэдэгдэнэ. Доголдол, зөрчлийг арилгах хугацааг сунгах мэдэгдлийг уг хугацаа дуусахаас өмнө хүргүүлнэ.

2.4.3. Мэдэгдэлд нэхэмжлэл гаргахдаа мөрдлөгө болгож буй заалт, үндэслэл, нэхэмжлэлийн дүн эсхүл сунгалтын талаарх баримтыг багтаасан байна.

2.4.4. Захиалагч гэрээний 3.2 дахь заалтын [Шийдвэрүүд] дагуу дараах нөхцөлийг тогтооно:

- (а) Захиалагч Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй баримтаар нотлогдсон үндэслэл бүхий дүн;
- (б) Зөрчил доголдлын талаар мэдэгдэх хугацааг сунгах сунгалт.

2.4.5. Захиалагч нь Гүйцэтгэгчээр төлүүлэх дүнг гэрээт ажлын эцсийн төлбөрөөс суутган тооцох бөгөөд үндэслэлгүй, ямар нэг нотлох баримтгүйгээр суутгал хийхийг хориглоно.

2.4.6. Зөрчил, доголдолын талаар гомдол гаргах хугацааны дотор өгөх бөгөөд хугацаа дуусгавар болсон тохиолдолд Гүйцэтгэгч түүнийг хүлээн авахгүй.

2.5. Барьж байгуулах ажилд туслалцаа үзүүлэх, урьдчилсан нөхцөл бүрдүүлэх

2.5.1. Захиалагч ажил гүйцэтгэх явцад шаардагдаж болох ус, хий, бохир ус, цахилгаанаар хангахад Гүйцэтгэгчид туслалцаа үзүүлэх үүрэг, хариуцлага хүлээхгүй. Гүйцэтгэгч тэдгээрийг өөрөө зохион байгуулах үүрэгтэй.

ИЛ БОЛСОН

НУУЦ

2.5.2. Захиалагч нь төмөр замын төрөөсний дагуу цахилгаан, дохиолол холбоо, зөрлөгийн байрлах газраас хамгийн ойр цэгт гаргаж өгсөн байна.

2.5.3. Түүнчлэн Захиалагч нь төмөр замын дээд бүтцийн ажлыг Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд саадгүй хийж гүйцэтгэхэд шаарлагатай төмөр замын доод бүтэц, далан, гүүр, ус зайлуулах байгууламж зэргийг бусад холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан урьдчилан хийж гүйцэтгүүлсэн байна. Энэхүү үүргээ хэрэгжүүлээгүйгээс Гүйцэтгэгчийн ажил саатах, үүнтэй холбоотой нэмэлт төлбөр гарсан тохиолдолд Захиалагч хариуцан барагдуулна.

ГУРАВ. ЗӨВЛӨХ-ХЯНАЛТЫН БАГ

3.1. Зөвлөх-Хяналтын баг

3.1.1. Гэрээний дагуу Захиалагчийн нэрийн өмнөөс ажиллах Зөвлөх-Хяналтын багийг гэрээний үндсэн дээр ажиллуулна. Захиалагч нь Зөвлөх-Хяналтын багийн нэр, хаяг, албан тушаал болон эрх хэмжээний талаарх мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө.

3.1.2. Зөвлөх-Хяналтын баг Захиалагчаас олгосон эрх хэмжээний хүрээнд даалгасан үүрэгт ажлыг гүйцэтгэнэ. Захиалагч Гүйцэтгэгчид мэдэгдээгүй бол мэдэгдэх хүртэл, Зөвлөх-Хяналтын баг нь гэрээний 15 дахь заалтад [Захиалагчийн санаачлагаар цуцлах] зааснаас бусад Захиалагчийн эрхийг эдэлнэ. Зөвлөх-Хяналтын баг гэрээний нөхцөлүүдэд өөрчлөлт оруулах эрхгүй.

3.1.3. Зөвлөх-Хяналтын баг гэрээнд заасан эсхүл Зөвлөх-Хяналтын багийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох эрхийг эдэлнэ.

3.1.4. Зөвлөх-Хяналтын багийн хууль бус, техникийн шаардлагад нийцээгүй шаардлагыг Гүйцэтгэгч биелүүлэхгүй байх эрхтэй бөгөөд Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.1.5. Захиалагч энэхүү гэрээний 3.1.4-т заасан мэдэгдлийг хүлээн аваад шаардлагатай арга хэмжээ аваагүйн улмаас Зөвлөх-Хяналтын багийн хууль бус, техникийн шаардлагад нийцээгүй үйлдлийн улмаас гарсан ажлын доголдол, зөрчил, гэмтлийн эцсийн хариуцлагыг Захиалагч хариуцна. Түүнийг зохих байдалд нь оруулахтай холбоотой гарсан нэмэлт зардлыг Гүйцэтгэгчид саадгүй төлнө.

3.1.6. Захиалагч нь Зөвлөх-Хяналтын багийн эрх, үүрэгтэй холбоотой ямар нэгэн өөрчлөлт хийхээр бол энэ тухай Гүйцэтгэгчид тухай бүр мэдэгдэнэ.

3.1.7. Зөвлөх-Хяналтын багийн шалгах, нягтлах, гэрчлэх, хянах, зааварчлах, мэдэгдэх, санал тавих, хүсэлт гаргах, туршилт явуулах, зөвшөөрөл өгөхтэй холбоотой үүрэг нь гүйцэтгэгчийг гэрээнд заасан ямар нэгэн үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

3.1.8. Зөвлөх-Хяналтын баг Гүйцэтгэгчээс тавьсан хүсэлт /талбайн/-ийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор бичгээр тодорхой хариу өгөх үүрэгтэй.

3.1.9. Зөвлөх-Хяналтын баг хугацаа сунгах эсхүл нэмэлт зардлыг зөвшөөрөх болон шийдвэрлэх, Гүйцэтгэгчийн танилцуулсан ажлын өөрчлөлтийн талаарх саналыг зөвшөөрөх, Зөвлөх-Хяналтын багийн тодорхойлсон онцгой нөхцөл байдлын дагуу арга хэмжээ авахаас өмнө Захиалагчаас албан ёсны зөвшөөрлийг авсан байна.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувиулж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хууль заалты дагуу хариуцлага хүрээлэх болно.
"МТЗ" ТӨХК "УБТЗ" ХНН,

ИЛ БОЛСОН

НУУЦ

3.1.10. Зөвлөх-Хяналтын баг ~~хөдөлмөрийн аюулгүй~~ байдал, эрүүл ахуй, байгаль орчинд нөлөөлж болохуйц онцгой нөхцөл үүссэн гэж үзвэл эрсдлийг багасгах үүднээс Захиалагчийн зөвшөөрлийг үл харгалзан Гүйцэтгэгчид зааварчилгаа өгөх бөгөөд Гүйцэтгэгч уг зааварчилгааг мөрдөх үүрэгтэй.

3.1.11. Зөвлөх-Хяналтын баг өгсөн зааварчилгаа, түүний хэрэгжилтийн тайланг Захиалагчид хүргүүлнэ.

3.1.12. Захиалагч нь энэхүү гэрээний 6.4.1-д заасан зүйлийг Зөвлөх-Хяналтын багийн ажилтнуудын хувьд мөн авч хэрэгжүүлсэн байна.

3.1.13. Захиалагчийн Зөвлөх-Хяналтын багийн ажилтан нь энэхүү гэрээний 6.4.2-т заасан ажлын талбай дахь Гүйцэтгэгчийн гаргаж мөрдүүлж буй дотоод журмыг мөрдөж ажиллах бөгөөд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааварчилгааг ягштал баримталж ажиллана.

3.1.14. Захиалагч нь Зөвлөх-Хяналтын багийн ажилтныхаа санаатай болон санамсар болгоомжгүйн улмаас Гүйцэтгэгч, түүний ажилтнууд болон бусад 3-дагч этгээдэд учруулсан гэм хорын хохирлыг хариуцна. Үүнтэй холбоотой ямар нэг шүүхийн маргаанаас Гүйцэтгэгчийг ангид байлгана.

3.2. Шийдвэр

3.2.1. Зөвлөх-хяналтын баг нь гэрээний 3.1-д заасны дагуу асуудлыг шийдвэрлэх эрхтэй бөгөөд харилцан тохиролцох, зөвшилцөх зарчмыг баримтлах ба тохиролцох боломжгүй тохиолдолд бие даан шийдвэр гаргах эрхтэй.

3.2.2. Зөвлөх-хяналтын баг нь шийдвэрээ дагалдах баримт бичгийг хамт Гүйцэтгэгчид заавал хүргүүлнэ.

3.2.3. Гүйцэтгэгч нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол тухайн мэдэгдэл авснаас хойш 14 хоногт багтаан Зөвлөх-хяналтын багт бичгээр хариу мэдэгдэнэ.

3.2.4. Зөвлөх-хяналтын баг Гүйцэтгэгчийн ирүүлсэн хариу мэдэгдлийн хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.2.5. Талууд тухайн маргааныг гэрээний 20 дахь заалтын [маргаан шийдвэрлэх] дагуу шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болно. Хийсэн тохиролцоо эсхүл шийдвэртэй холбоотой маргаан гарсан ч гэсэн Талууд гэрээгээр хүлээсэн холбогдох үүргүүдээ гүйцэтгэнэ.


ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ

4.1. Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг


4.1.1. Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэх, тухайн ажилтай холбоотой доголдол, зөрчлийг засаж залруулна.

4.1.2. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг зохих ёсоор хийж гүйцэтгэхтэй холбоотой Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлыг Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалыг удирдлага болгон зохион байгуулж ажиллана.

Энэхүү гэрээ нь торийн болон озбаны нүүсэд хамаарах түү өөр бусад этгээдэд хувилж тархах, нийтийн хуртэйл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцаага хүлээгэх болно.

"МТЗ" ТӨХК 

"УБТЗ" ХНН.....



ИЛ БОЛСОН

НУУЦ

4.1.3. Гүйцэтгэгч нь Захиалагчийн магадлал хийлгэсэн зураг төслийн дагуу, хэрвээ магадлал хийлгэсэн зураг төсөл байхгүй бол гэрээний Хавсралт 3, 6-д заасан төсөвт өртөгт багтааж ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.1.4. Ажлын үр дүн гэрээнд заасан эсхүл гэрээнд зохих ёсоор тодорхойлогдсон. Захиалагчаас өгсөн зураг төсөл, ажлын даалгавар, техникийн шаардлага болон гэрээний хавсралтад заасан бусад шаардлагад нийцсэн байна.

4.1.5. Ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, Зөвлөх-Хяналтын баг болон Захиалагчаас тавьсан шаардлагыг биелүүлж ажиллана.

4.1.6. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхэд шаардлагатай зөвшөөрөлтэй, зөвшөөрөл нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, хүн хүч, мэргэшсэн хүний нөөцтэй, машин механизм, тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл болон санхүүгийн бүрэн чадамжтай байна.

4.1.7. Гүйцэтгэгч Ажлын талбай дээрх үйл ажиллагаа, ажлын зохистой, тогтвортой, аюулгүй байдлыг хариуцна.

4.1.8. Захиалагчаас шаардсан үед Гүйцэтгэгч уг Ажил гүйцэтгэхэд ашиглахаар санал болгож буй арга болон зохион байгуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид өгнө. Захиалагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр эдгээр арга болон зохион байгуулалтад ямар нэгэн өөрчлөлт хийж үл болно.

4.2. Гүйцэтгэлийн баталгаа


4.2.1. Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар гаргаж байгаа бөгөөд улсын комисс хүлээн авсан өдөр 2.5 хувийг, чанарын баталгаат хугацаа дуусгавар болсон өдөр гүйцэтгэлийн 2.5 хувийг Гүйцэтгэгчийн гаргаж өгсөн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

4.3. Техникийн зөвлөх


4.3.1. Гүйцэтгэгч нь зураг төсөл боловсруулах шатнаас эхлэн зам барилга угсралтын ажлыг бүрэн дуусах хүртэл хяналт тавих, зөвлөх, төмөр зам барилгын зураг төсөв, инженерийн шийдэл, гүйцэтгэлийн үйл явц, гүйцэтгэлийн чанар байдал, техник тоног төхөөрөмж, бараа материал сэлбэг хэрэгслийн чанар байдалд хяналт тавих, зөвлөгөө үзүүлэх, туслан гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих, Төслийн нэгжээр дамжуулан шаардлага хүргүүлэх, Гүйцэтгэгчийн төслийн нэгжийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн, төслийн цаашдын үйл ажиллагаа болон бусад асуудалд зөвлөгөө үзүүлэх чиг үүрэг бүхий техникийн зөвлөхийн багийг ажиллуулж болно.

4.3.2. Техникийн зөвлөхийн хийж гүйцэтгэх ажлыг Хавсралт 11 /техникийн зөвлөх/ -д заасан.

4.3.3. Гүйцэтгэгч нь энэхүү хавсралтад заасан хэмжээгээр Техникийн зөвлөх /Хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний аль нь ч байж болно/-тэй тусгайлсан гэрээ байгуулж ажиллана.



Энэхүү гэрээ нь төрчин болон албаны нууцаар хамгаалах тул өөр бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй эсвэл эгтгээдэд хууль заасны дагуу хариуцаага хүлээлгэх болно. "МТЗ" ТӨХК..... "УБТЗ" ХНН.....



ИЛ БОЛСОН

МУУЦ

4.3.5. Техникийн зөвлөх Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу түүнд олгогдсон эрх хэмжээний хүрээнд ажиллана.

4.3.6. Техникийн зөвлөх нь зохих мэргэжил, ур чадварын шаардлагыг хангасан этгээд байна. Гүйцэтгэгч техникийн зөвлөхийг ажлын шаардлагаар хэдийд ч, хэдэн удаа ч сольж болох бөгөөд томилох болон өөрчилсөн тохиолдол бүрдээ энэ талаар Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

4.3.7. Гүйцэтгэгчийн техникийн зөвлөх Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс зааварчилгаа авна.

4.4. Гуравдагч этгээдээр ажил гүйцэтгүүлэх

4.4.1. Гүйцэтгэгч гуравдагч этгээдээр ажлын тодорхой хэсгийг ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно. Ийнхүү гүйцэтгүүлэх тохиолдолд Захиалагч гуравдагч этгээдтэй санхүүжилтийн гэрээ байгуулж, гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр төлбөрийг олгоно.

4.4.2. Захиалагч төлбөрийг Гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу шилжүүлээгүйгээс ажил саатах, чанар гүйцэтгэлд муугаар нөлөөлөх, алданги төлөх г.м нөхцөл байдалд хүргэсэн бол Захиалагч хариуцлагыг өөрөө биечлэн хүлээнэ.

4.4.3. Гүйцэтгэгч гэрээт ажлыг бүхэлд нь гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж үл болно.

4.4.4. Гүйцэтгэгч гуравдагч этгээдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн зөвлөмж, чиглэлийг авсан байна.

4.5. Хамтын ажиллагаа

4.5.1. Гүйцэтгэгч Гэрээнд тусгагдаагүй зарим ажлыг дараах этгээдүүдээр Зөвлөх-Хяналтын багийн зааварчилгааны дагуу гүйцэтгүүлэхээр хөлслөн ажиллуулж болох боломж олгоно:

- (a) Захиалагчийн ажилтан;
- (b) Захиалагч хөлслөн ажиллуулсан бусад Гүйцэтгэгч;
- (c) Эрх бүхий байгууллагаас албан ёсоор томилсон ажилтнуудыг.

4.5.2. Гэрээний 4.5.1-д заасан хөлсөөр ажилуулах гэрээний зардлыг Захиалагч өөрөө хариуцна.

4.5.3. Гүйцэтгэгч Захиалагчийн шаардлагад нийцүүлэн өөрийн үйл ажиллагааг бусад гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж зохион байгуулна.

4.5.4. Хөлсөөр ажил гүйцэтгэгч нь гэрээт ажилд сөргөөр нөлөөлж, саатал тасалдал учруулж, улмаар Гүйцэтгэгчид нэмэлт зардал, алдагдал хохирол учруулахад хүргэсэн тохиолдолд түүнийг Захиалагч хариуцна.

4.6. Ажлаа тодорхойлох

21

Энэхүү гэрээ нь торийн батал албаны нүүцэд хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тархах, нийтийн хүртээл болгохыг хорьсон. Энэ шаардлагыг биелүүлэхгүй албаар этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

МТЗ ТӨХК

"УБТЗ" ХНН

-40-

ИЛ БОЛСОН

4.6.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээнд дурдсан баримт бичиг, цэг, шугам, түвшний дагуу тодорхойлно.

4.6.2. Гүйцэтгэгч нь уг Ажлын бүх хэсгийг зөв байршуулах асуудлыг хариуцах бөгөөд уг Ажлын байрлал, түвшин, хэмжээс болон тэгшлэлтийн аливаа алдааг залруулна.

4.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин болон орон нутгийн харилцаа

4.7.1. Гүйцэтгэгч Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхдээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгаль орчны багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагыг ханган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.

4.7.2. Гүйцэтгэгч Хавсралт 12-д заасан ерөнхий шаардлагын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин болон орон нутгийн харилцааны төлөвлөгөөг боловсруулж Зөвлөх-Хяналтын багаар хянуулан баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

4.7.3. Ажлын талбай дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг бүрэн хангаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж ажиллана.

4.7.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг удаа дараа биелүүлээгүй ажилтныг ажлын талбайд нэвтрүүлэхгүй.

4.8. Чанарын баталгаат хугацаа

4.8.1. Гүйцэтгэгч Гэрээний шаардлагуудыг хангаж ажиллаж буйг харуулах чанарын хяналт баталгаажуулалтыг гүйцэтгэнэ. Чанарын хяналтын төлөвлөгөөг Зөвлөх-Хяналтын багаар хянуулж, батлуулах бөгөөд чанарын баталгааны хугацаа 3 жил байна.

4.9. Ажлын талбайтай холбоотой мэдээлэл

4.9.1. Ажил эхлэхээс өмнө Захиалагч нь Гүйцэтгэгчид ажлын талбай дээрх шаардлагатай мэдээлэл, түүнчлэн ус зүй, байгаль орчны болон бусад мэдээллийг үнэн зөв гаргаж өгнө.

4.9.2. Гүйцэтгэгчийн ажилд гарах болзошгүй эрсдэл, магадлашгүй ажлын зардал, бусад нөхцөл байдалтай холбоотой мэдээллээр хангана. Дээрх бүх мэдээ, мэдээлэл дараах мэдээллийг багтаасан гэж үзнэ. Үүнд:

- (a) Газрын гадаргуун нөхцөлийг багтаасан ажлын талбайн орчин байдал;
- (b) Ус зүйн болон цаг агаарын нөхцөл байдал;
- (c) Ажил гүйцэтгэх болон дуусгах, баталгаат засварын хугацаанд шаардлагатай ажил болон материалын хэмжээ;
- (d) Орон байр, хүн хүч, цахилгаан эрчим хүч, усны хангамж, бусад үйлчилгээтэй холбоотой Гүйцэтгэгчийн шаардлага энэхүү гэрээний 4.9, 4.11 дэх заалтуудаар хязгаарлахгүй;
- (e) Байгалийн болон хүний бүтээсэн гадаргуугийн нөхцөл байдлыг оролцуулан Ажлын талбайн хэлбэр ба шинж чанар;
- (f) Гидрогеологийн болон цаг уурын нөхцөлүүд;
- (g) Ажлын хэмжээ ба шинж чанар болон уг Ажлыг гүйцэтгэж дуусгах, аливаа доголдол эсхүл гэмтлийг засаж залруулахад шаардагдах Бараа материал;

22

Энэхүү гэрээний төрийн болон гайбаны нууцтай хамтаргах тул өөр бусад этг гэдэг хувиар тархах, нийтийн хүртээх бодогдох хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этг гэдэг хуульд тасны дагуу харилцааг хүлээлгэх болно.

"МТЗ" ТӨХК

"УБТЗ" ХНН

ИЯ БОЛСОН

НУУЦ

(h) Ажлын талбайд нэвтрэх ажиглагчдын байр, байгууламжууд, ажиллах хүчин, цахилгаан хангамж, тээвэр, ус болон бусад үйлчилгээнүүдийн талаарх Гүйцэтгэгчийн шаардлагууд.

4.9.3 Захиалагч нь Гүйцэтгэгчид гаргаж өгч буй аливаа мэдээлэл эсвэл өгөгдөл гол асуудлынхаа хувьд үнэн зөв, бүрэн дүүрэн эсвэл хангалттай гэдэгт баталгаа гаргаж байгаа бөгөөд тийм мэдээлэл эсхүл өгөгдлийн аливаа алдаа, дутуу дулимаг байдал болон тодорхой бус байдлын төлөө хариуцлага хүлээх болно.

4.10. Гэрээний үнэ болон Ажил гүйцэтгэж дуусгах хугацааны хангалттай байдал

4.10.1. Гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол Гэрээний үнэ нь Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хүлээсэн бүх үүрэг болон уг Ажлын зураг төсөл, инженеринг, худалдан авалт, бүтээн байгуулалт, туршилт болон ашиглалтанд хүлээн авалтыг зохих ёсоор хийж доголдолыг засаж залруулахад зайлшгүй шаардлагатай бүх зүйлсийг багтаасан байна.

4.11. Урьдчилан харах боломжгүй хүндрэл

4.11.1. Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал гэдэг нь Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх үед талбай дээр тулгарах байгалийн гамшиг, хүний үйлдэл, бусад саад тотгорыг хэлэх бөгөөд үүнд цаг агаарын нөхцөл байдал хамаарахгүй.

4.11.2. Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан таамаглах боломжгүй гэж үзэх хор хөнөөлтэй нөхцөл байдалтай тулгарвал тэр даруй Зөвлөх-Хяналтын багт мэдэгдэл өгнө.

4.11.3. Мэдэгдэлд бодит нөхцөл байдал, Гүйцэтгэгч яагаад урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал гэж үзсэн шалтгааныг тодорхой бичнэ. Гүйцэтгэгч нь бодит нөхцөл байдлын шинж чанар, боломжит хэмжигдэхүүнийг ашиглан Зөвлөх-Хяналтын багийн заавар, зөвлөмжийн дагуу гүйцэтгэх ажлаа үргэлжлүүлнэ. Хэрэв заавар, зөвлөмжийн дагуу өөрчлөлт орохоор бол гэрээний 13 (Өөрчлөлт болон тохируулга)-т заасныг мөрдөнө.

4.11.4. Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бодитой үүссэнээс шалтгаалан ажил хойшлогдох, зардал нэмэгдэхээр бол Гүйцэтгэгч нь энэ талаар мэдэгдэл өгөх эрхтэй.


4.11.5. Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол гэрээний 8.4 (Ажил дуусах хугацааг сунгах)-т заасны дагуу гэрээт ажлын хугацааг сунгана.


4.11.6. Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол гэрээнд (Ажил дуусах хугацааг сунгах) заасны дагуу гэрээт ажлын хугацааг сунгах ба үүнтэй холбоотой зайлшгүй гарах нэмэгдэх зардлыг Талууд харилцан тохиролцож, гэрээний үнэд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.

4.12. Бусдын газар болон байгууламжид нэвтрэх эрх

4.12.1. Гүйцэтгэгч нь ажлын талбайд нэвтрэх зардлыг оролцуулан шаардлагатай бусдын газарт нэвтрэх тусгай эсхүл түр хугацааны эрх авахад шаардагдах бүх зардал, төлбөрийг хариуцна. Гүйцэтгэгч нь мөн өөрийн эрсдэл ба зардлаар ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай Ажлын талбайн гаднах аливаа нэмэлт байгууламжуудыг олж авна.

Эндхүү гэрээ нь торийн болон албаны нууцад хамаархал тул өөр бусад этгээдээ хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биечүүд зэрүүг аливаа этгээдээ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

МТЗ ТӨХК 

"УБТЗ" ХНН 

ИЛ БОЛСОН

МУУЦ

4.13. Хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх

4.13.1. Гүйцэтгэгч нь олон нийтийн амгалан тайван байдалд саад учруулахгүй, нийтийн болон бусдын, Захиалагчийн эзэмшлийн бүх зам болон бусад өмч хөрөнгөд нэвтрэхдээ хүндэтгэлтэй хандах, тэдгээрийг зүй бусаар эзэмшиж, ашиглахаас зайлсхийнэ.

4.14. Технологийн болон түр зам ашиглах

4.14.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмж тээвэрлэх, тээврийн хэрэгсэл, ажилчид зорчих зориулалттай Технологийн болон түр замыг ашиглах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний болон бусад байдлаар эвдэрч, гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Үүнд:

- (a) өөрийн ашиглах замын ашиглалтад хяналт тавих, арчлалтыг хариуцах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- (b) замын дагуух шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ тавихдаа холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байх;
- (c) Захиалагч зам ашиглалтаас үүдэлтэй Гүйцэтгэгчийн буруутай ямар нэгэн нэхэмжлэлийг хариуцахгүй.

4.15. Бараа, материалын тээвэрлэлт

4.15.1. Гүйцэтгэгч нь Ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараанууд болон бусад зүйлийг савлах, ачих, тээвэрлэх, хүлээн авах, буулгах, хадгалах болон хамгаалах ажил болон зардлыг хариуцна.

4.16. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж

4.16.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор худалдан авсан машин, техник, тоног төхөөрөмж нь Гүйцэтгэгчийн өмч байх бөгөөд эдгээрийг Ажлын талбайд авчирсан бол Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж нь зөвхөн уг Ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан гэж тооцно.

4.16.2. Гүйцэтгэгч ажлын талбайгаас ямар нэгэн тоног төхөөрөмжийг Зөвлөх-Хяналтын багийн зөвшөөрөлгүйгээр зөөвөрлөхгүй. Гэхдээ ажлын талбайн гаднах бараа материалыг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл шаардлагагүй.


4.17. Байгаль орчныг хамгаалах

4.17.1. Гүйцэтгэгч нь ажлын талбайд болон гадна талд байгаль орчин хамгаалах арга хэмжээг бүх шатанд авах бөгөөд бохирдол дуу чимээнээс үүдэлтэй хүнд учруулах хор уршгийг хязгаарлана. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас болж хэт дулаан ялгаруулалт үүсэх, хөрсний гадаргуу голын сав газрыг гэмтээх нь холбогдох хууль эсхүл шаардлагад заасан үнэлгээнээс хэтрүүлэхгүй байна гэдэгт баталгаа өгнө.

4.18. Цахилгаан, ус болон хий

4.18.1. Гүйцэтгэгч нь өөрт шаардагдах цахилгаан, ус, хий, цахилгаан холбооны болон бусад үйлчилгээг хангах асуудлыг хариуцаж холбогдох зардлыг зохих этгээдэд төлнө.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамгаарах тул өөр бусад этгээдэд хувиарж тархах, нийтийн хуртэл болзолыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй олног этгээдэд хууль заасны дагуу хариуцаж хүлээж эх болно. МТЗ ТӨХК "УБТЗ" ХНН





ИЛ БОЛСОН

ГҮҮЦ

4.19. Ажлын явцын тайлан

4.19.1. Ажлын явцын талаарх сарын тайлангуудыг Гүйцэтгэгч бэлтгэн гурван (3) хувийг үүнээс нэг хувийг электрон хэлбэрээр хоёр хувийг нь цаасан хэлбэрээр Зөвлөх-Хяналтын багт гардуулан өгнө. Ажлын явцын анхны тайлан нь Ажил эхлэх өдрөөс хойшхи эхний хуанлийн сарын эцэс хүртэлх хугацааг хамарна. Тайлангуудыг түүнээс хойш сар тутам гаргах бөгөөд тайлан бүрийн хамрах хугацааны сүүлчийн өдрөөс хойш долоо (7) хоногийн дотор өгч, Зөвлөх-Хяналтын багаар хянуулж батлуулсан байна.

4.19.2. Батлагдсан маягтын дагуу мэдээлэл, тайланг хүргүүлнэ.


4.19.3. Зөвлөх-Хяналтын баг 7 хоног тутамд гүйцэтгэлийн тайлангийн хурлыг зохион байгуулна.

4.19.4 Ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авсан гэрчилгээнд заасан дуусах өдрийн байдлаар хийгдээгүй үлдсэн бүх ажлыг Гүйцэтгэгч хийж дуустал тайлагналт үргэлжилнэ.

4.19.5. Тайланд дараах зүйлс багтана. Үүнд:

- (a) Товч тойм;
- (b) Төлбөрийн гэрчилгээ;
- (c) Материалын гарал үүсэл, лабораторын дүгнэлт эсвэл үйлдвэрлэгчийн сертификат;
- (d) Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, худалдан авалт, үйлдвэрлэл, Ажлын талбайд хүргэлт, барьж байгуулалт болон туршилтын үе шат бүрийг багтаасан ажлын явцын бүдүүвчүүд болон нарийвчилсан танилцуулгууд;
- (e) Үйлдвэрлэлийн явц болон Ажлын талбай дээрх ажлын явцыг харуулсан гэрэл зургууд;
- (f) Монголд улсад үйлдвэрлэгдэж буй бараа бүтээгдэхүүн материалуудын гол зүйл тус бүрийн үйлдвэрлэлийн хувьд үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэгчийн байршил, үйлдвэрлэлийн хувь хэмжээ болон дараах зүйлсийн бодит эсвэл төлөвлөж буй хугацаа:
 - i. үйлдвэрлэл эхлэх;
 - ii. Гүйцэтгэгчийн үзлэг шалгалтууд;
 - iii. Тохируулга, зүгшрүүлэлт;
 - iv. тээвэрлэлт болон Ажлын талбайд ирэх.
- (g) Гэрээний 6.7-д [Гүйцэтгэгчийн ажиллагсадын болон тоног төхөөрөмжийн бүртгэлүүд]-т заасан дэлгэрэнгүй зүйлс;
- (h) Чанарын баталгаажуулалтын баримт бичгүүд, туршилтын үр дүнгүүд болон Материалуудын гэрчилгээний хуулбар;
- (i) Өөрчлөлтүүдийн жагсаалт гэрээний 2.4 [Захиалагчийн нэхэмжлэлүүд]-ийн дагуу өгсөн мэдэгдлүүд] болон Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу өгсөн мэдэгдлүүд;
- (j) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчны болон Орон нутгийн харилцаатай холбоотойгоор хэрэгжүүлсэн ажил, гарсан зөрчил, цаашид авах шаардлагатай арга хэмжээний тухай тоо баримт бүхий дэлгэрэнгүй тайлан.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамгаарах тул нэр бусад этгээдэд хувиалж тархах, нийтийн хүртээл бэлгэхийг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харгуулыг хүлээлгэх болно. МТЗ ТӨХК "УБТЗ" ХНН.....





ИЛ БОЛСОН

-44-

УУЦ

(к) Гэрээний дагуу ажлыг дуусгахад саад учруулж болох аливаа үйл явдал эсхүл нөхцөл байдал болон саатлыг гэтлэн давах үүднээс авч явуулсан (эсвэл авч явуулах) арга хэмжээний дэлгэрэнгүй танилцуулга бүхий ажлын бодит явц болон төлөвлөсөн явцыг харьцуулсан харьцуулалт;

4.20. Ажлын талбайн харуул хамгаалалт

4.20.1. Гүйцэтгэгч нь нэвтрэх эрхгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байх асуудлыг хариуцна.

4.20.2. Нэвтрэх эрх бүхий этгээдийг Гүйцэтгэгчийн ажилтнууд, Захиалагчийн ажилтнууд болон Хамааралтай ажил гүйцэтгэгчдийн эрх бүхий ажилтнууд гэж Захиалагчаас Гүйцэтгэгчид мэдэгдсэн бусад ажилтнаар хязгаарлана.

4.21. Ажлын талбай дахь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа

4.21.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрсөн ажлын талбайн хүрээнд өөрийн үйл ажиллагааг явуулах бөгөөд ажлын талбайд тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, хог хаягдлын цэг, түр байгууламжийг эмх цэгцтэйгээр байрлуулна. Ажил дуусахад ашигласан ахуйн, үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулж, ажлаас үүдэлтэй бохирдлыг арилгах бөгөөд шаардлагатай тохиолдолд байгалийн тогтоцын дагуу нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэнэ.

4.21.2. Ажил гүйцэтгэж байх явцад Гүйцэтгэгч нь ажлын талбайд байгаа бүх саадуудыг арилгаж, Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж эсвэл илүүдэл материалуудыг хадгалах ёстой газарт нь хадгалж эхүл зайлуулна. Гүйцэтгэгч нь Ажлын талбайгаас хэлтэрхийнүүд, хог хаягдал болон цаашид ашиглахгүй Түр зуурын байгууламжуудыг зөөвөрлөж цэвэрлэж байна.

4.21.3. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай байж болох тоног төхөөрөмж, бараа материалыг ажлын талбайд түр үлдээж болно.

4.21.4. Төмөр замын шугамын дээд бүтцийн угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч нь Зүүнбаянгаас нааш хийгдэж буй Захиалагчийн гүүр хоолойн ажлыг хүлээлгүйгээр өөрсдөө түр зам барьж ажлаа саадгүйгээр үргэлжлүүлнэ. Энэхүү түр зам барихтай холбоотой зардлыг Захиалагч бүрэн санхүүжүүлнэ. Захиалагчийн хүсэлтээр Төмөр замын шугамын дээд бүтцийн угсралтын ажил гүйцэтгэх ажлын зураг төсөл, төсөв, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх, магадлан итгэмжлэлээр оруулах ажлыг Гүйцэтгэгч хийсэн тохиолдолд түүнтэй холбоотой гарсан зардлыг Захиалагч бүрэн санхүүжүүлнэ.

4.22. Археологийн олдвор

4.22.1. Ажлын талбай дээрээс археологи болон палеонтологийн олдвор олдсон тохиолдолд хамгаалалтад авч Захиалагчид мэдэгдэнэ.

4.23. Ажлын талбайн газрын нөхцөл

4.23.1. Гэрээ байгуулсан өдрөөс өмнө ажлын талбай дээрх газрын хэвлийн болон гидрогеологийн нөхцөлүүдтэй (Ажлын талбайн нөхцөлүүд) холбоотой гэрээний 4.10

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцай хамаарах тул өөр бусад этгээдэд хувиулж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцаага хүлээгэгч болно.

"МТЗ" ТӨХ

"УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

МУУЦ

дахь заалтад заасан мэдээлэл ба өгөгдлүүдийг Захиалагч Гүйцэтгэгчийн мэдээлэлд зориулан бэлэн болгосон байна.

4.23.2. Хэрэв уг Ажил гүйцэтгэж байх явцад Гүйцэтгэгч урьдчилан харах бололцоогүй Ажлын талбайн нөхцөлүүдтэй учирвал, Гүйцэтгэгч энэ тухай аль болох богино хугацаанд бичгээр Захиалагчид мэдэгдэнэ.

4.23.3. Гэрээний 4.23.2-ын дагуу Гүйцэтгэгчийн гаргах мэдэгдэлд тухайн Ажлын талбайн нөхцөлүүдийг тодорхойлж, Гүйцэтгэгч яагаад урьдчилан харах боломжгүйд тооцож байгаа шалтгаанаа тайлбарласан байна. Тухайн нөхцөлд зохистой боломжийн арга хэмжээ авч, Гүйцэтгэгч уг Ажлыг үргэлжлүүлэн хийх бөгөөд Зөвлөх-Хяналтын багийн өгсөн зааварчилгааг дагаж мөрдөнө. Хэрэв зааварчилгаа нь өөрчлөлт оруулахуйц зааварчилгаа гэж тооцогдохоор байвал гэрээний 13 дахь заалтыг хэрэглэнэ.

4.23.4. Хэрэв уг ажлыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгч урьдчилан харах боломжгүйд тооцогдох Ажлын талбайн нөхцөлүүдтэй учирвал гэрээний 4.23.2-ын дагуу мэдэгдэл өгч, тийм нөхцөл байдлаас болж ажил саатаж, зардал гарсан бол төлбөрөө нэхэмжлэн авах ба ажил дуусгах хугацаа саатсан эсвэл саатахаар бол гэрээний 8.4 дэх заалтын дагуу саатсан хугацаагаар ажлын хугацааг сунгуулах эрхтэй.

ТАВ.ЗУРАГ ТӨСӨЛ

5.1. Ерөнхий зураг төслийн үүрэг

5.1.1. Гүйцэтгэгч нь Ажил эхлэх өдрөөс өмнө Захиалагчийн шаардлага, зураг төсөл болон гэрээний 4.9.1, 4.9.2 дэх заалтад дурдсан өгөгдөл мэдээллүүдийг нягтлан шалгана. Гүйцэтгэгч нь өөрийн гардан гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл болон баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлийн үнэн зөвийг хариуцна.

5.1.2. Захиалагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн ажлыг гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл, зураг төсөл, заавар зааварчилгаа, мэдээ мэдээлэл, баримт материал, бичиг баримт, судалгаа шинжилгээний үнэн зөвийг өөрөө хариуцах бөгөөд түүний алдаатай, буруу ташаа байдлаас үүдэн гарах хохирол, төсвийн үнийн зөрүү, эрсдлийг хариуцна.

5.2. Гүйцэтгэгчийн баримт бичиг


- 5.2.1. Гүйцэтгэгчийн баримт бичгүүд дараах баримт бичгээс бүрдэнэ. Үүнд:
 - (a) Захиалагчийн шаардлагын дагуу Гүйцэтгэгчийн боловсруулах зураг төсөл, өгөгдлүүд, баримт бичиг болон программ хангамж;
 - (b) Холбогдох зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгүүд;
 - (c) Гэрээний 5.6 [Барьж байгуулснаараа байгаа байдлын талаарх баримт бичгүүд] болон 5.7 [Ашиглалт үйлчилгээний зааварчилгаанууд] дахь заалтуудад дурдсан баримт бичгүүд;
 - (d) Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн боловсруулж нийлүүлсэн бусад гэрэл зураг (3D загварыг оролцуулан), тооцоон болон техникийн шинж чанартай бусад өгөгдөл, мэдээлэл.

5.2.2. Гүйцэтгэгчийн баримт бичгүүд нь гэрээний 1.3 [Хэрэглэх хууль ба хэл] дахь заалтад тодорхойлсон хэл дээр бичигдсэн байна.


5.3. Гүйцэтгэгчийн амлалт

5.3.1. Гүйцэтгэгч нь зураг төсөл, Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, ажлын гүйцэтгэл нь дараах зүйлтэй нийцснийг баталж байна. Үүнд:

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцанд хамаарах тул өөр бусад этгээдэд хувиар тархах, нийтийн хүртээл болгохыг хорьсон. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээжэх болно.

"МТЗ" ТӨХК 

"УБТЗ" ХНН



ИЛ БОЛСОН

- (a) Инженерингийн болон барилгын ажлын сайн практик;
- (b) Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт ;
- (c) Өөрчлөлтүүдийг тухай бүр хийсэн.

5.4. Техникийн стандарт болон журам

5.4.1 Зураг төсөл, Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, ажлын гүйцэтгэл нь холбогдох дүрэм, журам, стандарт, Захиалагчийн шаардлагад нийцсэн байна.

5.4.2 Гэрээ байгуулсан өдрөөс хойш холбогдох стандарт өөрчлөгдсөн, шинэ стандарт хүчин төгөлдөр болсон бол Гүйцэтгэгч нь Захиалагчид мэдэгдэл өгнө. Захиалагч мэдэгдлийг хүлээн авч, дагаж мөрдөх эсэх талаар зааварчилгаа өгнө.

5.5. Гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн талаарх баримт бичиг

5.5.1 Гүйцэтгэсэн ажлын дэлгэрэнгүй танилцуулга, гүйцэтгэсэн ажил буюу барьж байгуулсан байдлаар нь харуулсан бүртгэл /ил далд ажлын акт/-үүдийн иж бүрдлийг Гүйцэтгэгч тухай бүр шинэчилж байна. Эдгээр бүртгэлийг Ажлын талбай дээр хадгалах бөгөөд зөвхөн энэхүү заалтын зорилгод ашиглагдах болно. Урьдчилсан байдлаар ашиглалтанд хүлээн авахаас өмнө тэдгээр бүртгэлийн гурван хувийг цаасаар, нэг хувийг электрон хэлбэрээр Захиалагчид өгнө.

5.5.2 Түүнчлэн, Гүйцэтгэгч нь бүх ажлыг барьж байгуулсан байдлаар нь харуулсан ажлын зургуудыг гэрээний 5.2 [Гүйцэтгэгчийн баримт бичгүүд] дахь заалтын дагуу хянуулахаар Захиалагчид өгнө. Гүйцэтгэгч нь тэдгээрийн хэмжээ, референсийн систем болон бусад холбогдох дэлгэрэнгүй зүйлсэд Захиалагчийн зөвшөөрөл авна.

5.5.3 Урьдчилсан байдлаар ашиглалтанд хүлээн авсан тухай гэрчилгээ гаргахаас өмнө Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагын дагуу уг ажилтай холбоотой барьж байгуулсан байдлаар нь харуулсан зургийн хуулбарыг тусгайлан заасан тоо болон төрлөөр Захиалагчид өгнө. Захиалагч эдгээр баримт бичгийг хүлээн автал уг ажлыг урьдчилсан байдлаар ашиглалтанд хүлээн авсанд тооцохгүй.

5.6. Ашиглалт, үйлчилгээний зааварчилгаа

5.6.1 Урьдчилсан байдлаар ашиглалтанд хүлээн авахаас өмнө Гүйцэтгэгч нь тухайн ажлын үр дүнг зориулалтын дагуу ашиглах, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохируулах, зүгшрүүлэх, засварлах, ашиглах, үйлчилгээ хийх урьдчилсан зааварчилгааг Захиалагчид хангалттай дэлгэрэнгүйгээр гаргаж өгөх үүрэгтэй.

5.6.2 Энэ зорилгоор ашиглалт, үйлчилгээний эцсийн зааварчилгаанд заасан бусад дэлгэрэнгүй зааварчилгааг Захиалагч хүлээн авах хүртэл уг ажлыг урьдчилсан байдлаар ашиглалтанд хүлээн авсанд тооцохгүй.



5.7. Зураг төслийн алдаа

5.7.1 Захиалагчийн шаардлага, референс зургууд, өгөгдлүүд, Гүйцэтгэгчийн болон бусад баримт бичигт алдаа, зерчил илэрвэл буруутай этгээдийн зардлаар нэн яаралтай засаж залруулна.

ЗУРГАА. АЖИЛТАН БА АЖИЛЛАХ ХҮЧ

6.1. Ажилтан болон ажиллах хүч элсүүлэх

Энэхүү гэрээ нь төрийн болон алданы мэдээлэл хамгаалах тусгай зориулалттай бөгөөд энэ гэрээг хувиар тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүрээлэх болно.
"МТЗ" ТӨХК..... "УБТЗ" ХНН.....



6.1.1. Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэхээр дотоод, гадаадын ажилтан ажиллуулах, тэдний цалин хөлс, амьдрах байр, хоол унд, унаа тээврийг зохион байгуулах ажлыг хариуцна.

6.2. Захиалагчид ажилладаг хүмүүс

6.2.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилтнуудаас ажиллах хүч элсүүлэхгүй бөгөөд элсүүлэх гэж оролдохыг хориглоно.

6.3. Ажилтны ахуй хангамж

6.3.1. Гүйцэтгэгч нь ажилтныг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартын шаардлага хангасан, эрүүл аюулгүй ажлын болон ахуйн байр, ажиллах нөхцөлөөр хангана. Шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэх ба хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажилтнуудад хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох, хөдөлмөрийн хэвийн нөхцөл бүрдүүлэх болон бусад зохион байгуулалтын арга хэмжээ авна.

6.4. Эрүүл мэнд, аюулгүй байдал

6.4.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой дараах зүйлийг хариуцна:

- (a) Ажилд хамаарах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой бүхий л асуудлыг;
- (b) Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах, ажлын байрны болон тухайн газар орны цаг уурын нөхцөлд эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй ажилтныг төслийн ажилд оролцуулахгүй байх;
- (c) Ажлын талбай, үйлдвэрлэлийн орчинд гэрээгээр гүйцэтгэх ажлаас шалтгаалан гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, аюул, осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах.

6.4.2. Гүйцэтгэгч нь Хавсралт 12-д заасан Ерөнхий шаардлагын дагуу Ажлын талбайд мөрдөх журмыг боловсруулж, мөрдүүлнэ.

6.4.3. Журамд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

- (a) Ажлын талбайн эмх цэгц, харуул хамгаалалт;
- (b) ХАБЭА-н хяналт;
- (c) Байгаль орчны хяналт;
- (e) Тоног төхөөрөмж, машин механизмын хяналт;
- (f) Галын аюулаас урьдчилан сэргийлэх;
- (g) Ослын мэдээлэл дамжуулах.

6.4.4. Гүйцэтгэгч нь аливаа осол гармагц болсон явдлын дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид хүргүүлнэ.

6.4.5. Гүйцэтгэгч нь бүртгэл хөтөлж, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, болон өмчийн эвдрэл, хохиролтой холбоотой тайлан, ослын судалгааг Захиалагчийн шаардаж болох байдлаар гаргана.

6.5. Ажилтныг ажиллах нөхцөлөөр хангах

Энэхүү гэрээ нь тариус болон албаны нүүдэл захиарах тус өөр бусад тусгайд хувиаж тараах, нийтийн хуртгай болгохыг хориглоно. Энэ шаардлагыг бие бүтээгчүүд аливаа эмгэгид хуульд заасны дагуу харивцлага хүлээлгэх болно.

"МТЗ" ТӨХК

"УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

48

6.5.1. Техникийн шаардлагад бөрөөр заасангүй бол Гүйцэтгэгч нь өөрийн ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэхээс гадна шаардлагатай түр орон сууцаар хангасан байна. Гүйцэтгэгч нь ажлын талбайд дагаж мөрдөх дотоод дэг журам, ажил амралтын дэглэм, зохион байгуулалт, засвар, үйлчилгээг хариуцна.

6.5.2. Захиалагчийн ажилтан, Зөвлөх-Хяналтын багийг оролцуулан дараах байдалтай аливаа этгээдийг ажлын талбайд ажиллуулах болон оруулахыг хориглоно. Үүнд:

- (a) Аливаа зүй бус үйлдэл байнга гаргадаг;
- (b) Ажил үүргээ хийх чадваргүй эсхүл хайхрамжгүй ханддаг;
- (c) Дүрэм, журам, заавар, Гэрээний аливаа заалтыг дагаж мөрдөөгүй;
- (d) Бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал эсхүл байгаль орчинд хор хохирол учруулж болзошгүй этгээдийг;
- (e) Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн аливаа этгээд

6.6. Гүйцэтгэгчийн ажилтан

6.6.1. Гүйцэтгэгчийн ажилтан мэргэшсэн, ур чадвартай байна. Зөвлөх-Хяналтын баг болон Захиалагч нь ажлын талбайд, ажил гүйцэтгэхэд ажиллуулж буй Гүйцэтгэгчийн төлөөлөгч, ажилтанг дараах тохиолдолд солихыг шаардаж болно. Үүнд:

- a. Ажилтнаас хууль бус үйлдэл хийхийг шаарддаг;
- b. Хариуцсан ажилдаа хайхрамжгүй хандаж, хангалтгүй гүйцэтгэдэг, ажлын ур чадвар хангалтгүй;
- c. Гэрээний үүргээ биелүүлдэггүй, хариуцлагаа ухамсарладаггүй, гэрээний заалтыг дагаж мөрддөггүй;
- d. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хамгаалахад нөлөөлөх зүй бус үйлдэл, хандлагыг удаа дараа гаргасан.

6.7. Гүйцэтгэгчийн ажилтнуудын болон тоног төхөөрөмжийн бүртгэл

6.7.1. Гүйцэтгэгч нь Ажлын талбайд байгаа тоног төхөөрөмж, ажиллаж буй удирдах ажилтан, мэргэжлийн инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.

6.8. Ёс зүйгүй үйлдэл

6.8.1. Гүйцэтгэгч болон Захиалагч, Зөвлөх-Хяналтын багийн ажилчдын дунд хууль бус, догшин ширүүн, ёс зүйгүй үйлдэл гарахаас сэргийлэх, амгалан тайван байдлыг хангах, Ажлын талбай, түүний ойр орчимд байгаа хүмүүс болон өмч хөрөнгийг хамгаалах зохих ёсны арга хэмжээнүүдийг цаг үргэлж авч байна.

ДОЛОО. МАТЕРИАЛ БА АЖЛЫН УР ЧАДВАР

7.1. Гүйцэтгэх байдал

7.1.1 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдээ,

- (a) Гэрээнд заасан аргаар;
- (b) Хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагын дагуу ур чадвартай, нягт нямбай;

Энэхүү гэрээ нь өөрийн болон албаны нууцад хамгаалах зүйл бөгөөд бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хуртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биечүүтгэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцаж хураагдах болно. "УБТЗ" ТӨЖ "УБТЗ" ХНН

- (с) Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулах,
- (d) Ажил гүйцэтгэхэд шаардлагатай материалыг ашиглахаас өмнө зөвшөөрөл авах зорилгоор материалын дараах сорьц, дээж болон холбогдох мэдээллийг Зөвлөх-Хяналтын багт танилцуулна
 - i. Материалын дээж болон сорьцыг;
 - ii. Зөвлөх-Хяналтын багаас зааварчилсан нэмэлт дээж сорьцыг.
- (e) Ажилд ашиглахаар төлөвлөсөн дээж тус бүрт гарал үүсэл, хаяг, шошго тавьсан байна.

7.2. Сорьц болон дээж

7.2.1 Гүйцэтгэгч нь материалын дээж болон сорьцыг авч гэрээний 5.2 [Гүйцэтгэгчийн баримт бичиг]-т заасны дагуу хянуулахаар Захиалагчид хүргүүлнэ. Дээж болон сорьц тус бүрт түүний гарал үүсэл, холбогдох бусад мэдээллийг тавьсан байна.

7.3. Үзлэг, шалгалт

7.3.1 Зөвлөх-Хяналтын баг болон Захиалагч шаардлагатай үед:

- (a) Ажлын талбайн хэсгүүд болон түүхий эд материал авдаг газарт нэвтрэх эрхтэй;
- (b) Ажил гүйцэтгэхэд шаардагдах материалууд болон хийц ур чадварыг шалгаж, үзлэг шалгалт, хэмжилт ба туршилт явуулж, материалын үйлдвэрлэлийн явцыг шалгах эрхтэй.

7.3.2 Гүйцэтгэгч нь Захиалагчийг ажлын талбайн хэсгүүд болон түүхий эд материал авдаг газарт нэвтрүүлж, хамгаалалтын хэрэгслээр хангаж, үзлэг, шалгалт явуулах боломж олгоно.


7.3.3 Далд ажлыг далдан битүүмжлэхээс өмнө шаардлагатай тохиолдолд Захиалагчид мэдэгдэх бөгөөд Захиалагч нь шалтгаангүйгээр саатуулалгүй уг ажлыг шалгаж, хэмжиж турших эсхүл шалгах шаардлагагүй тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид шуурхай өгнө. Хэрэв Гүйцэтгэгч тийм мэдэгдэл өгөөгүй бол Гүйцэтгэгч нь Захиалагч шаардсан тохиолдолд Ажлын далдан битүүмжилсэн тодорхой хэсгийг хяналтын журмаар буцаан нээж шаардлагатай үзлэг шалгалт явуулж болно.

7.4. Тохируулга, зүгшрүүлэлт

7.4.1 Энэхүү заалт нь Гэрээнд заасан бүх тохируулга, зүгшрүүлэг хамаарна.

7.4.2 Ажлын талбайд хийгдэх ёстой тохируулга, зүгшрүүлэлтийг ажлын аль ч хэсэгт орхигдуулж болохгүй. Орхигдуулсан бол ажил гүйцэтгэх хугацааг сунгалгүйгээр Гүйцэтгэгчийн зардлаар тухайн орхигдуулсан хэсэгт шаардлагатай тохируулга, зүгшрүүлэлт хийхийг Зөвлөх-Хяналтын баг нь Гүйцэтгэгчээс шаардана.

7.4.3 Гүйцэтгэгч нь заасан тохируулга, зүгшрүүлэлтийг үр ашигтай явуулахад шаардлагатай бүх аппарат, туслалцаа, баримт бичиг, бусад мэдээлэл, цахилгаан, тоног төхөөрөмж, түлш, багаж, ажиллах хүч, материал (Гэрээгээр Захиалагч нийлүүлнэ гэж зааснаас бусад) болон туршлага, чадвартай ажилтнуудаар хангана.




ИЛ БОЛСОН

ГҮЙЦЭГ

7.4.4. Гүйцэтгэгч нь Зөвлөх-Хяналтын багийн материал, тоног төхөөрөмж болон бусад хэсэгт тохируулга, зүгшрүүлэлт хийх хугацаа болон газрыг тохиролцоно.

7.4.5. Зөвлөх-Хяналтын баг нь гэрээний 13 дахь заалтын дагуу тогтоосон тохируулга, зүгшрүүлэлтийн байршлыг өөрчлөх эсхүл нэмэлт тохируулга, зүгшрүүлэлт хийхийг Гүйцэтгэгчид зааварчилж болно. Хэрэв эдгээр өөрчлөгдсөн болон нэмэлт тохируулга, зүгшрүүлэлтээр тохируулга, зүгшрүүлэлт хийгдсэн материал хийц нь гэрээний дагуу шаардлага хангахгүй бол энэхүү өөрчлөлтөөр гарах зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

7.4.6. Зөвлөх-Хяналтын баг нь Гүйцэтгэгчид туршилтыг очиж үзэх эсэх мэдэгдлийг 24 цагаас багагүй хугацааны өмнө өгнө. Хэрэв Зөвлөх-Хяналтын баг нь зөвшөөрсөн хугацаанд тохируулга, зүгшрүүлэлтийн байршилд очихгүй бол Гүйцэтгэгч нь Зөвлөх-Хяналтын багийн зааварчилгаагүйгээр тохируулга, зүгшрүүлэлтийг явуулж болох ба Зөвлөх-Хяналтын багийг тохируулга, зүгшрүүлэлтийн үед байлцсан гэж үзнэ.

7.5. Үзлэг, тохируулга, зүгшрүүлэлтийн үр дүнг хүлээн авахаас татгалзах

7.5.1. Үзлэг, тохируулга, зүгшрүүлэлтийн үр дүнд ямар нэгэн эвдрэл гологдол гарсан бол Зөвлөх-Хяналтын баг нь шалтгааныг дурдсан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгөх бөгөөд Гүйцэтгэгч эвдрэл, гологдлыг засч, шаардлага хангасан гэдэгт баталгаа гаргаж өгнө.

7.5.2. Зөвлөх-Хяналтын баг нь эдгээр үйлдвэрлэл материал, хийцийг дахин туршихыг шаардвал ижил нөхцөлөөр туршилтыг давтан гүйцэтгэж болно.

7.6. Засаж залруулах ажил

7.6.1. Тохируулга, зүгшрүүлэлт, баталгааг үл харгалзан Захиалагч Гүйцэтгэгчид дараах зааварчилгааг өгч болох бөгөөд энэ нь үндэслэл бүхий холбогдох баримтуудаар нотлогдсон байна. Үүнд:

- (a) Гэрээнд заасан шаардлага хангаагүй бараа, материалыг ажлын талбайгаас нүүлгэн шилжүүлэх, солих;
- (b) Гэрээний дагуу хийгдээгүй ажлыг дахин гүйцэтгэх;
- (c) Урьдчилан харах боломжгүй үйл явдлын шалтгааныг арилгах эсхүл ажлын аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай ажлыг гүйцэтгэх.

7.6.2. Гүйцэтгэгч заасан хугацаанд Захиалагчийн болон түүний Зөвлөх-Хяналтын багийн үндэслэл бүхий зааварчилгааг дагаж мөрдөн, ажлыг гүйцэтгэх бөгөөд гэрээний 7.6.1.с-д заасан байдал үүссэн тохиолдолд яаралтай хийж гүйцэтгэх бөгөөд түүнтэй холбоотой зардлыг Захиалагчаас гаргуулна.

7.6.3. Гүйцэтгэгч зааварчилгааг мөрдөхгүй бол Зөвлөх-Хяналтын баг нь ажлыг гүйцэтгүүлэхээр өөр гүйцэтгэгчийг ажиллуулах эрхтэй. Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай төлбөрийг үндэслэл бүхий холбогдох баримтаар хангалттай нотлогдож байна гэж үзвэл Гүйцэтгэгч төлнө.

7.7. Материал, эд хөрөнгийн өмчлөл

7.7.1. Гэрээнд заасны дагуу хийж гүйцэтгэсэн ажил болон Ажлын талбайд буулгасан материал нь /төлбөрийг нь Захиалагч төлсөн тохиолдолд/ Захиалагчийн өмч байна.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамгаарах тул өөр бусад этгээдэд хувиар тархах, нийтийн хүртээл бэлгэхийг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харууцлага хүлээлгэх болно.

"ИТЗ" ТӨХК

"УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

НУУЦ

7.7.2 Харин тухайн ажлыг хийж гүйцэтгэхийн тулд Урьдчилгаа болон бусад төлбөрөөр Гүйцэтгэгчийн худалдан авсан машин, тоног төхөөрөмж, техник, сэлбэг хэрэгсэл нь Гүйцэтгэгчийн өмчлөлд шилжинэ.

7.8. Орон нутгийн хураамж

7.8.1. Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь дор дурдсан зүйлд зориулан орон нутгийн газар эзэмшлийн болон түрээсийн бүх төлбөр, хураамжийг төлбөрүүдийг төлнө. Үүнд:

- (a) Ажлын талбайн гаднаас олборлож буй түгээмэл тархацтай ашигт малтмалууд;
- (b) Хог хаягдлын төлбөр гэх мэт.

7.9. Барьцаалах

7.9.1. Гэрээний дагуу Ажил гүйцэтгэсний төлөө эсхүл аливаа үйлчилгээ үзүүлж, материал нийлүүлсний төлөө Гүйцэтгэгч болон Захиалагчийн ямар нэг хөрөнгийг барьцаалуулахгүй бөгөөд Захиалагч, Гүйцэтгэгчийн ажилтан, Захиалагчийн эсхүл Гүйцэтгэгчийн өмч хөрөнгийг барьцаалах, битүүмжлэх, өөрийн нэр дээр шилжүүлэхгүй.

7.10. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж

7.10.1. Гүйцэтгэгч ажлын талбайд авчирсан Гүйцэтгэгчийн бүх тоног төхөөрөмж нь зөвхөн уг Ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан байх бөгөөд уг Ажлыг гүйцэтгэхэд Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж цаашид ашиглахгүй болох хүртэл Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр уг тоног төхөөрөмжийг Ажлын талбайгаас авч явахыг (эсвэл авч явахыг зөвшөөрөхгүй) хориглоно.

7.10.2. Ажиллагсад, Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж эсхүл материалыг ажлын талбай руу эсхүл Ажлын талбайгаас тээвэрлэхэд ашиглагддаг тээврийн хэрэгслийн хувьд гэрээний 7.10.1-д зөвшөөрөл шаардлагагүй.

7.11. Аюултай материал

Гүйцэтгэгч нь дараах зүйлсийг хариуцна:


- (a) Ажлыг гүйцэтгэхэд болон энэхүү гэрээний дагуу хүлээсэн бусад үүргээ биелүүлэхэд Гүйцэтгэгчийн ашигласан, бий болгосон аюултай, хортой, эсхүл бохирдсон материал, бодисуудыг (холбогдох Хууль тогтоомж болон Захиалагчийн шаардлагуудын дагуу) ашиглах, хадгалах болон зайлуулах;
- (b) Ажлыг гүйцэтгэх болон энэхүү гэрээний дагуу хүлээсэн бусад үүргээ биелүүлэх явцад ажлын талбай болон үйлдвэрлэлийн орчинд учруулсан бохирдлыг арилгах, засаж залруулах.

НАЙМ. АЖИЛ ЭХЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, ХОЙШЛУУЛАХ, ТҮР ЗОГСООХ

8.1. Ажил эхлэх

8.1.1. Төмөр замын дээд бүтцийн ажлыг Гүйцэтгэгч нь ажил эхлэхээс өмнө Захиалагчийн хүлээн авсан төмөр замын доод бүтцийн ажлыг Зөвлөх-Хяналтын багтай хамтран шалгаж, акт үйлдэж хүлээн авах ба илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулсан талаарх мэдэгдлийг хүлээн авч, баталгаажуулснаар ажлыг эхлүүлнэ.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамраах тул сар бусад этгээдэд хувилж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээгээх болно.

"МТЗ" ТӨХК. 

"УБТЗ" ХНН. 

ИЛ БОЛСОН

ТҮҮЦ

(a) Энэхүү гэрээний хавсралт 3,4-т заасан хугацаанд ажлыг эхлүүлнэ.

8.2. Урьдчилсан байдлаар хүлээн авах хугацаа

8.2.1. Гүйцэтгэгч дараах зүйлүүдийг хийж гүйцэтгэнэ:

- (a) Гэрээний Хавсралт 4-т тодорхой заасан батлагдсан графикт хугацаанд төслийн гол үе шатуудын ажлыг хийж гүйцэтгэх;
- (b) Ажлыг урьдчилсан байдлаар хүлээлгэн өгөх буюу гэрээний хавсралтад заасан хугацаанд ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгөх.

8.3. Төлөвлөлт болон ажлын хуваарь

8.3.1. Ажлын гүйцэтгэлийг Хавсралт 3,4-т заасны дагуу төлөвлөсөн байна.

8.3.2. Гүйцэтгэгч өмнөх төлөвлөгөө бодит ахиц дэвшил болон гүйцэтгэгчийн хүлээх үүрэгтэй нийцэхгүй, эсхүл Захиалагч хүсэлт гаргасан тохиолдолд өөрийн зардлаар дахин сайжруулсан төлөвлөгөө боловсруулж болно.

8.3.3. Гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд төлөвлөгөө тус бүрт дараах зүйлүүдийг багтаана:

- (a) Ажлын үндсэн үе шат бүрийн урьдчилсан төлөвлөгөө гэх мэт гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажил;
- (b) Гэрээний 5.2 дахь заалтын дагуу хугацааг авч хэлэлцэх [Гүйцэтгэгчийн бичиг баримт];
- (c) Гэрээнд заасан хяналт, шалгалт, тохируулга, зүгшрүүлэлтийн дараалал болон хугацааны сонголт;
- (d) Дараах танилцуулга, мэдээг багтаасан туслах тайлан:
 - i. Ажлын гол үе шат бүрийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилготой гүйцэтгэгчийн арга зүйн ерөнхий танилцуулга;
 - ii. Гол үе шат бүрийн гүйцэтгэгчийн бие бүрэлдэхүүний тоог ангилал тус бүрээр, гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг төрөл тус бүрээр.

8.3.4. Захиалагчийн ажилтан болон ажил гүйцэтгэгчид үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа тус төлөвлөгөөнд үндэслэнэ.

8.3.5. Гүйцэтгэгч талаас ажлын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэх буюу гүйцэтгэлд саад учруулахуйц ирээдүйд учирч болох өөр тодорхой үйлдэл болон нөхцөл байдал үүссэн тохиолдолд Захиалагчид яаралтай мэдэгдэнэ.

8.4. Хугацаа сунгах

8.4.1. Гүйцэтгэгчийн ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаа эсхүл төслийн гол үе шатуудын заагийн үйл ажиллагаа гүйцэтгэх хугацаа дараах шалтгаануудын улмаас хойшилсон бол ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаа эсхүл төслийн гол үе шатуудын заагийн хугацааг сунгуулах эрхтэй. Үүнд:

- (a) Гэрээний 13-т заасны дагуу ажилд өөрчлөлт оруулах;
- (b) Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;
- (c) Эрх бүхий байгууллага эсвэл Захиалагчийн буруугаас болж санхүүжилтийг тасалдуулсан;
- (d) Ажил эхлэх өдрийн дараагаас эхлэн Захиалагч болон хамааралтай ажил Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа болон алдаа дутагдлаас үүдэн Гүйцэтгэгч

ИЛ БОЛСОН

НУУЦ

төслийн гол үе шатуудын заагийн огноонд багтаан төслийн гол үе шатуудын заагийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадаагүйн улмаас;

- (e) Эдгээр нөхцөлийн гэрээний заалтын дагуу хугацаа сунгах эрх олгох зорилгоор хойшлуулсан шалтгаан;
- (f) Захиалагч, Захиалагчийн бие бүрэлдэхүүнээс шалтгаалан учирсан хойшлуулалт, саад тотгор, урьдчилан сэргийлэлт;
- (g) Ажлын гүйцэтгэлийг удаашруулж болзошгүй урьдчилан тооцоолоогүй асуудал. Захиалагчийн зүгээс гүйцэтгэл нь удааширсан ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаа болон төслийн гол үе шатуудын заагийн үйл ажиллагаа гүйцэтгэх хугацааг сунгана. Үйл ажиллагаа гүйцэтгэх хугацааг сунгасан тохиолдолд Гүйцэтгэгчийн зүгээс ажлын гүйцэтгэл хойшлогдсонтой холбогдуулан гаргасан зардлыг Захиалагчаас ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаа болон төслийн гол үе шатуудын заагийн үйл ажиллагаа гүйцэтгэх огнооны өмнө болон дараа нөхөн төлбөр хэлбэрээр нэхэмжлэн авна.

8.4.2. Гүйцэтгэгч урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаа болон төслийн гол үе шатуудын заагийн үйл ажиллагаа гүйцэтгэх хугацааг сунгуулах эрхтэй гэж үзвэл гэрээнд заасны дагуу Захиалагчид мэдэгдэл хүргүүлж болох [Гүйцэтгэгчийн нэхэмжлэл] боловч хугацаа сунгах эрхийг зөвхөн гэрээний 8.4-т заасны дагуу эдэлнэ.

8.4.3. Захиалагчийн зүгээс аль ч цаг үед өөрийн санаачилга, саналаар Гэрээнд дурдсан болон дурдаагүй шалтгааны улмаас хугацаа сунгах асуудлыг нягталж, хугацаа сунгаж, сунгалтын хугацааг нэмэгдүүлж болно.

8.4.4. Материалын хангалт удааширч, гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд гэрээг харилцан тохиролцон сунгаж болно.

8.4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд төлбөрөөс чөлөөлөх хугацааг хэтрүүлсэн бол Гэрээний дагуу ажил гүйцэтгэх хугацаа сунгуулах эрхгүй. Үүнд:

- (a) Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн ямар нэгэн ажилтан зөрчил гаргасан, хайхрамжгүй хандсан, үүргээ биелүүлээгүйн улмаас ажлын гүйцэтгэл удааширсан;

8.4.6. Энэхүү гэрээний 8.4.1-д заасан шалтгаан үүссэн тохиолдолд гэрээг сунгаж талуудад учирсан хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авах эрхтэй.

8.5. Ажлыг түр зогсоох


8.5.1. Зөвлөх-Хяналтын баг хэдийд ч Гүйцэтгэгчийн гүйцэтгэж буй ажлыг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь түр зогсоож болно. Энэхүү түр зогсолтын хугацаанд Гүйцэтгэгч ажлын хэсэг болон ажлыг бүхэлд нь элэгдэл гэмтэл, алдагдал, эвдрэлээс хамгаалж, хадгалах арга хэмжээ авна.

8.5.2. Түр зогсолтын аль ч үед Гүйцэтгэгч материал болон тоног төхөөрөмжөө Зөвлөх-Хяналтын баг, Захиалагчид урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр ажлын талбайгаас нүүлгэж үл болно.


8.5.3. Зөвлөх-Хяналтын баг түр зогсоох болсон шалтгаанаа мэдэгдэнэ.

8.6. Түр зогсолтын үр дагавар

Энэхүү гэрээ нь торийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харууцлага хүлээлгэх болно.

"МТЗ" ТӨХК 

"УБТЗ" ХНН.....



ИЛ БОЛСОН

54-
ЦУЦ

8.6.1. Гүйцэтгэгч Зөвлөх-Хяналтын багийн зааварчилгааг дагаж мөрдөж, ажлаа сэргээх үйл явцыг удаашруулсан, зардал гаргасан бол Захиалагчид энэ талаар мэдэгдэнэ.
А. Гэрээний хугацааг сунгах;
Б. Үүнтэй холбоотой гарсан зардлыг гэрээний үнэд оруулах.

8.6.2. Энэ мэдэгдлийг хүлээн авсны дараа Зөвлөх-Хяналтын баг болон Захиалагч нь гэрээний 3.2-т заасны дагуу арга хэмжээг авна.

8.7. Түр зогсолтын үеийн материалын төлбөр

8.7.1. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажлын талбайд хүргэгдээгүй материалын үнийг Захиалагчаар төлүүлэх эрхтэй. Үүнд:

- (a) Тухайн материал ашиглаж гүйцэтгэх ажил эсхүл материал хүргэж ирэх хугацаа 14 (арван дөрөв) хоногоос дээш хугацаагаар саатсан бол;
- (b) Зөвлөх-Хяналтын багийн зааварчилгааны дагуу Захиалагчийн өмч гэж бүртгэсэн бол.

8.8. Түр зогсолтын хугацааны сунгалт

8.8.1. Хэрэв гэрээний 8.7-д заасан [Ажил түр зогсоох] түр зогсолтын хугацаа 60 (жар) хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн бол Гүйцэтгэгч Зөвлөх-Хяналтын багт ажлаа үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргана. Хэрэв Зөвлөх-Хяналтын баг хүсэлтийг хүлээн авснаас хойш 20 (хорь) хоногийн дотор зөвшөөрөл олгоогүй бол Гүйцэтгэгч Зөвлөх-Хяналтын багт мэдэгдэл хүргүүлж, түр зогсолт гэрээний 13-т заасны дагуу [Өөрчлөлт болон Залруулга] гэж үзнэ.

8.8.2. Хэрэв түр зогсолт нь бүх ажилд нөлөө үзүүлсэн бол гэрээ цуцлах мэдэгдлийг энэхүү гэрээний 16.2-т заасны дагуу гаргана.

8.8.3. Гүйцэтгэгч нь гэрээ цуцлах хүртэл зохих ёсоор хийж гүйцэтгэсэн ажлын хөлс болон ажлын талбай дээрх энэхүү гэрээний 8.7.1-д заасан төлбөрийг Захиалагчаас гаргуулан авна.

8.9. Ажлаа үргэлжлүүлэх

8.9.1. Ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл буюу зааварчилгаа авсны дараа Талууд хамтран түр зогсолтын нөлөөнд автсан ажил, материалуудыг шалгаж үзнэ. Захиалагч түр зогсолтын хугацаанд элэгдсэн, доголдол гарсан, алдагдалд орсон ажил, материалын төлбөрийг хариуцна.

ЕС. АЖИЛ ДУУСАХ ҮЕД ХИЙХ ТОХИРУУЛГА, ЗҮГШРҮҮЛЭГ

9.1 Ажил дуусах үеийн туршилт

9.1.1. Гүйцэтгэгч энэхүү гэрээний 7.4 дэх заалт, Хавсралт 5-д заасны дагуу ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгийг хийж гүйцэтгэнэ.

9.1.2. Гүйцэтгэгч ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэлт бүрийг хийхээс 14 (арван дөрөв) хоногийн өмнө Захиалагчид тохируулга, зүгшрүүлэлт хийхэд бэлэн болсон тухай мэдэгдэл хүргүүлнэ.

ДУУЦ

ИЛ БОЛСОН

9.1.3. Гүйцэтгэгч Зөвлөх-Хяналтын багийн туршилтад байлцуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгийг Захиалагчийн зааварчилгаа өгснөөс хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор эсвэл тухайн өдөр хийж гүйцэтгэнэ.

9.1.4. Гүйцэтгэгч тал ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгийн дүнгийн баталгаажсан тайланг тохируулга, зүгшрүүлэлт дууссаны дараа Зөвлөх-Хяналтын багт илгээнэ.

9.1.5. Хэрэв ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгийг үргэлжүүлэн гүйцэтгэх нь ажлын үр дүнг амжилтгүй болгох, бие бүрэлдэхүүнд гэмтэл, бэртэл учруулахуйц байвал Зөвлөх-Хяналтын багаас тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг зогсоож болно.

9.2. Зөвлөх-Хяналтын баг оролцож чадахгүй байх

9.2.1. Зөвлөх-Хяналтын багийн зүгээс ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгэд оролцоогүй бол Гүйцэтгэгч ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгүүд тэдгээрийг Зөвлөх-Хяналтын багийн оролцоотой хийсэнд тооцох ба тохируулга, зүгшрүүлэгийн дүнг үнэн зөвд тооцно.

9.3. Дахин тохируулга, зүгшрүүлэг хийлгэх

9.3.1. Хэрэв ажил дуусах үеийн тохируулга, зүгшрүүлэгийг гүйцэтгэх үед ажлын гүйцэтгэл тохируулга, зүгшрүүлэгийг давж чадаагүй бол Гүйцэтгэгч тохируулга, зүгшрүүлэг амжилтгүй болсон талаар Захиалагчид мэдэгдэж, адил нөхцөлд тохируулга, зүгшрүүлэгийг дахин гүйцэтгэнэ.

9.3.2. Гүйцэтгэгч тохируулга, зүгшрүүлэгийг давтан хийхээс өмнө тухайн ажлын тохируулга, зүгшрүүлэгийг амжилттай гүйцэтгэх зорилгоор боломжийн хурд, өөрийн зардлаар ажилд тохиромжтой өөрчлөлт, залруулга, сайжруулалт хийнэ.

9.3.3. Хэрэв Гүйцэтгэгч тохиромжтой өөрчлөлт, залруулга, сайжруулалт хийж чадаагүй бол Захиалагчийн зүгээс өөрийн сонголтоор болон Захиалагчийн өөр гүйцэтгэгч эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч Захиалагчийн сонголтоор зарцуулсан зардлыг Захиалагчид эргүүлэн төлөх эсвэл тус зардлыг Гэрээний үнээс хасаж тооцож болно.

АРАВ. УРЬДЧИЛСАН БАЙДЛААР ХҮЛЭЭН АВАХ

10.1. Урьдчилсан байдлаар хүлээн авах

10.1.1. Гүйцэтгэгч ажил дуусах үеийн байдлаар урьдчилан хүлээн авна. Үүнд:

- А. Төмөр замын дээд бүтцийг хоорондын зам болгоноор хэсэгчлэн техникийн комисс ажиллуулах;
- Б. Гүүрийг баригдаж дууссан тухай бүр техникийн комисс ажиллуулах;
- В. Эрчим хүчний барилга байгууламжийг багц болгон хувааж, техникийн комисс ажиллуулах;
- Г. Дохиолол төвлөрүүлэлт, хориглол ба холбооны систем, шилэн кабелийн ажлыг бүрэн хэмжээгээр хийж дуусгасны дараа техникийн комисс ажиллуулах.

10.1.2. Талууд техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу биелүүлнэ.

ИЛ БОЛСОН

12/01/21

10.1.3 Энэхүү гэрээний 10.1.2-т авсан тохиолдсон комиссоос өгсөн үүрэг даалгавар биелэгдсэний дараа Захиалагч зохих журмын дагуу Улсын комиссыг ажиллуулах арга хэмжээ авна.

АРВАННЭГ. БАГЦ АЖЛЫГ ЭЦСИЙН БАЙДЛААР ХҮЛЭЭЛЦЭХ

11.1. Гүйцэтгээгүй үүрэг, хариуцлага

11.1.1. Улсын комисс ажлыг хүлээж авсан эсэхээс үл харгалзан Гүйцэтгэгч гарсан доголдол, зөрчлийг арилгана.

11.1.2. Талууд гэрээний үүргийг зохих ёсоор биелүүлсний дараа талуудын эрх бүхий албан тушаалтнаас бүрдсэн комисс гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

11.1.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч хугацаанд нь хүлээн аваагүй бол ажлын үр дүн ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байсан ч гэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болох үр дагаврыг Захиалагч хариуцна.

11.2. Ажлын талбайг цэвэрлэх

11.2.1. Эцсийн байдлаар гэрээ дүгнэсэн акт үйлдэгдсэний дараа Гүйцэтгэгч тал үлдсэн тоног төхөөрөмж, үлдэгдэл, материал, хог хаягдал, түр ажлыг ажлын талбайгаас нүүлгэнэ.

АРВАНХОЁР. ДАЛД ДОГОЛДЛУУД

12.1. Засаж залруулах ажлын үүрэг

12.1.1. Эцсийн байдлаар хүлээн авсан тухай гэрчилгээ олгосон хэдий ч Гүйцэтгэгч нөхөн сэргээх ажлыг түргэн хугацаанд гүйцэтгэх, ажил болон сэлбэг хэрэгсэлд доголдол, зөрчил илэрсэн, эдгээрийг илрүүлэх хугацаанд илэрсэн, тохиолдсон далд доголдлоос үүдэн байнгын ажилд учирсан эвдрэл гэмтлийг өөрийн зардлаар засварлах үүрэг, хариуцлага хүлээнэ.

12.1.2. Гүйцэтгэгч Захиалагчаар батлуулах зорилгоор гэрээний 12 дахь заалтын дагуу хийж гүйцэтгэх засаж залруулах ажил, түүнийг гүйцэтгэх төлөвлөгдсөн хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх ба энэ дэлгэрэнгүй мэдээлэл нь тухайн засаж залруулах ажлыг зогсоох, гүйцэтгэх өдөр товлоход ашиглагдана. Хэрэв байнгын ажлыг зогсоолгүйгээр тухайн засаж залруулах ажлыг гүйцэтгэх боломжтой бол Гүйцэтгэгч засаж залруулах ажлыг аль болох хэрэгжүүлж болох түвшинд гүйцэтгэнэ. Хэрэв засаж залруулах ажлыг гүйцэтгэхийн тулд байнгын ажлыг зогсоох шаардлагатай бол засаж залруулах ажлын цаг, хугацааг Захиалагчтай тохиролцсоны үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.


АРВАНГУРАВ. ӨӨРЧЛӨЛТ, ТОХИРУУЛГА

13.1. Ажилд өөрчлөлт оруулах


13.1.1. Гүйцэтгэгчээс ажилд оруулах өөрчлөлтийн талаарх саналыг дараах байдлаар Зөвлөх-Хяналтын баг хүлээн авч болно. Үүнд:

- а) Ажил хүлээн авах гүйцэтгэлийн акт гаргахаас өмнө;
- б) Гүйцэтгэгчийн зүгээс санал хүсэлт гаргах, эсхүл зааварчилгааны аль нэгийг гарахаас өмнө.

Энэхүү гэрээ нь иргэйн болон албаны нүүрээс хамаргах тус өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хуртгал болгохыг хориглоно. Энэ шийрэмгийг биелүүлэхгүй яллагаг этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

МТЗ ТӨХИ 

УБТЗ ХНН.....



ИЛ БОЛСОН

ОУУП

13.1.2. Саналыг хүлээн авсан даруйдаа Зөвлөх-Хяналтын баг нь зааварчилгааг хүчингүй болгох, баталгаажуулах, эсхүл өөрчлөх арга хэмжээ авна.

13.1.3. Өөрчлөлт оруулах санал тус бүр нь дараах зүйлийг багтаасан байна. Үүнд:

- a) ажлын аль хэсэгт, ямар өөрчлөлт оруулах;
- b) ажлын чанар болон бусад шинж чанарт ямар өөрчлөлт оруулах;
- c) ажлын хэмжилтийн түвшин, байршил, хэмжээнд ямар өөрчлөлт оруулах;
- d) Гэрээнд тусгагдаагүй ажил эсэх;
- e) ямар нэгэн нэмэлт ажил, байнгын ажилд шаардлагатай материал, үйлчилгээ болон тохируулга, зүгшрүүлэлт, судалгааны ажил;
- f) ажлыг гүйцэтгэх дараалал болон хугацаанд орох өөрчлөлт,

13.1.4. Зөвлөх-Хяналтын баг нь зааварчилгааг хүчингүй болгох, баталгаажуулах эсхүл өөрчлөх хүртэл Гүйцэтгэгч нь ажилд өөрчлөлт хийж болохгүй.

13.1.5. Зөвлөх-Хяналтын баг гэрээний үнийн дүнд өөрчлөлт орохгүй тохиолдолд саналыг хүлээн авч, зааварчилгааг баталгаажуулах эсхүл өөрчлөнө.

13.1.6. Зөвлөх-Хяналтын баг ажлын өөрчлөлтөөс хамаарч гэрээний үнийн дүнд өөрчлөлт орох саналыг Захиалагчид нэн даруй уламжилна.

13.1.7. Зөвлөх-Хяналтын баг нь зардлыг тооцоход шаардлагатай тайлан, мэдээг багтаасан өөрчлөлт хийх заавар бүрийг Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

13.2. Өөрчлөлт хийх журам

13.3.1. Гүйцэтгэгч нь ажилд өөрчлөлт оруулах саналыг бичгээр гаргах бөгөөд яагаад дагаж мөрдөхгүй (хэрэв мөрдөхгүй байх тохиолдол байгаа бол) шалтгааныг тусгана. Үүнд:

- a. Гүйцэтгэхээр санал болгож буй ажлын тодорхойлолт болон гүйцэтгэх төлөвлөгөө;
- b. Гэрээний 8.3 (Ажлын хуваарь)-т заасны дагуу танилцуулах төлөвлөгөө болон ажлыг дуусгах хугацаанд оруулах шаардлагатай өөрчлөлтүүдийн талаарх Гүйцэтгэгчийн санал;
- c. Гэрээний үнэд өөрчлөлт, тохируулга хийх тухай Гүйцэтгэгчийн санал.

13.3.2. Зөвлөх-Хяналтын баг нь гэрээний 13.1-д заасны дагуу саналыг хүлээн авсны дараа аль болох хурдан хугацаанд хариугаа өгнө. Гүйцэтгэгч нь Зөвлөх-Хяналтын баг хариуг хүлээх хүртэл ажлыг хэвийн үргэлжлүүлнэ.


АРВАНДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР

14.1. Гэрээний үнэ


14.1.1. Гэрээний үнийг гэрээний Хавсралт 3, 6-д тогтоохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- (a) Албан ёсоор батлагдсан төсөвт өртөгт багтаан Улаанбаатар төмөр замын ажилтнуудын цалингийн системийг үндэслэн зардлын зүйл анги тус бүрээр зохицуулалтыг хийнэ.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамраах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцаага хүлээлгэх болно.

МТЗ ТӨХК 

"УБТЗ" ХНН



- (b) Албан ёсоор батлагдсан төсөвгүй ажлыг хийж гүйцэтгэхдээ Гүйцэтгэгч өөрөө төсөвт өртгийг гарган Захиалагчтай харилцан тохиролцож /дэд ажлын хэсэгт танилцуулан / батална.
- (c) Төмөр замын дээд бүтэц барих ажлын төсөвт өртөг нь Зүүнбаян өртөө талаас алслагдах тутамд тээврийн зардлын хэмжээгээр нэмэгдэнэ.

14.1.2. Гэрээний хавсралтанд заасан хийж гүйцэтгэх ажлын үнэд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн км дэлгэмэл урттай төмөр замын дээд бүтэц (гол зам, суман шилжүүлэг, зам төмөр, уулзварын ба завсрын бэхэлгээ, зам төмрийн суурь /дэр, дүнз, гулдангууд/чигжээсний үе, балласт хориг хашаа), Дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны систем болон эрчим хүч, шилэн кабель, өртөө зөрлөгийн зам, гүүр барьж байгуулах, зураг төсөл боловсруулахтай холбогдон гарах бүх зардал багтсан болно.

14.1.3. Гэрээний 14.1.1-д заасан үнэ болон өртгийн сууриар үнэлсэн ажилд тохируулга хийж болно.

14.1.4. Төсөл хэрэгжих явцад инженерийн зураг төслийг боловсруулах шатанд тодорхойгүй байсан үйл ажиллагааны үнийг тогтоож гэрээний үнийг өөрчилж болно.

14.2. Урьдчилгаа төлбөр

14.2.1. Захиалагч гэрээний Хавсралт 3, 5-т заасан тухайн үе шатны ажил эхлэх үед тухайн үе шатны ажлын нийт төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилгаа төлбөрийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 5(тав) хоногийн дотор гэрээний Хавсралт 6-д заасан дансанд шилжүүлнэ.

14.2.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг гэрээг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, машин техник, байгууламж болон ажил эхлүүлэхтэй холбогдсон зардалд зарцуулна.

14.2.3. Захиалагч тухайн үе шатны ажилд шаардлагатай байгаа бараа, материалын үнийг тухай бүрт нь урьдчилсан байдлаар олгоно.

14.2.4. Урьдчилгаа төлбөрийг гэрээний хавсралт 3-т заасан хэмжээгээр багц ажил тус бүрийн завсрын төлбөрүүдээс тодорхой хувь хэмжээгээр суутгал хийх замаар тооцно.

14.2.5. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа материалыг НӨАТ төлөгч хуулийн этгээдээс худалдан авах тохиолдолд Захиалагч тухайн этгээдтэй санхүүжилтийн гэрээ байгуулж, Гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр төлбөрийг олгоно.

14.2.6. Гүйцэтгэгчийн импортоор оруулж ирсэн ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа, материалын НӨАТ, гаалийн татварыг Захиалагч хариуцна.

14.2.7. Захиалагч Гүйцэтгэгчийн худалдан авч буй бараа, материалын төлбөрийг бараа, материал нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу шилжүүлээгүйгээс бараа материалын нийлүүлэлт доголдох, ажил саатах, чанар гүйцэтгэлд муугаар нөлөөлөх, алданги төлөх г.м нөхцөл байдал үүссэн тохиолдолд хариуцлагыг Захиалагч өөрөө биечлэн хүлээнэ.

14.3. Завсрын төлбөрийн хүсэлт

ИЛ БОЛОН

НУУН

14.3.1 Гүйцэтгэгч нь завсрын төлбөрийн гэрчилгээний төслийг дөрөв (4) хувь /3 хувь нь хэвлэмэл, 1 хувь нь электрон/ үйлдэж, Зөвлөх-Хяналтын багаар баталгаажуулж. Захиалагчаас баталсан маягтын дагуу Захиалагчид илгээх бөгөөд үүнд Гүйцэтгэгч нь гэрээний 4.19 дэх заалт [Ажлын явцын тайлангууд]-д заасны дагуу анхан шатны баримт бичиг, төлбөрийн дүнг нарийвчлан харуулсан байна.

14.3.2 Төслийн төсөв магадлалаар ороод баталгаажсаны дараа томсгосон төсөв батлуулна. Томсгосон төсөв нь төлбөрийн гэрчилгээний маягтын баримт болно. Төлбөрийн гэрчилгээ нь төсөвт өртгөөс гадна өмнөх тайлант үе, тайлант үе, нийт гүйцэтгэлийн дүн харагдаж байна.

14.3.3 Завсрын төлбөрийн гэрчилгээ бичигдэх нөхцөл /хугацаа, төлбөрийн гүйцэтгэл, ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, графикт хугацаа г.м/-ийг гэрээний хавсралт 3-т зааснаар ажил тус бүр дээр тухайлан заана.

14.3.4 Завсрын төлбөрийн гэрчилгээнд дараах зүйлсийг тусгасан байна:

- (a) Гүйцэтгэгчид төлөх дүн болон Хавсралт 3, 6-ын дагуу тооцоолсон, гүйцэтгэсэн Ажлуудын Гэрээний үнэд зориулсан, сарын эцэст гаргасан Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, бөглөсөн бусад маягт болон тэдгээрт тодорхойлсон холбогдох үнийн дүн;
- (b) Гэрээний 20 дахь заалт [Нэхэмжлэл, Маргаан болон шүүхийн ажиллагаа] зэрэг Гэрээний заалтуудын дагуу хэрэглэх, эсхүл зөвшөөрөгдсөн бусад суутгал, нэмэгдэл;
- (c) Өмнөх Завсрын төлбөрийн гэрчилгээнүүдэд оруулсан үнийн дүнгийн суутгал;
- (d) Гүйцэтгэлийн баталгааг энэхүү гэрээний 4.2-т зааснаар суутган тооцно.

14.3.5 Төлбөрийн хүсэлттэй хамт дараах материал дагалдана. Үүнд:

- (a) Тоо хэмжээний тооцоо Хавсралт 6-д заасан ажлуудыг амжилттай дуусгасан тохиолдолд өргөдлийн дагуу материалыг худалдаж авах, хүргэх, холбогдох ажлуудыг зохих ёсоор гүйцэтгэхийн тулд Захиалагчийн зүгээс хүсч болох баталгаа нотолгоо, анхан шатны баримт болон бусад мэдээлэл;
- (b) Бусад үнийн дүнгийн хувьд Захиалагчийнн зүгээс зохих ёсоор шаардаж болох анхан шатны тодорхой баримт бичгүүд.

14.4. Завсрын төлбөрүүд

14.4.1 Завсрын төлбөрийн гэрчилгээг болон гэрээний 14.3-т заасан бүх анхан шатны баримт бичгүүдийг хүлээн авсны дараа 10 (арав) хоногийн дотор Зөвлөх-Хяналтын баг завсрын төлбөрийн гэрчилгээг хянан баталгаажуулж, гарын үсэг зурж, мэдэгдлийг Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

14.4.2. Талууд тохиролцсон нь:

- (a) Энэхүү гэрээний 14 дэх заалтад шаардсан анхан шатны баримт бичиггүй, дутуу, эсвэл үнэн зөв биш төлбөрийн хүсэлтийг хангалтгүй гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж үзэх бөгөөд тухайн дутагдалтай, алдаатай зүйлсийг

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувиар тархах, нийтийн хүртээл баяглахыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүрээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. МТЗ ТӨХК "УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

УБТЗ

засаж залруулах арга хэмжээ авах хүртэл Зөвлөх-Хяналтын багийн зүгээс хянан баталгаажуулахгүй.

(b) Гүйцэтгэгчийн бүрэн гүйцэд хийж дуусгасан ажлуудад л зөвхөн төлбөр төлөх бөгөөд батлуулаагүй, хангалттай гүйцэтгэсэн эсэх нь нотлогдоогүй ажлуудад төлбөр төлөхгүй болно.

14.4.3. Завсрын төлбөрийн гэрчилгээнд тусгагдсан төлбөрийн хүсэлтийг батлахдаа Зөвлөх-Хяналтын баг нь дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

(a) Маргаантай төлбөрийн хувьд Захиалагч нь маргаан шийдэгдэх хүртэл маргаангүй Завсрын төлбөрийн гэрчилгээг хянан баталгаажуулна.

14.4.4. Завсрын төлбөр нь ажлын гүйцэтгэлийн чанар болон ажил гүйцэтгэх хугацаатай шууд хамааралтай тул ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын даалгаврын дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн ажлын хувьд хянан баталгаажуулахаас татгалзах эрхтэй бөгөөд бусад тохиолдолд Зөвлөх-Хяналтын баг завсрын төлбөрийн гэрчилгээг хянан баталгаажуулахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй.

14.4.5. Гэрчилгээг баталгаажуулаагүй тохиолдолд Зөвлөх-Хяналтын баг нь үндэслэл бүхий шалтгааныг Гүйцэтгэгч болон Захиалагчид бичгээр мэдэгдэнэ.

14.5. Төлбөр төлөх хугацаа

14.5.1. Зөвлөх-Хяналтын багийн хянан баталгаажуулсан Завсрын төлбөрийн гэрчилгээг Гүйцэтгэгчээс хүлээн авсан өдрөөс 14 (арван дөрөв) хоногийн дотор Захиалагч зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу Гүйцэтгэгчид үнийг төлнө.

14.5.2. Зөвлөх-Хяналтын багийн хянан баталгаажуулсан Эцсийн төлбөрийн гэрчилгээг Гүйцэтгэгчээс хүлээн авсан өдрөөс 14 (арван дөрөв) хоногийн дотор Захиалагч зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу Гүйцэтгэгчид үнийг төлнө.

14.5.3. Гүйцэтгэгчийн Хавсралт 3, 6-д заасан дансанд урьдчилгаа, завсрын, эцсийн төлбөрийг хийнэ.

14.5.4. Банкны ажиллах өдрөөс өөр өдөрт төлөгдөх болсон төлбөрийг дараагийн ажлын өдөрт гүйцэтгэнэ.

14.5.5. Ямар нэг үндэслэлээр аль нэг тал нь төлбөрийн гэрчилгээний дагуу төлөх ёстой дүнгээс хэтрүүлсэн төлбөр гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг дараагийн гүйцэтгэлд тусган суутгах боломжтой.

14.6. Төлбөрийн саатал ба баталгаа

14.6.1. Захиалагч нь гэрээний дагуу төлбөрөө заасан хугацаанд төлөхөө баталж байгаа болно.

14.7. Ажил дуусгасан тухай мэдэгдэл

14.7.1. Ажлуудыг урьдчилсан байдлаар хүлээж авсан баталгааг хүлээн авснаас 21 (Хорин нэг) хоногийн дотор Гүйцэтгэгч нь гэрээний 14.3 дахь заалт [Завсрын төлбөрүүдийн өргөдөл]-ын дагуу доорх тооцоог харуулсан анхан шатны баримт

Эндүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарна тул өөр бусад этгээдэд хувиаж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харилцаага хүлээлгэх болно.
"МТЗ" ТӨХК..... "УБТЗ" ХНН.....

[Signature]

[Signature]

ИЛ БОЛСОН

61-
НУУЦ

бичгүүдтэй хамт ажил дуусгасан тухай мэдэгдлийн Гурван хэвлэмэл хувь, нэг электрон хувийг Захиалагчид илгээнэ:

- (a) Ажлыг урьдчилсан байдлаар хүлээн авсан тухай баталгаанд заасан хугацааг хүртэл Гэрээний дагуу гүйцэтгэсэн бүх ажлын үнийн дүн;
- (b) Гүйцэтгэгчийн зүгээс авах ёстой гэж үзсэн аливаа үнийн дүн;
- (c) Гэрээний дагуу Захиалагчийн төлөх ёстой гэж тооцсон бусад дүн. Ажил дуусгасан тухай мэдэгдэлд тусад нь тооцоолсон дүнг харуулсан байна.

14.7.2. Захиалагч нь гэрээний 14.4 дэх заалт (Завсрын төлбөрүүд)-ын дагуу Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч, 14.5 дахь заалт (Төлбөрийн хугацаа тогтоох)-ын дагуу төлбөрийг гүйцэтгэнэ.

14.8. Эцсийн төлбөр авах хүсэлт

14.8.1. Гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг Улсын комисс хүлээн авч, дүгнэлт гаргасны дараа 28 (хорин найм) хоногийн дотор Гүйцэтгэгч нь Захиалагчаас баталсан маягтаар дараах зүйлсийг нарийвчлан харуулсан анхан шатны баримтуудын хамт эцсийн мэдэгдлийн төслийн хоёр хэвлэмэл хувь болон нэг электрон хувийг Захиалагчид илгээнэ.

- (a) Гэрээний дагуу хийсэн бүх ажлын үнийн дүн.
- (b) Гэрээний дагуу эсвэл бусад нөхцөлийн дагуу гүйцэтгэх ёстой гэж Гүйцэтгэгчийн үзсэн үнийн дүн.

14.8.2. Захиалагч нь эцсийн мэдэгдлийн төсөл дэх ямар нэг хэсэгт санал нэгдэхгүй, шалгаж баталгаажуулж чадахгүй бол Гүйцэтгэгч нь Захиалагчийн зүгээс зохих ёсоор шаардсаны дагуу илүү мэдээллээр хангаж, Талууд харилцан тохиролцож төсөлд өөрчлөлт оруулна. Гүйцэтгэгч нь тохирсон ёсоор эцсийн мэдэгдлийг бэлтгэж, Захиалагчид илгээнэ. Ийнхүү тохиролцсон мэдэгдлийг энэхүү Гэрээнд "Эцсийн мэдэгдэл" гэх бөгөөд үүний дараа Захиалагч нь нэн даруй Эцсийн төлбөрийн баталгааг гаргаж, төлбөрийг энэхүү гэрээний 14.3-т заасны дагуу саадгүй шилжүүлнэ.


14.9. Гүйцэтгэл

14.9.1. Эцсийн мэдэгдлийг илгээхдээ Гүйцэтгэгч нь бичгээр үйлдсэн гүйцэтгэлийн мэдээг илгээх бөгөөд үүнд эцсийн мэдэгдлийн нийт төлбөр нь Гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх бүх мөнгөний бүрэн гүйцэд, эцсийн төлбөр тооцоо болохыг баталгаажуулсан байна

14.10. Эцсийн төлбөр

14.10.1. Гэрээний 14.5 дахь заалт (Төлбөрийн хугацаа тогтоох)-ын дагуу Захиалагч нь Гэрээний дагуу авах суутгал болон өмнө нь төлөх бүх дүнг хасч түүнчлэн гэрээний дагуу төлөх ёстой болон гэрээ хэрэгжих явцад гарсан нэмэгдэл төлбөр болон гарсан хохирол зэргийг бүгдийг нэмж тооцон Эцсийн төлбөрийн баталгаанд эцсийн байдлаар тусгагдсан дүнг Гүйцэтгэгчид саадгүй төлнө.

14.11. Төлбөр хийх мөнгөн тэмдэгт



И.Д. БОЛСОН

14.11.1. Гэрээний үнийг Хавсралт 3, 6-д заасан төгрөгөөр урьдчилгаа, завсрын, эцсийн төлбөр бүрээр төлнө.

14.12. Нэмэлт төлбөрийн нэхэмжлэл

14.12.1. Захиалагч Гэрээг зөрчсөнөөс болж Гүйцэтгэгчид нэмэлт болон тооцоолоогүй зардал гарсан тохиолдолд /Зөвлөх-Хяналтын баг баталгаажуулсан/ Гүйцэтгэгч нь тухайн зардлыг Гэрээний үнэд нэмж төлүүлэх эрхтэй.

АРВАНТАВ. ЗАХИАЛАГЧИЙН САНААЧИЛГААР ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

15.1. Доголдол, зөрчил засах

15.1.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн ажил, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, зөрчсөн, алдаа, дутагдал гаргасан, нуун дарагдуулсан, хууран мэхэлсэн болон доголдол, зөрчлийг засах хугацааг үндэслэлгүйгээр хэтрүүлсэн тохиолдолд Зөвлөх-Хяналтын баг нь Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч гаргасан зөрчил, доголдлыг тогтоосон хугацаанд арилгах, засч залруулах, үүргээ биелүүлэхийг шаардана.

15.1.2. Гүйцэтгэгч шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Захиалагчийн санаачилгаар Гэрээг цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

15.2. Захиалагч Гэрээг цуцлах

15.2.1 Гүйцэтгэгч нь дор дурдсан нөхцөл байдлыг үүсгэсэн бол Захиалагч гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

(a) гэрээний 15.1 (Зөрчил, доголдлыг засах)-д заасны дагуу мэдэгдэл авч доголдлыг арилгаагүй;

(b) Гэрээнд заасан ажил, үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэхгүй буюу гүйцэтгэхээс татгалзаж байгаагаа бичгээр илэрхийлсэн;

(c) Тодорхой шалтгаангүйгээр дор дурдсаныг биелүүлээгүй:

(i) Гэрээний 8.1-д заасны дагуу ажлаа гүйцэтгээгүй;

(ii) Гэрээний 7.6 (Засаж залруулах ажил), 7.5 (Ажлыг хүлээн авахаас татгалзах)-д заасны дагуу мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор дагаж мөрдөөгүй;

(iii) зохих зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдээр ажлаа гүйцэтгүүлсэн



(iv) санхүүгийн чадавхгүй болж дампуурсан, зээлдүүлэгчтэй нэгдмэл сонирхолтой болсон, хүлээн авагч тал нь бизнесийн үйл ажиллагааг явуулж байгаа, зээлдүүлэгчийн ашгийн төлөө үйлчилж байгаа, холбогдох хуулийн дагуу шийдвэр гарсан болон гарах гэж байгаа.

15.2.2. Хуульд заасан үндэслэлээр болон дараах зорилгоор бусдад шан харамж, урамшуулал хэлбэрээр авлига, хээл хахууль, бэлэг, үнэт зүйл өгсөн, өгөхөөр завдсан, авсан, авахаар завдсан. Үүнд:

(a) Гэрээтэй холбоотой ямар нэгэн хууль бус үйлдэл хийлгэх зорилгоор;

(b) Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хэн нэгэнд давуу байдал олгохоор найр тавьсан, өөрт ашиг хонжоо, ашигтай байдал бий болгох зорилгоор;

15.2.3. Гэрээг цуцлах тухай Захиалагчийн санал нь Гэрээний дагуу хүлээсэн Захиалагчийн бусад эрх, мэдлийн хэмжээнд урьдчилан төлөвлөсөн байж болохгүй.



ИЛ БОЛСОН

15.2.4. Гэрээг цуцалсны дараа, Гүйцэтгэгч нь ажлын талбайг чөлөөлж, шаардлагатай бараа, материал, Гүйцэтгэгчийн бүх баримт бичиг, өөрийн боловсруулсан зураг төслийн бусад баримт бичгийг Зөвлөх-Хяналтын багт хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь 1) гуравдагч этгээдийн гэрээг шилжүүлэх, 2) ажлыг гүйцэтгэхэд холбогдуулан аюулгүй байдал, өмч хөрөнгө, байгаль орчин, эрүүл ахуйг хамгаалахтай холбоотой мэдэгдэлд дурдсан зааварчилгааг мөрдөнө.

15.2.5. Гэрээг цуцалсны дараа, Захиалагч нь ажлыг дуусгах болон хэн нэгэн этгээдээр ажлыг гүйцээж хийлгэх арга хэмжээ авна. Захиалагч болон бусад этгээд нь Гүйцэтгэгчийн бараа, материал, баримт бичгийг ашиглаж болно.

15.2.6. Захиалагч ажлын талбай болон түүний ойролцоо байрлах Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл, байнгын ажлыг чөлөөлөх мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө. Гүйцэтгэгч нь тэр даруй өөрийн эрсдэл, зардлаар тэдгээрийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авна.

15.3. Гэрээ цуцлах өдөр гаргах үнэлгээ

15.3.1. Гэрээний 15.2-т заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдлийг хүлээн авсан даруй Гүйцэтгэгч нь мэдэгдэлд дурдсан шаардлагыг шуурхай биелүүлэх бөгөөд Зөвлөх-Хяналтын баг нь Гэрээний 3.2 (Шийдвэр)-д заасны дагуу Гүйцэтгэгчид гэрээ цуцлах хүртэл хийж гүйцэтгэсэн ажлын төлбөр, үлдсэн ажил, бараа, материал, Гүйцэтгэгчийн баримт бичгийн үнэлгээг хийнэ.

15.4. Гэрээ цуцлалтын дараах төлбөр

15.4.1. Гэрээний 15.2-т заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдэл өгсний дараа Захиалагч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- (a) Гэрээний 2.4-д заасны дагуу арга хэмжээ авах;
- (b) Илэрсэн доголдол, зерчлийг арилгах хүртэл Гүйцэтгэгчид төлбөр олгохгүй байх;
- (c) Гэрээний 15.1.2-т заасан арга хэмжээ авах.

15.4.2. Захиалагч хуульд заасны дагуу гэрээ дуусгавар болох хүртэл хугацаанд Гүйцэтгэгчийн гэрээний дагуу зохих ёсоор хийж гүйцэтгэсэн ажлын болон Захиалагчид шилжүүлж өгсөн бараа материалын төлбөрийг Гүйцэтгэгчид төлнө.

15.4.3. Аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас болж гэрээг цуцалснаас учирсан хохирлыг буруутай тал төлнө.

15.5. Гэрээг цуцлах Захиалагчийн эрх

15.5.1. Захиалагч нь гэрээний 15.2-д заасан тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй бөгөөд энэ тухай Гүйцэтгэгчид мэдэгдэл өгнө. Гүйцэтгэгч мэдэгдлийг хүлээж авснаас хойш 21 хоногийн дотор тайлбар гаргаагүй бол гэрээг дуусгавар болсон гэж үзнэ.

15.5.2. Ийнхүү цуцалсны дараа Гүйцэтгэгч нь гэрээний 16.3 (Гүйцэтгэгчийн техник хэрэгслийг гаргах болон Ажлыг зогсоох)-т заасны дагуу ажиллаж, 19.5 (Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт)-д заасны дагуу төлбөрийг гүйцэтгэнэ.

15.5.3. Энэхүү гэрээний 15(Захиалагчийн санаачлагаар дуусгавар болгох) болон гэрээний 19 (Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл)-т Гэрээг дуусгавар болгохтой холбоотой Талуудын онцгой эрх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

ИЛ БОЛСОН

-64-

15.5.4. Захиалагч энэхүү гэрээний 16.2-т зааснаас бусад тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар цуцлахыг хориглоно.

АРВАН ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧ АЖЛЫГ ТҮР ЗОГСООХ БОЛОН ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

16.1. Ажлыг түр зогсоох Гүйцэтгэгчийн эрх

16.1.1. Захиалагч нь хоёр (2) сар дараалан гэрээний Хавсралт 3-т заасан ажлын үе шат бүрт төлөх төлбөрийн төлбөл зохих хэмжээний үнийн дүнг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд гэрээний 14.5 [Төлбөрийн хугацаа тогтоох]-д заасны дагуу Гүйцэтгэгчид төлбөр төлөх болсон түүнчлэн дээрх төлбөр төлөөгүй байдал нь энэхүү гэрээний 16.1-т тусгайлан заасанчлан Захиалагчид мэдэгдэл өгснөөс хойш ажлын тав (5) хоногийн турш зөрчлөө засаж залруулаагүй зэрэг нь Гүйцэтгэгчийг ажлыг түр зогсоох саналд хүргэх, улмаар Гүйцэтгэгч нь мэдэгдэлд дурдсан төлбөрийг хүлээж авах хүртлээ ажлыг түр зогсоож болно.

16.1.2. Гүйцэтгэгчийн эдгээр үйлдэл нь гэрээний 14.6 [Төлбөрийн саатал ба баталгаа]-д дурдсан санхүүжилтийн үүрэг болон гэрээний 16.2 [Гүйцэтгэгчийн санаачлагаар дуусгавар болгох]-д заасан Гэрээг цуцлах эрхүүдэд нөлөөлөхгүй.

16.1.3. Гүйцэтгэгч нь Гэрээг дуусгавар болгосон талаарх мэдэгдлийг өгөхийн өмнө буюу өгсөн даруй (дээрх мэдэгдэлд тодорхойлсон) төлбөрийг хүлээн авсан тохиолдолд Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ.

16.1.4. Хэрвээ Гүйцэтгэгч нь энэхүү заалтын дагуу ажлыг түр зогсоосны улмаас нэмэлт зардал гарсан, ажил саатсан бол Захиалагчид мэдэгдэл өгч, Гэрээний дагуу дор дурдсаныг нэхэмжлэн авна:

- (a) Гэрээний 8.4 [Хугацааг сунгах]-т заасны дагуу ажил гүйцэтгэх хугацааг сунгах
- (b) Ийнхүү ажил түр зогсоны улмаас гарсан нэмэлт зардлыг гэрээний төлбөрт тооцуулан нэмж авах

16.2. Гүйцэтгэгч гэрээг дуусгавар болгох

16.2.1. Гүйцэтгэгч нь дараах тохиолдолд Гэрээг дуусгавар болгох эрхтэй. Үүнд:

- (a) Хэрвээ Захиалагч нь тухайн багц ажлын 2 сарын эсхүл тухайн багц ажлын нийт үнийн дүнгийн 20 хувиас хэтэрсэн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний үнийн дүнг зохих хугацаанд нь төлөөгүй, дээрх хоёр тохиолдлын аль нэг нь түрүүлж үүссэн, гэрээний 14.5 дахь заалт [Төлбөрийн хугацаа тогтоох]-ын дагуу Гүйцэтгэгчид төлбөр төлөх болсон, түүнчлэн дээрх төлбөр төлөөгүй байдал нь энэхүү гэрээний 16.2 дахь заалтад тусгайлан заасанчлан Захиалагчид мэдэгдэл өгсөнөөс хойш 14 (арван дөрөв) хоногийн турш зөрчлөө засч залруулаагүй зэрэг нь Гүйцэтгэгчийн зүгээс Гэрээг дуусгавар болгох зорилгод хүргэнэ;
- (b) Захиалагч нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, зээлдүүлэгч нарын нэхэмжлэлийн дагуу захиргааны шийдвэр гарч, тус шийдвэрийг хүлээлгэн өгсөн, зээлдүүлэгч нарын хохирлыг барагдуулахын тулд хариуцагч, итгэмжлэгдэгч буюу менежер томилогдон бизнесийн үйл ажиллагааг хяналтандаа авсан, (холбогдох хуулийн дагуу) дээр дурдсан

46

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамрагдох тул өөр бусад этгээдэд хувиулж тархах, нийтийн хуримтлал болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцахаг хүлээлгэх болно.

"МТЗ" ХХК

"УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

ГҮҮЦ

үйлдэл, арга хэмжээтэй ижил төстэй шинж чанар бүхий бусад тохиолдол бий болсон.

16.2.2. Дээрх (а) дугаар хэсгийн хувьд Гүйцэтгэгч нь 14 (арван дөрөв) хоногийн дотор Гэрээний зөрчлийг засаж залруулахыг шаардаж, Захиалагчид мэдэгдэл өгч болох бөгөөд Захиалагч нь тухайн зөрчлийг засаж залруулж чадаагүй тохиолдолд Гэрээг дуусгавар болгоно [эсвэл Гүйцэтгэгчийн зүгээс хүлээн зөвшөөрөх түвшинд хүртэл зөрчлийг засаж залруулах бүхий л бодитой, боломжит арга хэмжээнүүдийг авна]. (b) дүгээр хэсгийн хувьд Гүйцэтгэгч нь Гэрээг нэн даруй дуусгавар болгох мэдэгдэл өгнө. Гэрээний болон бусад нөхцөлийн дагуу Гэрээг дуусгавар болгох Гүйцэтгэгчийн сонголт нь Гүйцэтгэгчийн бусад эрхэнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

16.3. Ажил зогсоож, Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх

16.3.1. Гэрээний 15.2 [Захиалагчийн санаачлагаар дуусгавар болгох], 15.5 [Гэрээг цуцлах Захиалагчийн эрх], 16.2 [Гүйцэтгэгчийн санаачлагаар дуусгавар болгох] болон 19.5 дахь заалт [Цуцлах хувилбар, төлбөр ба Чөлөөлөлт]-уудийн дагуу Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болсны дараа Гүйцэтгэгч нь нэн даруй дараах үйл ажиллагааг хийнэ. Үүнд:

- (a) Ажлын аюулгүй байдал, эсхүл эд хөрөнгө, амь насыг хамгаалахын тулд Захиалагчаас үргэлжлүүлэх, үлдээхийг хүссэн ажлыг эс тооцвол бусад ажлыг зогсоож, талбайгаас нүүлгэн шилжүүлнэ;
- (b) Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэлийг үндэслэн талбайгаас Гүйцэтгэгчийн бүх тоног төхөөрөмжийг зайлуулж, мөн Гүйцэтгэгчийн бүх ажилтныг буцаан татаж, ямарваа төрлийн хог, хаягдал, үлдэгдэл зэргийг талбайгаас чөлөөлж, талбайг бүхэлд нь цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээнэ;
- (c) Гүйцэтгэгч нь Гэрээг дуусгавар болгох хугацаа хүртэл хийсэн ажлаа төлбөр хүлээн авсан байдалтай нийцүүлж, гарын авлага (барилга, хийцийн зураг гм), Гүйцэтгэгчийн баримт бичиг, материал болон бусад ажлын хамт гардуулж өгнө;
- (d) Гэрээтэй холбоотойгоор олж авсан зөвшөөрлийг Захиалагч, эсхүл Захиалагчийн томилох этгээдийн нэр дээр шилжүүлнэ.



16.4. Цуцлах үед төлөх төлбөр

16.4.1. Гэрээний 16.2 [Гүйцэтгэгчийн санаачлагаар дуусгавар болгох]-д заасанчлан Гэрээг цуцлах тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болсны дараа Захиалагч нь дараах үйл ажиллагааг нэн даруй гүйцэтгэнэ:

- (a) Гэрээний 19.5 дахь заалт [Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт]-ын дагуу Гүйцэтгэгчид төлбөрийг төлнө.

16.5. Цуцлах онцгой эрх

16.5.1. Энэхүү гэрээний 16 дахь [Гүйцэтгэгч Гэрээг түр зогсоох болон цуцлах] болон 19 дэх заалт (Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйл) нь Гэрээг дуусгавар болгохтой холбоотойгоор Талуудын эдлэх онцгой эрх, авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон Ажил эхлэх өдрийн дараа Гүйцэтгэгчийн зүгээс Гэрээг цуцалж, дуусгавар болгох онцгой эрхийг тодорхойлно.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглана. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харилцлага хүлээлгэх болно.
"МТЗ" ТӨХК  "УБТЗ" ХНН 

ИЛ БОЛСОН

ГҮҮЦ

16.5.2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 16.2.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар цуцлахыг хориглоно.

АРВАНДОЛОО. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

17.1. Хохирлыг арилгах баталгаа

17.1.1. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас болж Ажлын талбай дээр ажиллаж буй Захиалагчийн ажилтан /өөрсдийнх нь буруутай үйл ажиллагаанаас болсныг хариуцахгүй/-д дараах шалтгаанаас үүдсэн зарга, хохирол, алдагдлыг барагдуулж хохиролгүй болгоно. Үүнд:

- (a) Ажлын зураг, гүйцэтгэл болон дуусгах ажиллагаа, мөн доголдлыг засахтай холбоотойгоор хүний биед гэмтэл учруулсан, өвдсөн эсхүл амь нас эрсдсэн;
- (b) Ажлын зураг, гүйцэтгэл болон дуусгах ажиллагаа, мөн доголдлыг засах, Урьдчилсан хүлээн авах хугацаа өнгөрсний дараа Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн бусад ажилтай холбоотойгоор эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгөд учруулсан хохирол.

17.1.2. Аль ч тохиолдолд, Захиалагч, Зөвлөх-Хяналтын баг, Захиалагчийн боловсон хүчин эсхүл холбогдох төлөөлөгчийн хайхрамжгүй болон санаатай үйлдэл эсхүл Гэрээг зөрчсөнөөс үүдсэн гэмтэл, өвчин, хүний амь эрсдсэн, мөн бусад хохирол болон алдагдлын хэмжээгээр Гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй болно.

17.1.3. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас болж Гүйцэтгэгч, Гүйцэтгэгчийн төлөөлөгч түүний хамаарал бүхий этгээдэд учирсан аливаа нэхэмжлэл, хохирол, алдагдал болон зардал /шүүхийн зардал/-ыг Захиалагч бүрэн барагдуулж, хохиролгүй болгоно.

17.1.4. Захиалагч гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах үүргээ биелүүлээгүй бол түүнийг тухайн ажлын үр дүнг хүлээн авсан гэж тооцно.

17.1.5. Захиалагч өөрийн буруугаар ажлын үр дүнг хүлээж аваагүй байхад гүйцэтгэсэн ажлын үр дүн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас утсан, гэмтсэн, эсхүл захиалагчийн буруугаар ажлыг хугацаанд нь гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ажлын хөлсөө төлүүлнэ.

17.2. Гүйцэтгэгч ажилдаа хариуцлагатай хандах

17.2.1. Ажил эхлэхээс дуусах хүртэл ажил болон бараа, материалыг хамгаалахтай холбоотой үүргийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

17.2.2. Хэрэв Ажлын тодорхой хэсгийг хүлээн авч урьдчилсан байдлаар ажил хүлээн авах акт олгосон (эсхүл олгосон гэж үзсэн) бол тухайн Ажилд хариуцлагатай хандах үүрэг Захиалагчид шилжинэ.

17.2.3. Хариуцлагатай хандах үүрэг Захиалагчид шилжсэний дараа, Гүйцэтгэгч Урьдчилсан байдлаар ажил хүлээн авах актад заасан хугацаанд үлдсэн аливаа ажилд хариуцлагатай хандах үүргийг Урьдчилсан байдлаар ажил хүлээн авах акт олгосны дараа тухайн үлдсэн ажлыг гүйцэтгэж дуусах (үүнд доголдлыг засах ажил багтана) хүртэл хүлээнэ

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувиаж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Эг шалтгааныг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.
"МТЗ" ТӨХК..... "УБТЗ" ХНН.....

ИЛ БОЛСОН

17.2.4 Гүйцэтгэгчийн ажилд хариуцлагатай хандах үүрэг хүлээсэн хугацаанд Ажил, Бараа материал эсхүл Гүйцэтгэгчийн бичиг баримтад гэрээний 17.3 дахь заалтад [Захиалагчийн эрсдэл] зааснаас бусад шалтгааны улмаас алдагдал, хохирол учирсан бол Гүйцэтгэгч өөрийн зардлаар эрсдлийг хүлээж алдагдал, хохирлыг засаж барагдуулан Ажил, Бараа материал болон Гүйцэтгэгчийн бичиг баримтыг Гэрээнд нийцүүлнэ.

17.3. Захиалагчийн эрсдэл

17.3.1. Захиалагчийн эрсдэл:

- (a) Дайн, (дайн зарлах эсхүл зарлахгүй байх эсэх) дайсагнасан нөхцөл байдал, халдлага, гадны дайснуудын ажиллагаа;
- (b) Бослого, терроризмын ажиллагаа, хувьсгал, үймээн самуун, цэргийн эсхүл засгийн эрхийг булаасан хүчин, улс оронд гарсан иргэний дайн;
- (c) Гүйцэтгэгчийн боловсон хүчин болон ажилтнуудаас бусад этгээдийн улс орон дотор гаргасан бослого, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, үймээн эсхүл эмх замбараагүй явдал;
- (d) Гүйцэтгэгчийн ашиглахаас бусад дайны зэр зэвсэг, тэсэрч дэлбэрэх материал ионжуулсан цацраг эсхүл радио идэвхт хог хаягдал;
- (e) Дууны хурд эсхүл түүнээс дээш хурдаар нисч буй агаарын хөлөг болон агаарын төхөөрөмжийн учруулсан даралтат долгион;
- (f) Урьдчилсан байдлаар ажил хүлээн авах акт олгохоос өмнө Ажлын аль нэг хэсгийг Захиалагч ашигласан эсхүл авсан.

17.4. Захиалагчийн эрсдлийн үр дагавар

17.4.1. Гэрээний 17.3-т жагсаасан эрсдлийн улмаас Ажил, Бараа материал эсхүл Гүйцэтгэгчийн баримт бичигт алдагдал, хохирол учирсан бол, Гүйцэтгэгч тухайн алдагдал, хохирлын талаар зохих ёсоор Зөвлөх-Хяналтын багт бичгээр мэдэгдэл өгнө.


17.4.2. Хэрэв Гүйцэтгэгч 17.3 дахь заалтад заасан эрсдлээс үүдэн гэрээний 8.4 дэх заалтад [Хугацаа сунгалт] заасан шалтгаанаар гүйцэтгэл хойшилсон, хохирол учирсан бол Гүйцэтгэгч тухайн хойшилж буй хугацаагаар ажлын гүйцэтгэлийн хугацааг сунгах, гарсан зардлыг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотой мэдэгдлийг Зөвлөх-Хяналтын багт хүргүүлнэ. Энэ мэдэгдлийг хүлээн авсны дараа Зөвлөх-Хяналтын баг нь гэрээний 3.2 дахь заалтад [Шийдвэрүүд] заасны дагуу арга хэмжээ авна.

17.5. Оюуны болон үйлдвэрлэлийн өмчлөх эрх

17.5.1. Гүйцэтгэгч дараах зүйлд холбогдох Оюуны өмчийн эрхийн зөрчил, хууль бусаар эзэмших эсхүл буруугаар ашигласан нь бодитоор тогтоогдсон, буруутгагдсантай холбоотой аливаа алдагдал, зардал эсхүл Нэхэмжлэлээс Захиалагчийг хохиролгүй болгож, ангид байлгана:

- (a) Гүйцэтгэгчийн зураг төсөл, инженер, худалдан авалт, барилга, Ажлыг шалгах эсхүл ашиглалтад хүлээн авах;
- (b) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг ашиглах;

Эгээр гэрээ нь төрийн болон аймны нүүрэн хамгаалж тус өөр бусад этгээдээ хувиаж тараах, нийтийн хуртээ болгохыг хориглоно. Энэ шаардлагыг бие үүлээгүй аливаа этгээдээ хуульд заасны дагуу хариуцлага хуваагч болно.

"МТЗ" ТӨХК 

"УБТЗ" ХНН.....



МУУЛ

ИЛ БОЛСОН

17.6. Хариуцлагын хязгаарлалт

17.6.1. Гэрээний аль нэг тал нь нөгөө талаасаа энэ гэрээний 16.4-д заасан гэрээ цуцлахтай холбоотой гарсан төлбөр болон 17.1-д заасан нөхөн төлбөртэй холбоотойгоос бусад асуудлаар гэрээтэй холбоотой бусад этгээдийн үйл ажиллагаанаас учирсан хохирол эсхүл аливаа шууд бус алдагдал эсхүл аливаа гэрээний алдагдал, ирээдүйд олох байсан орлого, ажлын үр дүнг ашиглаагүйгээс учирсан алдагдлыг шаардах эрхгүй.

17.6.2. Гэрээний хариуцлагын хязгаарлалт нь дараах зүйлд хэрэглэгдэхгүй бөгөөд дараах хэмжээгээр мөн хорогдохгүй болно (хариуцлагыг тооцоход дараах асуудалд хариуцлага хүлээхгүй):

- (a) Гүйцэтгэгчийн нөхөн төлсөн эсхүл даатгагчаар нөхөн төлүүлэх хариуцлага (үүнд Захиалагч эсхүл Санхүүжүүлэгчээс шууд бус хэлбэрээр хүлээн авсан хөрөнгө багтана);
- (b) Гүйцэтгэгчээс аливаа даатгагчаар төлүүлэх, гэхдээ Гүйцэтгэгч өөрөө даатгалыг хүчин төгөлдөр байлгаж, хадгалах Гэрээнд заасан үүргээ зөрчсөнтэй холбоотой хүлээх хариуцлага;
- (c) Луйвар, залилангийн үйлдэл, санаатай зүй бус үйлдэл, эсхүл санаатай зөрчил. Хориглосон үйлдэл эсхүл холбогдох хууль тогтоомжийн зөрчилтэй холбоотой хариуцлага;
- (d) Гүйцэтгэгчийн эсрэг эрхээ хэрэгжүүлэхэд гарах Захиалагчийн зардал;
- (e) Гэрээг цуцлах эсхүл Гүйцэтгэгчийн Гэрээний дагуу хүлээсэн үүргийг цуцлахаас өмнө Гэрээнд заасан Ажлыг явуулах болон үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулах ёстой зардал;

17.6.3. Гэрээнд нийцсэн эсэхийг үл харгалзан аль ч Тал нөгөө Талд гэрээний зөрчлөөс үүдсэн хохирол, хуульд заасан эрх, үүрэг эсхүл бусад эрх зүйн онолыг зөрчсөн иргэний эрхийн зөрчил, Эдийн засгийн алдагдалд ямар нэг хариуцлага хүлээхгүй бөгөөд дараах хариуцлагыг урьдчилан сэргийлж, хязгаарлаж эсхүл оруулаагүй болно:

- (a) Гэрээний Татан буугдсаны хохирлын хэмжээг тогтоох зорилгоор урьдчилсан байдлаар гаргасан алдагдлын хэмжээнд хамаарч байгаа Эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага;
- (b) Гэрээний хариуцлагын хязгаарлалтад хамаарахгүй гэрээний 17.6.2 дахь заалтад дурдсан хариуцлага, зардал, алдагдал эсхүл хохирлын тодорхой хэсэг болж байгаа Эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага;
- (c) Гэрээний 15.2, 16.2 дахь заалтын дагуу Гэрээг цуцалснаас үүдсэн Эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага

АРВАН НАЙМ. ДААТГАЛ

18.1. Захиалагчийн даатгал

18.1.1. Захиалагч нь өөрийн зардлаар Хавсралт 7-гийн А хэсэгт заасан даатгалуудад мөн түүнд заасан хэмжээ, хугацаа, хасаж тооцох зардал, хасалт, сунгалт болон бусад нөхцлүүдийн шаардлагын дагуу даатгуулж, Ажлын гүйцэтгэлийн явцад хүчин төгөлдөр байлгах үүрэг хүлээнэ.

Эгээр гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул нэр бусад этгээдэд хувилж тархах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Эгээр даатгалыг биеч үлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээгээх болно.
"МТЗ" ТӨХ... "УБТЗ" ХНН.....

ИЛ БОЛСОН

1999

18.2. Гүйцэтгэгчийн даатгал

18.2.1. Гүйцэтгэгч өөрийн зардлаар Хавсралт 7-гийн Б хэсэгт заасан даатгалуудад мөн түүнд заасан хэмжээ, хугацаа, хасч тооцох зардал, хасалт, сунгалт болон бусад нөхцлүүдийн шаардлагын дагуу даатгуулж, Ажлын гүйцэтгэлийн явцад хүчин төгөлдөр байлгах үүрэг хүлээнэ. Гүйцэтгэгч нь бүх шаардлагатай даатгалуудад бүрэн даатгуулж, хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа нотолгоог Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

18.3. Гүйцэтгэгчийн ажилтны даатгал

18.3.1. Гэрээний 18.2-д заасан Гүйцэтгэгчийн хүлээх үүргээр хязгаарлагдахгүйгээр, Гүйцэтгэгч нь өөрийн болон түүний бусад ажилтны хөлсөлсөн этгээд бэртэж гэмтсэн, өвдсөн эсхүл амь нас эрсдсэнээс үүдсэн нэхэмжлэл, хохирол, алдагдал эсхүл зардалд (үүнд эрх зүйн холбогдолтой төлбөр, зардал багтана) хүлээх хариуцлагыг даатгуулж, хүчин төгөлдөр хэрэгжүүлэх ёстой.

АРВАН ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

19.1. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн тодорхойлолт

19.1.1. Энэ зүйлд, "Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлс" гэдгийг дараах гадны хүчин зүйл эсхүл нөхцөл байдал гэж ойлгоно:

- (a) Талуудын хяналтаас давсан;
- (b) Тухайн Талын энэхүү Гэрээг хийхээс өмнө мэдэх боломжгүй байсан;
- (c) Талын зайлсхийж эсхүл давж гарч чадаагүйн улмаас үүдсэн.

19.1.2. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлст дээр дурдсан нөхцлийг хангасан дор дурдсан гадны үйл явдал эсхүл нөхцөл байдал багтах хэдий ч үүгээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:

- (a) Дайн, (зарлагдсан эсхүл зарлагдаагүй) дайны байдал, халдлага, гадны дайсны үйл ажиллагаа;
- (b) Эсэргүүцэл, терроризмын ажиллагаа, хувьсгал, үймээн самуун, цэргийн эсхүл засгийн эрхийг булаах үйл ажиллагаа, иргэний дайн;
- (c) Үймээн самуун, тайван бус байдал, ажил хаялт, бослого эсхүл локаут;
- (d) Гүйцэтгэгчийн тухайн зэр зэвсэг, тэсэрч дэлбэрэх материал, цацраг эсхүл радио идэвхт бодисыг ашиглаж байгаагаас бусад дайны зэр зэвсэг, тэсэрч дэлбэрэх материал, ионжуулсан цацраг эсхүл радио идэвхт хаягдал;
- (e) Байгалийн гамшиг, тухайлбал газар хөдлөлт, далайн шуурга, хар салхи эсхүл галт уулын идэвхижилт;
- (f) Захиалагчийг гэрээний үүргээ биелүүлэх эсхүл төслийг үргэлжлүүлэх боломжгүй болгож буй Монгол Улсын эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр болон Монгол Улсын бусад хууль, тогтоомж. /энэхүү заалт нь Захиалагчийн эрх, үүрэг төрийн өмчит аж ахуй нэгжид шилжсэн (Төрийн өмчийн аж ахуй нэгж/ Монгол Улсын Засгийн газарт шууд ба шууд бус байдлаар бүрэн эсхүл бүрэн бус өмчлөгдөх) тохиолдолд хамаарахгүй/

Энэхүү гэрээ нь төрийн ботол албаны нууцанд хамаарах тул оор бусад этгээд хувиалж тархах, ийтийн хүртээл болгохыг зарилжыг. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливан этгээдэд хуульд заасны дагуу хариуцлагыг хүлээлгэх болно.
МТЗ ТӨХК "УБТЗ" ХНН

ИЛ БОЛСОН

19.1.3. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлст дараах үйл явдал эсхүл нөхцөл байдал хамаарахгүй (эсхүл эдгээрийн хавсарсан үйл явдал, нөхцөл болон бусад үйл явдал, нөхцөл). Үүнд:

- (a) Захиалагчийн шаардлагуудад заасан хүндрэлийн хязгаарлалтад багтах цаг агаарын нөхцөл байдал;
- (b) Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалаагүй үйлдэл, эс үйлдэл эсхүл алдаа;
- (c) Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалаагүй, ажиллах хүч эсхүл бараа материалын дутагдал;
- (d) Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалаагүй аль нэг Талын өмчийн эсхүл түүний ажиллуулж буй тоног төхөөрөмж, машин механизм, үйлдвэрийн механик эсхүл цахилгааны гэмтэл, доголдол;
- (e) Гэрээний дагуу авах ёстой зөвшөөрлийг Гүйцэтгэгч аваагүй;
- (f) Гүйцэтгэгчийн Талбай болон ажилтнуудад хамаарах эсхүл Улс орон дахь бусад бизнесийн байгууллагуудын ажилтнуудад материаллаг байдлаар нөлөөлөхгүй үйлдвэрийн маргааны нэг хэсэг болохооргүй ажил хаялт, бусад үйлдвэрийн саатал.


19.1.4. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагч хугацаанд нь хүлээн аваагүй бол ажлын үр дүн ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байсан ч гэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болох үр дагаврыг Захиалагч хариуцна.

19.2. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн талаарх мэдэгдэл

19.2.1. Хэрэв аль нэг Тал Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхэд саад учирч байгаа бол ("Өртсөн Тал"), нөгөө талд Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсэд хамаарах үйл явдал эсхүл нөхцөл байдлын талаар нөгөө талд мэдэгдэх бөгөөд ямар үүргийг биелүүлэхэд саад учирсныг тодорхой хэлнэ. Өртсөн тал холбогдох үйл явдал эсхүл нөхцөл байдал нь Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн шинжтэй болохыг мэдсэн эсхүл тодорхой болсны дараа 30 хоногийн дотор мэдэгдэл өгөх бөгөөд Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас тухайн мэдэгдлийг өгөх боломжгүй болсон бол Талууд хоорондоо мэдэгдэл өгөх боломжтой болсноос 14 хоногийн дотор мэдэгдэнэ. Өртсөн тал нөгөө Талд тухайн үйл явдлыг Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйл болох шалтгааныг тодорхой тайлбарласан хоёр дахь мэдэгдлийг өгөх бөгөөд хоёр дахь мэдэгдэлд дараах зүйлсийг тусгаж аль болох хурдан өгнө:

- (a) Үүргээ гүйцэтгэхэд нөлөөлж буй талаарх урьдчилсан үнэлгээ;
- (b) Өртсөн тал үүргээ гүйцэтгэх боломжгүй байх хугацааг урьдчилан тооцсон байдал;
- (c) Бусад холбогдох асуудал.

19.2.2. Гэсэн хэдий ч энэ хоёр дахь мэдэгдлийг Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлд өртсөн Тал эхний мэдэгдлийг өгснөөс хойш 14 хоногоос хэтрэхгүй өгнө.



ИЛ БОЛСОН

11.2011

19.2.3. Тохиромжтой эсхүл нөгөө тал хүсэлт гаргасан тохиолдолд, Өртсөн тал Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлд хамаарах үйл явдал, түүний шалтгааны талаар илүү тодорхой дүрсэлсэн мэдэгдлийг өгөх бөгөөд үүнд мөн Өртсөн тал үр нөлөөнөөс зайлсхийх эсхүл багасгахад зориулж буй хүчин чармайлт, мөн Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гүйцэтгэх боломжгүй болсон үүргийг биелүүлэхэд хүндрэл учрах хугацааны талаар сүүлийн үеийн мэдээлэл өгнө.

19.3. Саатлыг хамгийн бага болгох үүрэг

19.3.1. Тал тус бүр Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Гэрээний гүйцэтгэлд гарсан саатлыг хамгийн бага болгох бүх хүчин чармайлтыг гаргана.

19.3.2. Өртсөн тал Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн нөлөө зогссон даруйд энэ тухай нөгөө Талд мэдэгдэх бөгөөд түүнийг 30 хоногоос хэтрүүлэлгүй нөгөө талд мэдээлсэн байна.

19.4. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн үр дагавар

19.4.1. Хэрэв Гүйцэтгэгч Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр Гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд саад учирч, энэ тухай гэрээний 19.2 дахь заалтын [Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн талаар мэдэгдэл] дагуу мэдээлсэн бөгөөд тухайн Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас саатал гарсан бол, мөн хэрэв Урьдчилсан байдлаар хүлээн авах гэрээний 8.4 дэх заалтад [Хугацаа сунгалт] заасны дагуу хойшилсон бол Гүйцэтгэгч гэрээнд заасны дагуу тухайн саатлын хугацаагаар ажил гүйцэтгэх хугацааг сунгах эрхтэй байна.

19.4.2. Мэдэгдэл авсны дараа Захиалагч эдгээр асуудлыг хүлээн зөвшөөрч, тогтооход гэрээний 3.2 дахь заалтад [Шийдвэрүүд] заасны дагуу арга хэмжээ авна.

19.4.3. Гэрээний 19.1 болон 19.1.2-д зааснаар Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүнтэй холбоотой үүсэх гэрээний аливаа хариуцлагаас чөлөөлөгдөнө.

19.5. Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт



19.5.1. Гэрээг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас цуцлах тохиолдолд дараах төлбөрийг харилцан тохиролцож төлнө. Үүнд:

- (a) Гэрээнд заасан ажлын гүйцэтгэлд төлбөл зохих төлбөр;
- (b) Ажилд зориулж захиалан Гүйцэтгэгчид хүргүүлсэн эсхүл Гүйцэтгэгч хүргэлтийг нь хариуцсан Бараа материалын зардал
- (c) Ажлыг гүйцэтгэнэ гэж төлөвлөн Гүйцэтгэгчид учирсан аливаа нөхцөл байдалд хүлээх хариуцлага эсхүл бусад зардал;

19.5.2. Захиалагч нь гэрээний 19.5.1 дэх заалтын дагуу Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг цуцлахаас өмнө Гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэл өгч, дараах сунгалтыг хийж болно:

- (a) Гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр, сунгалтыг цааш үргэлжлүүлэх [нэг зуун наян (100) хоног];

Энэхүү гэрээ нь торийн болон албаны нүүцэл хамаарах тусгаар бусад этгээдээ хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдээ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

"МТЗ ТӨХК"  "УБТЗ" ХНН 

ИЛ БОЛСОН

НҮҮГЭ

(b) Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлс тохиолдсоны улмаас хугацааг сунгасан бол, Захиалагч гэрээний 19.5.1 дэх заалт хүчингүй болсноос эхэлж Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлс зогсох эсхүл гэрээний 19.5.1 дэх заалтад заасны дагуу Гэрээг цуцлах хүртэл сунгалтаас үүдсэн аливаа зардлыг Гүйцэтгэгчид гэрээний дагуу Гэрээний үнэд нэмж, нэмэлт төлбөр байдлаар төлнө.

ХОРЬ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

20.1. Маргаан шийдвэрлэх журам


20.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйтэй холбоотой маргаантай асуудал гарвал талууд асуудлыг эвийн журмаар шийдвэрлүүлэхээр нэг Талаас нөгөө Талд бичгээр мэдэгдэл хүргүүлж, мэдэгдлийн дагуу Талууд зөвшилцөлд хүрэх арга замыг бүх талаар эрэлхийлнэ.


20.1.2. Талууд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад асуудлыг уламжилж, дээд түвшинд шийдвэрлүүлэх арга хэмээ авна.

20.1.3. Аль нэг талын хүсэлтээр үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр хэдийд ч хөндлөнгийн Шинжээчид хандаж болно. Ийнхүү шинжээчид хандсан тал шинжээчийн зардлыг хариуцна. Шинжээч нь өмнө ба одоо аль нэг Талд ажиллаж байгаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй, холбогдох маргааны зүйлийг шинжлэн дүгнэлт гаргах мэдлэг, ур чадвартай. Талуудад хүлээн зөвшөөрөгдөхүйц мэргэжлийн бөгөөд мэргэшсэн хүн, хуулийн этгээд байна.

20.1.4. Энэ зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.3-т заасны дагуу маргааныг шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувицаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.
"МТЗ" ТӨХК "УБТЗ" ХНН





ИЛ БОЛСОН

29
НУУЦ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар
хот

ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, 9.1.1, 9.1.2, Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын 2.2, "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 2.2.3, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32, 2012 оны 07/04 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.2-т заасан эхний үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтэц, 3.2.4-т заасан 2 дахь үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц гэж үзсүгэй.

2. Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдол бүхий төмөр замын суурь бүтцийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах зорилгоор энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосугай.

3. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын I болон II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийг барих төслийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай хамтарсан

тусгай зориулалтын компани байгуулах замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батзаяа)-д даалгасугай.

4. 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдөр "Дорнын төмөр зам" ХХК болон "Монголиантранс Лайн" ХХК-тай байгуулсан "Сайншанд-Тавантолгой" чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг, "Энержи Ресурс" ХХК болон "Энержи Ресурс Рэйл" ХХК-тай байгуулсан "Ухаахудаг-Гашуунсухайт" чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг тус тус цуцлах арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан "Дорнын төмөр зам" ХХК болон "Монголиантранс Лайн" ХХК,



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН

ТОГТООЛ

ИЛ БОЛСОН

2013 оны 1 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Шинэ төмөр зам төслийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Концессын тухай хуулийн 6.1.2, Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


1. "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д заасан I, II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийн "барих-ашиглах-шилжүүлэх" концессыг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж санхүүжүүлэх, 2013 онд гүйцэтгэх 2 дугаар хавсралтад заасан ажлыг холбогдох журмын дагуу хянан баталгаажуулж санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д даалгасугай.

3. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан ажлыг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Засгийн газрын 2011 оны 266 дугаар тогтоолын дагуу олгохыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

4. Хөгжлийн банкны зээлийг эргэн төлөх хөрөнгийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

5. Шинэ төмөр зам төслийн ажлын явцын талаар Засгийн газарт сар бүр танилцуулж байхыг Зам, тээврийн сайд А.Гансүхэд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн сайд

Н.АЛТАНХУЯГ

А.ГАНСҮХ

Засгийн газрын 2013 оны 28 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**"ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО Д
ЗААСАН", И ҮЕ ШАТНЫ ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙГ БАРИХ АЖЛЫН
ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЖАГСААЛТ**

Монголбанкны ам.долларын ханш (2012/12/21) 1.391₮

ИЛ БОЛСОН

Ажил	Нийт дүн (мян.₮)	Нийт дүн (мян.\$)	Үндэслэл
Хээрийн судалгааны ажил (Деланзадгад- Чойбалсан 1.165 км)	12.297.188	8.838	
1 Геодези	5.892.676	4.235	"Монголын төмөр зам" ТӨХК, "Геомастер" ХХК-тай 2011 оны 3 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан 1/001 дүгээр гэрээ (Ажлын даалгаврыг БНБД 11-07-04 дагуу боловсруулсан)
2 Геологи	5.367.155	3.858	"Монголын төмөр зам" ТӨХК, "Экогидро гео" ХХК-тай 2011 оны 3 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан 1/002 дугаар гэрээ (Ажлын даалгаврыг БНБД 11-07-04 дагуу боловсруулсан)
3 БОНУ	1.037.357	746	"Монголын төмөр зам" ТӨХК, "Найчрал Састайнэблэ" ХХК-тай 2011 оны 3 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан 1/003 дугаар гэрээ
Туршилтын хөрс хуулалт (нийт 100 км)	10.005.421	7.191	
1 Хөрс хуулалт	5.156.131	3.706	"Монголын төмөр зам" ТӨХК, "Транскон" ХХК-тай 2011 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан 1/008 дугаар гэрээ
2 Хөрс хуулалт	4.849.290	3.485	"Монголын төмөр зам" ТӨХК, "Кэй Эйч Эн Ар" ХХК-тай 2011 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан 1/006 дугаар гэрээ
Урьдчилсан ТЭЗҮ	9.023.736	6.486	
1 Хаан банкны үндсэн зээл	7.861.014,50	5.650	ЗТБХБ-ын сайд, ТӨХ-ны даргын 30/24 дүгээр хамтарсан тушаал, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ТУЗ-ийн 23 дугаар шийдвэрийн дагуу "Маккинсэй" компанитай байгуулсан 2011 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн гэрээ болон ТӨХ-ны 2011 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 107 дугаар тогтоол, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2011 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 24 дүгээр тогтоолын дагуу "Хаан" банктай байгуулсан 2011 оны 3Г-11/108/03 дугаар гэрээ
2 Хаан банкны хүү	1.162.721	836	
	31.326.344	22.515	

ИЛ БОЛСОН

Засгийн газрын 2013 оны үйл ажиллагаа
тогтоолын 2 дугаар хавсралт

"ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО"-Д
ЗААСАН I, II ҮЕ ШАТНЫ ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙГ БАРИХ АЖЛЫН
ХҮРЭЭНД 2013 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

(мянган төгрөг)

Хээрийн судалгааны ажлын үргэлжлэл (Даланзадгад-Чойбалсан 1.165 км)		9.535.518
1	Геодези	166.933
2	Геологи	8.809.243
3	БОНУ	259.340
4	Археологи	150.000
5	Палеонтологи	150.000
Хээрийн судалгааны ажил (Хөөт-Бичигт 230 км)		4.251.092
1	Геодези	1.196.318
2	Геологи	2.798.774
3	БОНУ	256.000
Зөвлөх үйлчилгээ		31.513.625
1	Техникийн зөвлөх (Техникийн зураг төсөл боловсруулах, FEED)	20.869.950
2	Хуулийн зөвлөх	6.260.985
3	Санхүүгийн зөвлөх	3.060.926
4	Менежментийн зөвлөх	1.321.764
Нийт дүн		45.300.232



ИЛ БОЛСОН

НУУЦ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.1, 23.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1, Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.2.1, Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг үйлдлийн, хүүгүй, 20 хүртэл жилийн хугацаатай 750.0 (долоон зуун тавин) тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хяалтгай хүрээнд худалдахаар гаргах зөвшөөрлийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгохыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Р.Мэргэн)-д тус тус даалгасугай.

2. "Монголын төмөр зам" ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр ил, гүүр, төмөрлэлтийн төлбөрөөс суутгах зэрэг эргэн төлөх нөхцөлөөр Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас худалдан авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д даалгасугай.

3. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн үндэслэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх зорилгыг судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартаар чанарын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Төрийн хөгжлийн сайд
УХА0064

У.ХҮРЭЛСҮХ
Б.ЭНХ-АМГАЛАН

ИЛ БОЛСОН



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 5 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 53


Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- Дарга - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэл дарагч - Зам, тээврийн хөгжлийн сайд ✓
- Гишүүд:
 - Сангийн сайд;
 - Батлах ажилсаглахын сайд;
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд;
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;
 - Барилга, хот байгуулалтын сайд;
 - Эрчим хүчний сайд;
 - Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга;
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга;
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; ✓
 - Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
 - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга;
 - Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга; ✓

ИЛ БОЛСОН




Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлж, тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий Ажлын хэсэг дараахь чиглэлийг баримтлан ажиллана:

1. "Монголын төмөр зам" ТӨХК-иас үнэт цаас гаргах, гаргасан үнэт цаасыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК нэрлэсэн үнээр нь худалдан авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрдүүлэх;
2. Төмөр замын барилгын ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулах;
3. Тус чиглэлийн төмөр замын шугамын чигийн зарим хэсгийг шинэчлэн тогтоож, бүтээн байгуулалт хийгдэх газрыг үлдсэн тусгай хэрэгцээнд авах, төмөр замын дурвас газарт дахин байгаа эсэхийг тогтоож, чөлөөлөх арга хэмжээ авах, түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;
4. Төслийн техникийн адийн засгийн үндэртэл, инженерийн тооцоо, ертвийн төсөлд холбогдох аурс төслийн магадлалыг хасагчлан хийлгэх, барилгын ажлыг тасралтгүй шуурхай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;
5. Археологи, палеонтологийн нэмэлт судалгаа болон олдворыг хамгаалах ажлыг хийлгэх;
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, холбогдох шинжилгээ, дүгнэлтийг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулах;
7. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхэд шаардагдах усны хайгуулын судалгаа, өрөмдлөг, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын судалгааны худалдан авалтыг яаралтай зохион байгуулах;
8. Төсөлд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал, ус ашиглалтын төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
9. Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг цаг алдалгүй эхлүүлэх, барилгын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын уялдааг хангаж ажиллах;
10. Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай үлдэгдэл хөрөнгийг Сангийн яам, Монголбанкны дэмжлэгээр дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх;



ИЛ БОЛСОН МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
Ц. Ш А А Л

2016 оны 8 сарын 27 өдөр

Улаанбаатар хот.

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дэхь хэсэгт заасныг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Тавантолгой-Зуунбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулж, баримтлах удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

Дарга:

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга А.Ганбат

Гишүүд:

Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ц.Батаул;

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шигшмэлгээ, үнэлгээ, Дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхболд;

Тэгшүүлын ерөнхий газрын Эдийн засгийн аюулгүй байдлын газрын дарга Д.Баясгалан;

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дэд бөгөөд Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Ц.Ням-Очир;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Мэдээллийн технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу;

Авлигатай тэмцэх газрын Ахлах комиссар Э.Батбаяр /Зөвлөлдсөн бэр/.

Нарийн бичгийн дарга

Монголын төмөр зам ТӨХК-ийн Хуулийн хэлтсийн дарга Р.Бямбаа

ИЛ БОЛСОН

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2019 оны 7 дүгээр тушаалын хавсралт

ТАВАНТОЛГОЙ ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ
ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсэг дараахь удирдамжийг баримтална:

1. Худалдан авах ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулахад анхаарч ажиллах;
2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
3. Төмөр замын барилгын ажлын захиалагч болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах буюу өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг захиалагч, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс гаргуулж Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсэгт танилцуулах;
4. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-д тусгагдсан барааг эхний ээлжинд худалдан авах зарчим баримтлах;
5. Худалдан авах ажиллагаанд оролцохоор санал ирүүлсэн этгээд нь өөрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан ерөнхий нөхцөл, санхүүгийн болон техникийн чадавхи, үршлэгийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
6. Худалдан авах ажиллагаанд оролцохоор ирүүлсэн санал болон үйлчилгээний хорооны шийдвэр, дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл өгөх, гарсан зөрчлийг арилгуулах;
7. Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичиг, материалтай үйлдэж хянах, зөвлөх, дэмжлэг үзүүлэх;
8. Захиалагч худалдан авах ажиллагаа бүрээр хавтаст хэрэг бүрдүүлж, үйлдэж хянаж болгон хадгалж байгаа эсэхэд хяналт тавих.



ИЛ БОЛСОН МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
Т У Ш А А Л

Улаанбаатар хот

2019 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 53

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт
заасныг үндэслэн ТУШААХ нь:

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны
44 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн
төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах
ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах,
хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн удирдамж"-д дараахь өөрчлөлт
оруулсугай:

1/"Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын
ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага,
зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд
ажлын хэсгийн удирдамж"-ийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

"2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,
үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д заасныг баримтлан
худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион
байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;"

2/Мөн удирдамжийн 6 дахь заалтын "Үнэлгээний хорооны" гэснийг "Сонгон
Шалгаруулах, худалдан авах ажлын хэсгийн" гэж өөрчлөх.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0000142

ИЛ БОЛСОН



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, баримтлах удирдамжийг хавсралт ёсоор баталсугай:

Дарга:

Д.Ганзориг Зэвсэгт хүчний жанжин штабын дарга /зөвшилцсөнөөр/

Гишүүд:

Ц.Батзул Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/;

М.Энхболд Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч;

Д.Баясгалан Тагнуулын ерөнхий газрын Эдийн засгийн аюулгүй байдлын газрын дарга /зөвшилцсөнөөр/;

Ц.Ням-Очир Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дэд бөгөөд Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга /зөвшилцсөнөөр/;

Н.Цэрэнсамбуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Мэдээллийн технологийн албаны дарга /зөвшилцсөнөөр/;

Э.Батбаяр Авлигатай тэмцэх газрын Ахлах комиссар /зөвшилцсөнөөр/.

Нарийн бичгийн дарга:

Б.Энэрэлт "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/

ИЛ БОЛСОН

17
Зам, төөрийн хөгжлийн сайдын
2019 оны 12 дугаар сарын
өдрийн 213 дугаар тушаал
ногдуулар хавсралт

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсэг дараахь удирдамжийг баримтална:

1. Худалдан авах ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулахад анхаарч ажиллах;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д заасныг баримтлан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
3. Төмөр замын барилгын ажлын захиалагч болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах буюу өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг захиалагч, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс гаргуулж Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсэгт танилцуулах;
4. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-д тусгагдсан барааг эхний ээлжинд худалдан авах зарчим баримтлах;
5. Худалдан авах ажиллагаанд оролцохоор санал ирүүлсэн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан ерөнхий нөхцөл, санхүүгийн болон техникийн чадавхи, туршлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
6. Худалдан авах ажиллагаанд оролцохоор ирүүлсэн санал болон Сонгон шалгаруулах, худалдан авах ажлын хэсгийн шийдвэр, дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл өгөх, гарсан зөрчлийг арилгуулах;
7. Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичиг, материалтай танилцаж хянах, зөвлөх, дэмжлэг үзүүлэх;
8. Захиалагч худалдан авах ажиллагаа бүрээр хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байгаа эсэхэд хяналт тавих;
9. Ажлын хэсгийн гишүүд ажил үүргийн хүрээн дэх мэдээллийг нийтэд мэдээлэхгүй байхад анхаарч ажиллах.



ИЛ БОЛСОН

НУУЦ

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ"
ТӨХЖ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Р.БАТСҮХ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267166, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrtд.gov.mn, http://www.mrtд.gov.mn

2019-12-02 № 01/6353

танай _____-ны № _____-т


Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 10 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар ээлжит хуралдаанаас өгсөн үүргийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлын дээд бүтэц /зам төмөр дэрийн сараалж, буталмал чулуун чигжээс буюу балласт, суман шилжүүлэг, дохиолол холбоо, эрчим хүч, шилэн кабел, гүүр/-ийн ажлуудыг "Улаанбаатар төмөр зам" ХНН-ээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.

Иймд дээр дурьдсан ажлуудтай холбоотой одоо хийгдсэн болон дутуу үлдсэн зураг төсөв, гэрээ, худалдан авах ажиллагаа зэргийг дуусгавар болгож, цаашид дээд бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг "Улаанбаатар төмөр зам" ХНН-тэй байгуулж 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн дотор хариу мэдэгдэнэ үү.


Хувийг: "УБТЗ" ХНН-т

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

Ургамал, Ганзориг, Батсүх
МРТД



НУУЦ


ИЛ БОЛСОН

ХАВСРАЛТ -2
ОГ 120/042

2007-07-08

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Энэхүү гэрээ нь иргэйн болон алианы үүснэгт хамсаарайх түүх дээр бүхэд энгэрдээ хувилж тараах, нийтийн хурт тээгдэг бөгөөд хэргийн үйлдэл Энэ шаардлагаг биед; үүснэгт ашигтай энгэрдээ хуульчид хамтаар хариуцаж хуульчид бодол.

МТЗ ТӨХК


"УБТЗ" ХНН.....



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ**

16051 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Сөүлийн гудамж-42, Утас: 24-23-70, Факс: 24-30-44,
и-мэйл: ubtz@ubtz.mn

2023.10.12

№ 84/3655

танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

"Улаанбаатар төмөр зам" ХНН болон "Монголын төмөр зам" ТӨХК-ийн хооронд байгуулсан 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан ОГ/20/042 тоот Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, гүүр хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх гэрээг байгуулж ажилласан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1км төмөр зам барих төслийг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар шийдвэрээр байгуулагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг хийж 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 2023/008 тоот барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулсан.

Иймд ОГ/20/042 тоот гэрээг холбогдох дүрэм, журмын дагуу дүгнэх шаардлагатай тул гэрээг дүгнэх актыг төслийг хүргүүлж байна. Судлан үзэж зохих саналыг ирүүлж хамтран ажиллана уу.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

1601235989